

# ҮНДСЭН ТАЙЛАН

---

Айлд ГЭРИЙН ҮЙЛЧЛЭГЧ ХИЙЖ БАЙГАА  
ХүүХДҮҮДИЙН СУУРЬ СУДАЛГАА

Санхүүжүүлэгч:

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага,  
АЙПЕК хөтөлбөр

Гүйцэтгэгч:

Монгол Улсын Их Сургууль,  
Хүн Амын Сургалт Судалгааны Төв

Улаанбаатар хот, 2005 он

## ТАЛАРХЛЫН ҮГ

Сүүлийн жилүүдэд Монголд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар нэлээд судалгаа шинжилгээний ажлууд хийгдсэн боловч айлд гэрийн үйлчлэгч болон мал маллаж буй өвөрмөц хэлбэрийн хөдөлмөрийг цогц байдлаар судалсан судалгаа, шинжилгээний ажил хараахан хийгдээгүй байна.

Иймд айлд гэрийн үйлчлэгчийн болон мал маллах ажил хийж байгаа хүүхдийн хөдөлмөрийн шинж, нөхцөл байдал болон хот, хөдөөгийн гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн бодит ялгааг судлах зорилгоор “Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн суурь судалгаа”-г Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын АЙПЕК хөтөлбөрийн захиалга, санхүүжилт, техникийн тусламж, дэмжлэгтэйгээр МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн Хүн Амын Сургалт Судалгааны Төв (ХАССТ)-ийн багш, судлаачид хийж гүйцэтгэлээ.

Судалгааны түүвэрлэлтийг хот, хөдөөд хоёр өөр аргаар хийсэн. Хоёр шатад түүврийн аргыг Улаанбаатар хотод, гурван шатат түүврийн аргыг хөдөөгөөс сонгогдсон гурван аймагт ашиглав. Нийт 360 хүүхэд, айлд хүүхдээ ажиллуулж буй 168 эцэг эх, 166 ажил олгогчид түүвэрлэлтэд хамрагдлаа.

Судалгааны загвар, агуулга боловсруулахад техникийн туслалцаа үзүүлсэн АЙПЕК хөтөлбөрийн Бангкок дахь суурь судалгааны мэргэжилтэн Санжугта Мухаржид ХАССТ-ийн хамт олон гүн талархал илэрхийлж байна. Судалгааны олон үе шатуудад түүний үзүүлсэн техникийн туслалцаа, мэргэжлийн үнэтэй санал зөвлөмжид ХАССТ баяртай байна.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн асуудлыг хөндөж тавьсан, мөн судалгааны үр дүнгийн тайланд үнэтэй санал, зөвлөмж өгсөн АЙПЕК хөтөлбөрийн Монгол дахь зохицуулагч Н. Монголмаад чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн АЙПЕК хөтөлбөрийн Бангкок дахь ажилтан хатагтай Аяака Мацунод судалгааны үр дүнгийн тайланд үнэтэй санал, зөвлөмжид өгсөнд судалгааны багийн хамт олон гүнээ талархаж байна.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн суурь судалгааг амжилттай явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлсэн болон судалгааны асуулга боловсруулахад санал, зөвлөмж өгсөн бүх байгууллага, хамт олонд тодруулбал, Улаанбаатар хот, орон нутгаас судалгаанд хамрагдсан иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, судалгааг явуулах багт ярилцлага авагчаар оролцсон МУИС-ийн Эдийн Засгийн сургуулийн оюутнуудад ХАССТ баярласан талархснаа энэ ялдамд уламжилж байна. Эцэст нь, судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй болон айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй бүх хүүхдүүдэд цаг зав гарган, хувийн санал бодлоо хуваалцсан явдалд судалгааны багийн хамт олон чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Ì ÖÈÑ-èéí Öçí Àì ûí Ñóðääàëö Ñóäàëäàí û Ö°âèéí õàì ò íéïí

## АГУУЛГА

Oóóäàñ

<b>БҮЛЭГ 1.</b>	<b>Удиртгал</b>	4
<i>Аёäààäèéí Ñîëîíäî</i>		
1.1	Үндэслэл	4
1.2	Судалгааны зорилго	4
1.3	Илтгэлийн бүтэц	5
<b>БҮЛЭГ 2.</b>	<b>Судалгааны арга зүй</b>	6
<i>Äààòåðæäàäûí Í àðäí òóëäà</i>		
2.1	Тандалтын судалгааны арга зүй	6
2.2	Тоон судалгааны арга зүй	7
2.2.1	Түүвэрлэлт	7
2.2.2	Судалгааны үр дүнг ашиглан эх олонлогийг тодорхойлох нь	11
2.2.3	Асуулгын хуудас	12
2.2.4	Мэдээлэл цуглуулалт	13
2.2.5	Мэдээлэл боловсруулалт	12
2.2.6	Судалгааны хязгаарлагдмал байдал	13
2.3	Чанарын судалгааны арга зүй	13
<b>БҮЛЭГ 3.</b>	<b>Улаанбаатар хотод айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүд</b>	14
<i>Ööï °ðòîéäéí Í àðä-</i>		
3.1	Айлд гэрийн үйлчлэгч хийж буй хүүхдүүдийн шинж байдал	14
3.1.1	Хүн ам зүйн шинж байдал	14
3.1.2	Сургуульд хамрагдалт ба бичиг үсгийн мэдлэг	15
3.1.3	Шилжих хөдөлгөөн	18
3.1.4	Ар гэрийн байдал, амьдралын нөхцөл	20
3.2	Өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт	24
3.2.1	Анхны ажил эрхлэлт	24
3.2.2	Одоогийн ажил эрхлэлт	28
3.2.3	Ажлын үргэлжлэх хугацаа ба амралт	31
3.3	Хөдөлмөрийн хөлс ба зарцуулалт	35
3.4	Хөдөлмөрийн харилцаа ба хүүхдүүдэд тохиолдож буй бэрхшээл	38
3.5	Хүүхдийн эрүүл мэнд ба хөдөлмөр хамгаалал	42
3.6	Дадал зурсил ба чөлөөт цаг	45
3.6.1	Муу дадал, зурсил	45
3.6.2	Мэдлэг хандлага, ирээдүйн хүсэл эрмэлзлэл	47
<b>БҮЛЭГ 4.</b>	<b>Хөдоод айлд мал маллаж, гэрийн үйлчлэгчийн ажил хийж байгаа хүүхдүүд</b>	52
<i>Ääààäèéí Ñîëîíäî</i>		
4.1	Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн шинж байдал	52
4.1.1	Хүн ам зүйн шинж байдал	52
4.1.2	Асран хамгаалагчийн хараа, хяналт	53
4.1.3	Иргэний бичиг баримт, эрүүл мэндийн даатгалд хамрагдалт	56
4.1.4	Бичиг үсгийн мэдлэг ба сургуульд хамрагдалтын түвшин	57
4.2	Айлд мал маллаж буй хүүхдүүдийн өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт	61
4.2.1	Өнгөрсөн үеийн ажил эрхлэлт	61
4.2.2	Одоогийн ажил эрхлэлт	64
4.2.3	Ажлын цаг	69
4.2.4	Хөдөлмөрийн харилцаа ба түүний зохицуулалт	73
4.2.5	Айлд ажиллаж буй малчин хүүхдүүдийн тархалтын байдал	76
4.3	Эрүүл мэнд ба хөдөлмөр хамгаалал	78
4.3.1	Эрүүл мэндийн байдал ба эмнэлгийн тусламж, үйлчилгээ	78
4.4	Хүүхдийн чөлөөт цаг ба хүсэл тэмүүлэл	81

<b>БҮЛЭГ 5.</b>	<b>Гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж буй хүүхдүүдийн эцэг/эх</b>	86
<i>Ааðöýí ãýëëéí I ॐðæàðääëë</i>		
5.1	Судалгаанд хамрагдсан эцэг/эх, тэдний өрхийн гишүүдийн шинж байдал	86
5.1.1	Гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн өрхийн гишүүдийн шинж байдал	86
5.1.2	Гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн эцэг/эхийн шинж байдал	88
5.2	Судалгаанд хамрагдагчдын ахуйн нөхцөл	89
5.3	Судалгаанд хамрагдагчдын орлого	91
5.4	Нийгмийн үйлчилгээ хүртэх боломж	96
5.5	Хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийн талаарх эцэг/эхийн бодол	97
5.6	Хүүхдийн ирээдүйн талаарх эцэг/эхийн үзэл бодол	101
<b>БҮЛЭГ 6.</b>	<b>Гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж буй хүүхдүүдэд ажил олгогчид</b>	106
<i>Ааðàððæàðäüí I àðäí ñðéëà</i>		
6.1	Судалгаанд хамрагдсан ажил олгогчид, тэдний өрхийн гишүүдийн шинж байдал	106
6.1.1	Ажил олгогчдын өрхийн гишүүдийн шинж байдал	106
6.1.2	Ажил олгогчийн шинж байдал	108
6.2	Ажил олгогчийн зүгээс хүүхдийн ажлыг үнэлж буй байдал	112
6.2.1	Хүүхдийн ажлын хөлс/урамшуулал	112
6.2.2	Хүүхдийн ажлыг үнэлж буй байдал	118
<b>ЕРӨНХИЙ ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>		122

## **БҮЛЭГ 1. УДИРТГАЛ**

### **1.1 Үндэслэл**

Монгол улс 1990-ээд оноос хойш зах зээлийн харилцаанд шилжсэнтэй холбоотойгоор нийгэмд гарсан сөрөг үзэгдлүүдийн нэг бол хүүхдийн хөдөлмөр эрхлэлт юм. Хүүхдүүд хөдөлмөр эрхэлснээр тэдний сурч боловсрох, эрүүл аж төрөх, амьдралын баяр, баясгалан эдлэх зэрэг үндсэн эрхүүд зөрчигдэж байна.

Хүүхдийг ажил хөдөлмөрт сургах уламжлал, зан заншил манайд байдаг ч ядуурал газар авч, хямд ажиллах хүчийг ажиллуулах сонирхол бий болж байгаагаас хүүхдүүд эдийн засгийн үйл ажиллагаанд илүүгэй татагдан орж байна. Сургуульд суралцах боломж, бололцоо тааруу, ядуу өрхийн хүүхдүүд орлого олж, амьжираагаа залгуулах зорилгоор ажил хийх нь түгээмэл байна<sup>5</sup>.

Хүүхдүүд гар дээрээс худалдаа хийх, гутал тослохоос эхлээд ачаа зөөх, албан бус аргаар алт олборлох, хог хаягдал цуглуулах зэрэг *ОАА-І, Հéёäáýðéýé, őöäàéäàà* *շéё÷éëäýýéé* бараг бүхий л ажлуудад оролцож байна. Үүний сацуу хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, цар хүрээ нэмэгдэхийн хэрээр тэд өөр айлд *áýðééí* *շéё÷éýä÷ééí* ажлыг ил болон далд байдлаар хийх үзэгдэл Монголд хэдийнээ бий болжээ.

Харин хот, хөдөөгийн айлд гэрийн үйлчлэгчийн ажил эрхэлж буй хүүхдүүдийн бодит нөхцөл байдал нэлээд ялгаатай юм. Тухайлбал, хотод гэрийн үйлчлэгч хийж буй хүүхдүүд ганцаарлагдмал, нуугдмал байдалд байхад хөдөөд айлд мал маллаж буй хүүхдүүд айлын малыг нь маллахын зэрэгцээ тухайн айлын гэр орны өдер тутмын бүхий л ажлуудад гар бие оролцож байх жишээтэй. Мал маллах болон гэрийн үйлчлэгчийн ажлыг хүүхдүүдийн өөрийн гэртээ хийж байна уу эсвэл өөр айлд хийж байна уу гэдгийг нарийн зааглах нь чухал юм. Хүүхдээ айлд ажиллуулж буй эцэг эхчүүд хүүхдийнхээ суурь боловсролд төдийлэн анхаарахгүй байна. Хөдөөгийн сургуульд сурч буй хүүхдүүд голдуу дотуур байранд амьдардаг ч долоо хоногийн амралтын өдрүүдээр айлд мал маллах, гэрийн үйлчлэгчийн ажлуудыг хийж байна. Харин зуны амралтаар тэд бүтэн цагаар мал маллах, гэрийн үйлчлэгчийн ажлуудыг хийдэг. Хөдөөгийн дэд бүтцийн хөгжил сүл дорой байгаа нь ийм ажил хийж буй хүүхдүүд сургуульдаа тасралтгүй суралцах боломжийг (ялангуяа хөдөөгийн алсдагдсан багт ажиллаж буй хүүхдүүдийн хувьд) хязгаарлаж байна.

Сүүлийн жилүүдэд Монголд хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар нэлээд судалгаа шинжилгээний ажлууд хийгдсэн боловч гэрийн үйлчлэгч болон айлд мал маллаж буй энэхүү өвөрмөц хэлбэрийн хөдөлмөрийг цогц байдлаар судалсан судалгаа, шинжилгээний ажил хараахан хийгдээгүй байна.

### **1.2 Судалгааны зорилго**

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн асуудлаар Монголд өмнө нь судалгааны ажил хийгдээгүй, энэ талаархи мэдлэг бараг байхгүй байв. Энэхүү судалгааны үндсэн

<sup>5</sup> Үндэсний Статистикийн Газар, 2004. “Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан”, Улаанбаатар

зорилго нь Улаанбаатар хот болон хөдөөгийн сонгосон турван аймагт айлд гэрийн үйлчлэгчийн ажил хийж байгаа хүүхдүүдийн тоо хэмжээг тодорхойлох анхдагч мэдээлэл цуглуулахад оршиж байв. Судалгааны үр дүнд хот, хөдөөд гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй хүүхдийн бодит ялгааг харуулсан. Энэхүү судалгаагаар дараах үндсэн асуудлуудыг дэвшүүлэн тавьсан юм. Үүнд:

- Гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж буй хүүхдүүдийн шинж байдал, ажлын нөхцөл, ажлын үнэлэмж, хөдөлмөр хамгааллын асуудлуудыг тодорхойлох;
- Хотод гэрийн үйлчлэгч, хөдөөд айлд мал маллаж буй хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдалд гарч буй ялгаа, хүндрэл бэрхшээлүүдийг илрүүлж, харьцуулах;
- Ажил олгогч болон хүүхдээ айлд ажилшуулж буй эцэг эхийн байр, суурь хандлагыг тодорхойлох;

### 1.3 Илтгэлийн бүтэц

Илтгэлийг дараах бүтэцтэй бэлтгэлээ. Илтгэл нь хураангуй хэсгээр эхлэх ба энд судалгааны гол үр дүнг товчхон танилцуулсан болно. Бүлэг 1-д судалгааны үндэслэл, зорилго, зорилтуудыг, Бүлэг 2-д судалгааны арга зүй аргачлалыг тодорхойлж өгөв. Бүлэг 3-д айлд гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй хүүхдүүдийн шинж байдал, хөдөлмөрийн нөхцөл, ажлын ачаалал, цалин хөлс, хөлс төлөлгтийн хэлбэр, хэмжээ, зарцуулалт, цаашлаад хүүхдүүдэд тохиолдож хүндрэл бэрхшээлүүдийг тодорхойлсон болно. Харин Бүлэг 4-д айлд мал маллаж буй хүүхдүүдийн хувьд дээрх асуудлыг авч үзснээс гадна айлын малыг маллахаас гадна малчин өрхийн гэр орны өдөр тутмынх нь ажилд хүүхдүүд хэр оролцоотой байгааг дэлгэрэнгүй авч үзлээ. Бүлэг 5-д айлд хүүхдээ айлд ажилшуулж буй эцэг эхийн байр суурь, хандлагыг, Бүлэг 6-д ажил олгогчдын шинж байдал, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаархи хандлага, байр суурийг тус тус хөндөж тавив. Төгсгөлд нь судалгааны гол үр дүнд үндэслэсэн бодлогын зөвлөмжийг санал болгосон болно.

## **БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

Өөрийн өрхөөс гадуур, өөр айлд гэрийн ажил хийж буй хүүхдүүд олон нийтийн хараанаас далд ажилладаг. Хэдийгээр Олон Улсын хөдөлмөрийн Байгууллагын 182-дугаар Конвенциор гэрийн ажлыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдэд шууд тооцоогүй боловч Конвенцид тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх эрсдэлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, уг Конвенцийг дагалдан гарсан 190-р Зөвлөмжид “охид илүү эрсдэлд орж болох ажлын далд нөхцөлүүдэд анхаарлаа хандуулах шаардлагатайг” заасан байдаг.

Хүүхдийг гэрийн үйлчлэгчээр ажиллуулдаг практик Азийн улс орнуудад нэлээд тархсан байдаг бөгөөд судалгаанаас үзэхэд гэрийн үйлчлэгчийн ажил нь хамгийн доод үнэлгээтэй, олон цагаар, амралтгүй хийгддэг, хүүхдүүд бага наснаасаа татагдан ордог, ажиллаж буй айлдаа амьдарч ажилладаг хүүхдүүдийн хувьд ажил олгогчийн байнгын хяналт дор байдаг тул эрх чөлөө нь хязгаарлагдах, тоглох, сурх, бусадтай харилцах, найз нөхөнтэй байх зэрэг хүүхдийн эрх нь зөрчигдөх, охидын хувьд бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байх зэргээр хийж буй ажил нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй нөхцөл рүү орох эрсдэл өндөртэйг тэмдэглэсэн байдаг.

Энэхүү судалгаагаар “Тэрийн үйлчлэгчээр ажиллаж буй хүүхэд” (цаашид *аүдэээй үеё-еёй* гэнэ) гэсэн ойлголтонд бид 6-17 насны, өөрийнхөө гэрээс өөр өрхийн гэрийн ажилд хөлстэй болон хөлсгүйгээр тусалж/ажиллаж байгаа хүүхдүүдийг хамруулсан. Тухайн ажиллаж буй өрхдөө бүр болон түр хугацаагаар амьдардаг, эсвэл амьдраагүй боловч өрхийн өдөр тутмын ажилд (гэр цэвэрлэх, хүүхэд асрах, ус түлээ бэлтгэх, гэр сахих гэх мэт) оролцдог хүүхдүүдийг гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй хүүхдүүдэд хамааруулан авч үзсэн болно. Судалгаанд Улаанбаатар хотод гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй нийт 90 хүүхэд хамрагдсан.

Монголын хөдөө орон нутгийн эдийн засаг, хүн амын амьжирагаанд нүүдлийн мал аж ахуй чухал байр суурь эзэлдэг учраас хөдөө амьдарч буй хүүхдүүд мал аж ахуйн ажлын зэрэгцээ гэр орны өдөр тутмын ажилд оролцдог. Хөдөөд өөр айлд гэрийн ажлыг нь хөлсөөр хийж буй хүүхдүүд ч мал маллах ажилд оролцдог, эсвэл малыг нь маллаж буй хүүхдүүд гэрийн ажлыг нь мөн амжуулдаг. Тиймээс хөдөөд гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй хүүхдүүдийг судлахад айлд мал маллаж буй хүүхдүүдээс салган судлах аргагүй юм. Судалгаагаар хөдөө айлд мал маллаж буй хүүхдүүдийг гэрийн үйлчлэгчийн ажил хийж буйд тооцох зорилго агуулаагүй боловч срөнхийдөө айлд ажиллаж буй хүүхдүүдийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилго тавьсан юм. “Тэрийн үйлчлэгчийн судалгаа”-нд хөдөөгийн баг, сумын төвөөс байнга болон улирлын чанартайгаар мал маллах ажилд оролцдог нийт 270 хүүхэд хамрагдсан.

“Тэрийн үйлчлэгч хүүхдүүдийн суурь судалгаа”-нд мэдээлэл цуглуулах тоон болон чанарын арга зүйг тус тус ашигласан.

### **2.1. Тандалтын судалгааны арга зүй**

Улаанбаатар хотын хэмжээнд гэрийн үйлчлэгчтэй өрхүүдийн талаарх судалгаа, тоо мэдээлэл дутагдалтай байгаа учраас түүвэрлэлт хийхэд шаардлагатай мэдээллийг

цуглуулах, түүвэрлэлтийн гол параметрийг тодорхойлох зорилгоор 2004 оны 9 сарын 2-13-ны өдрүүдэд тандалтын судалгааг гэр болон байшин хорооллын төлөөлөл болгон Сонгинохайрхан дүүргийн 8, Сүхбаатар дүүргийн 7-р хороодод тус тус явуулсан.

Хүснэгт 2.1-д тандалтын судалгааны хамралтын хүрээг харуулав.

#### *Одийн үзүүлэлт 2.1. Тандалтын судалгааны хамралтын хүрээ*

Дүүрэг	Сонгогдсон дүүрэг	Сонгогдсон дүүргийн нийт хорооны тоо	Сонгогдсон хороо	Сонгогдсон хорооны төрөл	Сонгогдсон хорооны нийт өрхийн тоо	Сонгогдсон өрхийн тоо	Гэрийн үйлчлэгчтэй өрхийн тоо
Баянгол							
Баянзүрх	Сонгинохайрхан	21	8 дугаар хороо	Гэр	1422	143	9
Сонгинохайрхан							
Сүхбаатар							
Хан-Уул	Сүхбаатар	16	7 дугаар хороо	Байшин	2108	142	5
Чингэлтэй							
<b>Бүгд</b>	<b>2</b>	<b>37</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>3530</b>	<b>285</b>	<b>14</b>

Үзүүлэлт: ОААННО, “Айдэээй үзүүлэлтэй үзүүлэлт”-ийн Одийн үйлчлэгчтэй өрхүүд байгаа бөгөөд тус статистикийг Улаанбаатар хотын түүвэрлэлтэнд ашиглав.

## 2.2. Тоон судалгааны арга зүй

### 2.2.1 Одийн үйлчлэгчтэй өрхүүд

Энэхүү судалгааны түүвэрлэлтийг хийхдээ Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт ялгаатай арга зүйг ашиглав.

#### A. Улаанбаатар хотын түүвэрлэлтийн хүрээ:

Одийн үйлчлэгчтэй өрхүүдийн хувь

Судалгаанд Улаанбаатар хотоос хэдэн өрх хамруулахыг дараах томъёоны тусламжтай тодорхойлов.

$$n = t^2 p(1-p)/\alpha^2, \quad \text{Энд: } n - \text{Түүвэр олонлогийн хэмжээ}$$

α- Түүврийн алдаа

p- Гэрийн үйлчлэгчтэй өрхийн хувийн жин

t - Итгэх түвшний утга

Түүвэр судалгааны алдааг 5 хувь, итгэх түвшний утгыг 5 хувь байхаар сонгож, тандалтын судалгааны үр дүнд үндэслэн түүвэр олонлогийн оновчтой хэмжээг тодорхойлж бол 72 өрх болно. Бид түүврийн бус алдааг тооцож үзсэнээр эх олонлогоос гэрийн үйлчлэгчтэй 90 өрхийг энэхүү түүвэр судалгаанд хамруулсан. Судалгаанд

хамрагдсан өрхүүдийн ялгаатай шинж чанарыг авч үзэх зорилгоор хэсэг бүрээс хамгийн ихдээ 5-6 өрхийг хамруулахад нийт 16 хэсгийг судалгаанд хамруулах шаардлагатай юм.

### *Ӧёààí áààòàð õî òûí Ӧ݂݂âýðëéòèéí çàâààð*

Улаанбаатар хотын хэмжээнд түүвэрлэлтийг хийхдээ хоёр шатат энгийн санамсаргүй түүвэрлэлтийн загварыг ашигласан. Түүвэрлэлтийн эхний шатанд Улаанбаатар хотын 6 дүүргийн<sup>6</sup> 109 хорооны 1102 хэсгээс санамсаргүйгээр 16 хэсгийг сонгосон. Ийнхүү сонгоходо тус хотын гэр болон байшин хорооллын харьцаанд үндэслэн 16 хэсгийн 60 хувь нь гэр, 40 хувь нь байшин хэсэг байхаар буцаалттай энгийн санамсаргүй түүвэрлэлтийг хийлээ.

Харин хоёр дахь шатанд эхний шатанд сонгогдсон 7 байшин, 9 гэр хэсэг дэх өөр айлын хүүхэд ажиллуулж буй бүх өрхүүдээс санамсаргүйгээр түүвэр олонлогийн оновчтой хэмжээтгэй тэнцүү тооны (90 өрх) өрхийг сонгож, тухайн өрхөд ажиллаж буй гэрийн үйлчлэгч хүүхдийг судалгаанд хамруулсан юм.

### Б. Хөдөө орон нутгийн түүвэрлэлтийн хүрээ:

### *Ӧoäoo Ӧđíí Ӧóàààñ Õõíàâäàð Ӧ݂݂âýð Ӧéíéééí Õýí æýý*

Хөдөө орон нутгаас сонгогдох түүврийн хэмжээг тодорхойлохдоо 2002 онд ОУХБ-ийн АЙПЕК хөтөлбөрийн захиалгаар Зөвлөх Нэгжийн гүйцэтгэсэн “Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн талаарх судалгаа”-ны үр дүнг ашиглав.

Түүвэр олонлогийн хэмжээг дараах томъёоны тусlamжтай тодорхойлсон.

$$n = t^2 p(1-p)/\alpha^2, \quad \text{Энд: } n - \text{Түүвэр олонлогийн хэмжээ}$$

α- Түүврийн алдаа

p- Малчин хүүхэд ажиллуулдаг өрхийн хувийн жин

t - Итгэх түвшний утга

Түүвэр судалгааны алдааг 5 хувь, итгэх түвшний утгыг 5 хувь байхаар сонгож, малчин хүүхэд ажиллуулж буй өрхийн хувийн жин 22.2 хувь гэсэн статистикийг ашиглан түүвэр олонлогийн оновчтой хэмжээг тодорхойлбол 265 өрх болно. Түүврийн бус алдааг тооцож үзсэнээр эх олонлогоос ойролцоогоор 270 өрхийг түүвэр судалгаанд хамруулсан юм.

Олонхи судалгаануудын туршилагаас түүвэрлэлтийн анхан шатны нэгжээс ойролцоогоор 30-50 нэгж сонгох нь түүвэрлэлтийн бус алдааг харьцангуй бага байлгадаг хамгийн үр ашигтай хэмжээ болох нь харагдсан учраас жигд тархаалтын

<sup>6</sup> Улаанбаатар хотын 9 дүүргээс Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийн хүн ам тус хотын нийт хүн амд маш бага хувь эзэлдэг учраас судалгааны үр дүнд хангалттай нөлөө үзүүлэхгүй болов уу гэсэн үндэслэлээр хотоос авах судалгаанд зөвхөн төвийн 6 дүүргийг хамруулав.

аргыг ашиглан, сум бүрээс 30 өрхийг судалгаанд хамруулна гэвэл аймаг бүрээс 3 сум сонгогдож байна.

### *Оюу түүвэрлэлтийн зарим параметрүүд, аймгуудаар*

Хөдөө орон нутгаас судалгаанд хамрагдах өрхүүдийг сонгохдоо түүвэрлэлтийг 3 шатат загварыг ашиглалаа. Түүвэрлэлтийн эхний шатанд зорилтот түүвэрлэлтийн аргаар нийт 18 аймгаас<sup>7</sup> нэг өрхөд ногдох малын тоо, ядуурал (нэг хүнд ногдох ДНБ улсын дунджаас доогуур эсэх) болон хотоос алслагдсан байдал, сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо болон амьжиргааны түвшинд ихээхэн нөлөө үзүүлэхүйц байгаль, цаг уурын гамшигт өртсөн эсэх зэргийг түүвэрлэлтийн гол шалгуур болгон үзэж дээрх 18 аймгийг төлөөлөхүйц 3 аймгийг сонголоо.

Үндэсний статистикийн газрын 2003 оны тоо мэдээллээс үзэхэд дээрх аймгуудад нийт 349.3 мянян өрх амьдардаг ба Хүнэгт 2.2-т аймгуудын өрх, малын тоо болон нэг хүнд ногдох ДНБ-ийг харуулав.

### *Оюу түүвэрлэлтийн зарим параметрүүд, аймгуудаар*

Д/д	Аймгууд	Өрхийн тоо /мян/	Малын тоо /мян/	Нэг өрхөд ногдох малын тоо	Нэг хүнд ногдох ДНБ*, /ам.дол/
1	Архангай	24.7	1837.5	74.4	1232.12
2	Баян-Өлгий	21.8	1315.6	60.3	992.85
3	Баянхонгор	21.5	1099.2	51.1	1392.36
4	Булган	15.4	1107.9	71.9	1434.46
5	Говь-Алтай	15.2	1261.2	83.0	1345.54
6	Дорнговь	13.2	926.4	70.2	1193.62
7	Дорнод	17.1	843.8	49.3	956.32
8	Дундговь	12.5	1598.1	127.8	1424.74
9	Завхан	20.2	1628.6	80.6	1225.91
10	Өвөрхангай	28.8	1918.8	66.6	792.77
11	Өмнөговь	12.1	907.4	75.0	1667.14
12	Сүхбаатар	13.3	1622.7	122.0	1272.8
13	Сэлэнгэ	22.6	587.0	26.0	1600.98
14	Төв	23.3	1475.6	63.3	1719.77
15	Увс	19.8	1664.4	84.1	1098.3
16	Ховд	19.2	1541.0	80.3	1178.42
17	Хөвсгөл	31.0	2060.4	66.5	976.44
18	Хэнтий	17.6	1451.7	82.5	1289.61
Аймгуудын дундаж		349.3	24847.3	71.1	-
Улсын дундаж		585.5	25427.7	43.4	1740

Үүснэгийн дундаж: - НА, 1996-2003

\* - 1996-2003-ийн дундаж

Хоёр дахь шатанд сонгогдсон аймгуудын нийт 60 сумаас нэг өрхөд ногдох малын тоонд үндэслэн аймаг бүрээс 3 сумыг сонгосон. Түүвэрлэлтийн түвшинд ихээхэн нөлөө үзүүлэхүйц байгаа аж үйлдвэр хөгжсөн гэж үзээд бусад 18 аймгаас судалгааны түүвэрлэлтийг хийнэ.

<sup>7</sup> Улаанбаатар хот болон Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгуудыг харьцаангуйц цөөн малтай, дэд бүтэц болон аж үйлдвэр хөгжсөн гэж үзээд бусад 18 аймгаас судалгааны түүвэрлэлтийг хийнэ.

Түүвэрлэлтийн анхан шатны нэгж болох сүм бүрээс мал маллах ажилдаа өөр айлын хүүхэд туслалцуулдаг 30 өрхийг санамсаргүйгээр сонгож, айлд мал маллах буй хүүхдүүдийг судалгаанд хамруулсан болно. Хүснэгт 2.3-т сонгогдсон аймгууд, аймаг тус бүрээс сонгогдсон түүвэрлэлтийн анхан шатны нэгжүүдийг 2 дахь шатны түүвэрлэлтийн параметрүүдийн хамт харуулав.

#### *Одийн 2.3. Аймгуудас сонгогдсон түүвэрлэлтийн анхан шатны нэгжүүд*

Д/д	Аймгууд	Сүмын нэр	Өрхийн тоо	Малын тоо	Нэг өрхөд ногдох малын тоо
1	Өвөрхангай	Зүүн баян улаан	1255	79571	63.4
		Тараагт	1171	90414	77.2
		Хужирт	2041	108895	53.4
<i>Аёй аёеи аёй</i>			28865	1918832	66.5
2	Ховд	Булган	1953	172499	88.3
		Буянт	734	73333	99.9
		Дөргөн	654	56681	86.7
<i>Аёй аёеи аёй</i>			19243	1541004	80.1
3	Хөвсгөл	Жаргалант	1271	76684	60.3
		Тариалан	1474	96092	65.2
		Эрдэнэбулган	710	43196	60.8
<i>Аёй аёеи аёй</i>			31021	2060424	66.4

Үүснэгдэл: -НА, Нийт орлогчийн тоог Хүснэгт 2.4-д харуулав.

#### B. Судалгааны түүврийн хэмжээ:

Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч/айлд мал маллах байгаа хүүхдүүд, тэдний эцэг/эх болон ажил олгогчдын тоог Хүснэгт 2.4-д харуулав.

#### *Одийн 2.4 Судалгаанд хамрагдалтын түвшин*

Судалгаанд хамрагдсан			
Аймаг, хот	Хүүхдүүдийн тоо	Эцэг, эхийн тоо	Ажил олгогчдын тоо
1 Өвөрхангай	90	40	40
2 Ховд	90	39	41
3 Хөвсгөл	90	45	35
4 Улаанбаатар	90	44	50
<b>Бүгд</b>	<b>270</b>	<b>168</b>	<b>166</b>

Түүвэр олонлогийн хэмжээтэй тэнцүү тооны хүүхдүүдийг судалгаанд бүрэн хамруулж, мэдээлэл авсан юм. Харин тэдний эцэг/эх болон ажил олгогчдын судалгаанд хамрагдалтын түвшин ойролцоогоор 62 хувь байна.

Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч/айлд мал маллах буй хүүхдүүдийн эцэг/ эх болон ажил олгогчоос мэдээлэл цуглуулахын тулд нэг өрхөд хамгийн олондоо Улаанбаатарт 3 удаа, хөдөө орон нутагт 1 удаа дахин очилт хийсэн.

Хотод ажиллаж буй хүүхдүүдийн эцэг/эхийн 48.9 хувь, хөдөөд ажиллаж буй хүүхдүүдийн эцэг/эхийн 45.9 хувь нь судалгаанд хамрагджээ. Түүнчлэн хотын ажил олгогчдын 55.6, хөдөөгийн ажил олгогчдын 43 хувиас нь мэдээлэл цуглуулсан байна.

Гэрийн үйлчлэгч/айлд мал малаж буй хүүхдүүдийн эцэг эхийн судалгааны дутуу хамрагдалтанд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэг/эх өөр аймаг хотод амьдарч байх, (20 хувь) түр хугацаагаар эзгүй байх (18.9 хувь) зэрэг шалтгаанууд хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин ажил олгогчдын хувьд түр хугацаагаар эзгүй байсан (31.4 хувь), татгалзсан (8.6) гэсэн шалтгаанууд бусад шалтгаанаас өндөр хувьтай гарчээ.

## *2.2.2 №ääëäàäí û ð äíä àøëäëäí ýö tëëíëëä ñtäï ðöëëëí ïü*

“Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн суурь судалгаа”-ны мэдээлэлд үндэслэн Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг болон хөдөө орон нутагт айлд ажил хийж буй хүүхдүүдийн тоог тодорхойлсон юм.

Хүснэгт 2.5-д эх олонлогийн тооцооллыг харуулав.

Судалгааны үр дүнгээс харахад Улаанбаатар хотын нийт өрхүүдийн 3.4 хувь нь өдөр тутмын ажилдаа өөр айлын хүүхэд туслалцуулдаг байна. Харин хөдөөгийн 100 өрх тутмын 12-13 нь өөр айлын хүүхэд ажиллуулдаг өрх байна. Энэхүү статистикийн ашиглан, Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг болон аймгуудад хичнээн хүүхэд ажиллаж байгааг, өөрөөр хэлбэл эх олонлогийн хэмжээг тодорхойлоход дээрх үр дүн гарчээ (Хүснэгт 2.5).

### *Огийн 2.5 Түүвэрлэлтийн тархаалт*

	Судалгааны үр дүн/Түүвэр олонлог			Эх олонлог	
	Хүүхэд ажиллуулж буй өрхийн тоо/Түүврийн хэмжээ- $n_{GY}$	Судалгаанд хамрагдсан нийт өрхийн тоо- $n_{Нийт}$	Хүүхэд ажиллуулж буй өрхүүдийн хувийн жин/Тархалт	Нийт өрхийн тоо- $N_{Нийт}$	Хүүхэд ажиллуулж буй нийт өрхийн тоо- $N_{GY} = N_{Нийт} \times p$
<i>Байришил</i>			$p = \frac{n_{GY}}{n_{Нийт}}$		
Улаанбаатар	90	2624	3.4%	180822*	6148
Хөдөө орон	270	2152	12.5%	243412**	30427
нутаг					

*Үүснэгт 2.5-д түүвэрлэлтийн тархаалт*

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт нийт 6148 хүүхэд өөр өрхөд ажиллаж байна. Нэг айлд нэгээс илүү хүүхэд ажиллахгүй гэвэл, нийслэлийн төвийн 6 дүүргийн нийт өрхүүдийн 6148 нь өөр айлын хүүхэд ажиллуулж байна. Мөн хөдөө орон нутагт 30427 хүүхэд өөрийнхөө гэрээс өөр өрхийн малд маллах ажилд тусалж байна гэсэн үр дүн гарсан байна.

Эдгээр хүүхдүүдийг ажил олгогчийн хамаарлаар Хүснэгт 2.6-д харуулав.

\* -Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн өрхүүдийн тоо

\*\* -Дархан-Уул, Орхон аймаг болон Улаанбаатар хотын бүх өрхүүд, бусад аймгуудын аймгийн төвийн өрхүүд ороогүй

Хөдөө орон нутагт айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн 30 хувь нь буюу нийт 9128 хүүхэд өвөө/эмээ болон төрсөн ах/эгч гэсэн ойрын хамаатан өрхөд ажиллаж байна. Хотод энэ хувь харьцангуй өндөр байгаа ба гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй хүүхдүүдийн талаас илүү хувь нь (52.2 хувь) өвөө/эмээ болон төрсөн ах/эгчийндээ ажиллаж байлаа.

#### *Огийн 2.6 Ажил олгогч ба хүүхдийн хамаарал*

Ажил олгогчийн хамаарал	Хот		Хөдөө	
	Гэрийн үйлчлэгч хүүхдийн хувь	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо	Айлд мал маллаж буй хүүхдийн тоо	Айлд мал маллаж буй хүүхдийн хувь
Өвөө/Эмээ	37.8	2324	27.8	8459
Төрсөн ах/эгч	14.4	885	2.2	669
Бусад хамаатан	18.9	1162	41.9	12749
Хамаатан бус	28.9	1777	28.1	8550
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>6148</b>	<b>100.0</b>	<b>30427</b>

Хот ба хөдөөгийн аль алинд хамаатан бус өрхийн гэрийн болон мал маллах ажилд тусалж буй хүүхдүүдийн хувь ойролцоо байна. Судалгааны үр дүнгээс харахад, Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт хамаатан бус өрхөд гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй 6-17 насны 1777 хүүхэд, аймгуудад хамаатан бус айлд мал маллаж буй мөн насны 8550 хүүхэд байгаа ажээ.

#### *2.2.3 Айлд мал маллаж буй хүүхдээс асуулга*

Судалгааны зорилгод нийцсэн мэдээллийг цуглуулахын тулд тоон судалгаанд ялгаатай бэлтгэсэн асуултын хуудсуудыг ашигласан. Үүнд:

- Гэрийн үйлчлэгч хүүхдээс асуух асуулга
- Айлд мал маллаж буй хүүхдээс асуух асуулга
- Гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн эцэг/эхээс асуух асуулга
- Ажил олгогчоос асуух асуулга

Эдгээр асуултын хуудас бүр нь тодорхой онцлогтой бөгөөд срөнхийдөө гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж буй хүүхдүүдийн шинж байдал, өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт, ажлын нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл, хөдөлмөр хамгааллын асуудлыг цогц байдлаар судалж, үнэлэлт, дүгнэлт гаргах зорилготойгоор боловсруулагдсан болно.

#### *2.2.4 Ийн өдөрний өөрөө*

Судалгааны мэдээлэл цуглуулалтанд МУИС-ийн ХАССТ-ийн багш, судлаачид, хүн ам зүйн 4-р анги (бакалавр), магистрын ангийн оюутнууд оролцсон. Мэдээлэл цуглуулах ажлыг 1 багийн ахлагч, 3 ярилцлага авагчийн бүрэлдэхүүнтэйгээр 2004 оны 11-р сарын 12-ноос 11-р сарын 26-ныг дуустал нийт 15 өдрийн хугацаанд хийж

гүйцэтгэв. Судалгааны мэдээлэл цуглуулалтанд сонгогдсон хэсэг, багийн ахлагчид ихээхэн дэмжлэг үзүүлж байлаа. Багийн ахлагчид, ярилцлага авагчдын үүргээ гүйцэтгэж буй байдлыг үнэлэх, мэдээлэл цуглуулалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон Хөвсгөл аймагт хяналт, шалгалтыг хийсэн.

### *2.2.5 1 юүүёёё айёй айдооёёё*

Тоон судалгааны мэдээллийг ISSA программын тусламжтайгаар компьютерт оруулж, мэдээллийн боловсруулалт, статистик шинжилгээнд SPSS программыг ашиглав. Тус судалгааны мэдээлэл 4 тусдаа асуулгын хуудсаар цуглуулагдсан учраас ялгаатай мэдээллийн баазуудад боловсруулалт, шинжилгээг хийлээ. Мэдээлэл боловсруулалтанд ихэнхдээ тайлбар болон харьцуулсан статистикийн арга зүй ашиглагдсан болно.

### *2.2.6 Нийтийн түвшингээс ямар доогуур мэдээлдэг*

Өрхүүд орлогынхоо түвшинг хэрэглээнийхээ түвшингээс ямагт доогуур мэдээлдэг<sup>8</sup> практикийг харгалзан судалгааны тайланда тооцоологдсон өрхийн орлогын түвшинд бодитойгоор хандах шаардлагатай. Айлд ажиллаж буй хүүхдүүдийн өдөр тутмын ажлын цагийн хуваарилалт нэлээд тойм байдааар тодорхойлогдсон байж болох талтай.

## **2.3. Чанарын судалгааны арга зүй**

“Гэрийн үйлчлэгчийн суурь судалгаа”-ны тоон мэдээллийг буюу тоон судалгааны үр дүнг батлах зорилгоор чанарын судалгааг явуулсан. Чанарын судалгаа нь гүнзгийрүүлсэн ярилцлага болон ажиглалтын аргаас бүрдсэн бөгөөд, судалгаанд хамрагдсан хүүхэд бүртэй урьдчилан бэлтгэсэн удирдамжийн дагуу хийсэн дэлгэрэнгүй ярилцлага, мөн ярилцлага авагчдын ажиглалтын үр дүнд үндэслэн дараах мэдээллийг гарган авах зорилготой байв. Үүнд:

- Хүүхдийн бие бялдар, оюун санаа, сэтгэлгээний хөгжил
- Хүүхдийн нэг өдрийн амьдралын зураглал (цаг зарцуулалтын байдал, тогтмол очдог газрууд гэх мэт)
- Эрхэлж буй хөдөлмөрийн хүндрэл, бэрхшээлүүд
- Ажиллаж буй айлынхантайгаа ямар харьцаатай байдаг, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа байдал, хүчирхийллийн шинж тэмдэг байгаа эсэх
- Гэмт хэргийн орчин
- Мөрөөдөж хүсдэг зүйл багтана.

<sup>8</sup> ХАССТ, 2004. “Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн”, Улаанбаатар

## БҮЛЭГ 3. УЛААНБААТАР ХОТОД АЙЛД ГЭРИЙН ҮЙЛЧЛЭГЧ ХИЙЖ БАЙГАА ХҮҮХДҮҮД

Бид энэ судалгаагаараа хүүхдийн хөдөлмөрийн нэг хэлбэр болох айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн байдлыг нийслэл хотын хэмжээнд судалсан юм. Дэлхийн хөгжиж байгаа олон оронд хүүхдийн хөдөлмөрийн энэ хэлбэр түгээмэл, мөн энэ талаар хийгдсэн судалгааны ажлууд нэлээд байсан нь судалгаа явуулахад тус дөхөмтэй байв.

Энэ бүлгээрээ айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн шинж байдал, өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт, эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалалт, дадал зуршил, хүндрэл бэрхшээл, ирээдүйн хүсэл мөрөөдлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргэх болно.

### 3.1 Айлд гэрийн үйлчлэгч хийж буй хүүхдүүдийн шинж байдал

Айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн суурь судалгааг Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн 16 хэсгийг сонгон, нийтдээ 2624 өрхөөс илрүүлсэн 90 гэрийн үйлчлэгчийн дунд явууллаа. Түүврийн тархаалтын тооцоогоор Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэгт 6148 хүүхэд гэрийн үйлчлэгчийн ажлыг эрхэлж байна гэсэн тоо гарч байна. Судалгаагаар нэлээд нарийвчилсан мэдээлэл гаргахыг зорьсон, нөгөө талаар судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо цөөн байгаагаас үүдэн гарах алдааг бодолzon мэдээллийг тархаалт хийлгүйгээр зөвхөн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд гаргах нь зүйтэй гэж үзэв.

#### 3.1.1 Орчны үзүүлэлтэй өвлийн тоо

Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийг нас, хүйс, Улаанбаатар хотын дүүргээр Хүснэгт 3.1-д харуулав.

Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийг дүүргээр авч үзвэл Сонгино хайрхан (30.0 хувь), Баянзүрх (28.9 хувь) дүүргүүдэд гэрийн үйлчлэгчээр ажилладаг хүүхдүүдийн эзлэх хувь бусад дүүргүүдээс харьцаангуй өндөр байна. Энэ нь дээрх дүүргүүдэд шилжин ирэгсдийн тоо их байдагтай холбоотой.

Өзүүлэлт 3.1. Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, хүйс ба дүүргээр			
Дүүрэг	Хүйс		Бүгд
	Эрэгтэй	Эмэгтэй	
Баянгол	13.7	7.8	11.1
Баянзүрх	35.3	20.5	28.9
Сүхбаатар	5.9	20.5	12.2
Сонгинохайрхан	33.3	25.6	30.0
Чингэлтэй	5.9	12.8	8.9
Хан-Уул	5.9	12.8	8.9
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо</b>	<b>51</b>	<b>39</b>	<b>90</b>

Судалгаагаар гэр болон байшин хороодын айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн ялгаатай шинж байдлыг гаргахыг зорьсон боловч харамсалтай нь байшин хорооллоос харьцангуй цөөн (14 хүүхэд) хүүхэд судалгаанд хамрагдсан. Судалгаа явулахаас өмнө гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдийг олох зорилгоор сонгогдсон хороодын өрхүүдийн талаар урьдчилсан судалгааг гаргуулсан боловч ялангуяа, байшин хороололд үүдээ тайлж өгөхгүй байх, хорооноос хүүхэд ажиллаж байгаа гэсэн жагсаалт гаргаж өгсөн байхад байхгүй гээд судалгаа өгөхөөс татгалзах явдал түгээмэл байлаа. Хэдийгээр хүүхдийн гэрийн үйлчлэгчийн хөдөлмөр эрхлэлтийн талаар хүмүүс сайн мэддэг, тэр битгий хэл хөлсөлж ажиллуулна гэсэн зар мэдээ хэвлэл мэдээллээр цацагддаг болсоор удсан ч хүмүүсийн дунд хүүхэд зарцалж байна гэж хэлэх вий гэсэн болгоомжлол байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.

Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийн 56.7 хувь нь эрэгтэй, 43.3 хувь эмэгтэй хүүхдүүд байв. Насны бүлгээр авч үзэхэд 47.8 хувь буюу бараг тал хувийг нь 12-14 насныхан эзэлж байсан ба гэрийн үйлчлэгч хийж байгаа эрэгтэй хүүхдүүдийн дундаж нас 13, эмэгтэй хүүхдүүдийнх 14 байлаа.

Гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийн 52.2 хувь нь өвөө, эмээ, ах, эгчийндээ, 18.9 хувь нь бусад хамаатныдаа, 28.9 хувь нь найз нөхөд/хамаатан бус айлынд ажилладаг ажээ.

### *3.1.2 №0ðääööÿä ðàì ðàääääöö ãà áè÷èä ÿñäééí i ýäéýä*

Сургуульд суралцах боломж, нөхцөл муу байгаа нь хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэх нэг гол шалтгаан болдог. Сүүлийн жилүүдэд улсын хэмжээгээр сургууль завсардалт буурч байгаа боловч сургуульд огт сураагүй болон бага сургууль төгсөөгүй хүүхдүүдийн тоо өндөр хэвээр байна. Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны дүнгээс харахад сургуульд огт сураагүй хүүхдүүдийн дотор 10-17 насны хүүхдүүд 8.0 хувь, нийт хүүхдүүдийн дөрөвний нэг нь анхан шатны боловсрол эзэмшээгүй байгаагийн бараг 44.0 хувь нь 10-17 насныхан байгаа нь анхаарал татсан асуудал юм.<sup>9</sup>

Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 34.4 хувь нь сургуульд сурдаггүй ба 6 хүүхэд албан бус сургалтанд хамрагддаг ажээ (Хүснэгт 3.2). Тодруулбал, зайлшгүй суралцах ёстой 7-15 насны хүүхдүүдийн 25.3 хувь нь сургуульд суралцахгүй байна.

Сургуульд суралцдаггүй хүүхдүүдийг насны бүлгээр авч үзвэл 12 хүртэл насны хүүхдүүдийн 13.2 хувь, 12-14 насны хүүхдүүдийн 23.5 хувь, 15-17 насны хүүхдүүдийн 59.4 хувь нь сургуульд суралцахгүй байна. Өөрөөр хэлбэл, тухайн насны бүлэгт сургуульд сурахгүй байгаа хүүхдүүдийн эзлэх хувь нас ахих тусам нэмэгдэж байна. Хүйсээр авч үзэхэд сургуульд суралцдаггүй эрэгтэй хүүхдүүдийн хувийн жин эмэгтэй хүүхдүүдтэй ойролцоо түвшинд байна.

Ажиллаж буй айлынх нь хамаарлаар авч үзвэл, өвөө, эмээ, ах, эгчийндээ ажиллаж байгаа хүүхдүүдийн дийлэнх нь сургуульд сурч байхад бусад хамаатныдаа ажиллаж

<sup>9</sup> Үндэсний Статистикийн Газар, 2004. “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”, Улаанбаатар

байгаа хүүхдүүдийн талаас илүү хувь нь, хамаатан бус айлд ажиллаж байгаа дөрвөн хүүхэд тутмын нэг нь сургуульд сурч байна.

**Одойт 3.2. Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хүүхдийн хувийн жин, сургуульд суралцдаг эсэх, сонгосон үзүүлэлтээр**

Сонгосон үзүүлэлт	Сургуульд суралцдаг эсэх			Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Сургуульд сурдаг	Албан бус сургалтанд хамрагддаг	Сурдаггүй		
<b>Нас</b>					
6-11	86.7	-	13.3	<b>100.0</b>	<b>15</b>
12-14	67.4	9.3	23.5	<b>100.0</b>	<b>43</b>
15-17	34.4	6.2	59.4	<b>100.0</b>	<b>32</b>
<b>Хүйс</b>					
Эрэгтэй	58.8	5.9	35.3	<b>100.0</b>	<b>51</b>
Эмэгтэй	59.0	7.7	33.3	<b>100.0</b>	<b>39</b>
<b>Шилжилтийн байдал</b>					
Шилжигч	47.4	10.5	42.1	<b>100.0</b>	<b>19</b>
Шилжигч бус	62.0	5.6	32.4	<b>100.0</b>	<b>71</b>
<b>Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох</b>					
Өвөө, эмээ, ах, эгч	80.9	-	19.1	<b>100.0</b>	<b>47</b>
Бусад хамаатан	52.9	5.9	41.2	<b>100.0</b>	<b>17</b>
Хамаатан бус	23.1	19.2	57.7	<b>100.0</b>	<b>26</b>
<b>Бүгд</b>	<b>58.9</b>	<b>6.7</b>	<b>34.4</b>	<b>100.0</b>	<b>90</b>

Энд анхаарал татсан нэг зүйл бол шилжих хөдөлгөөнд оролцсон бараг хоёр хүүхдийн нэг нь сургуульд суралцахгүй байна.

Сургуульд суралцахгүй байгаа гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн суралцахгүй байгаа шалтгааныг Хүснэгт 3.3-т үзүүлэв.

Сургуульд суралцдаггүй гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн талаас илүү хувь нь ар гэрийн гачигдлаас болж сургуульд сурдаггүй бөгөөд аль ч насын бүлэгт энэ хувь өндөр байгаа юм. Үүний дараа ажил хийдэг учраас сургуульд сурдаггүй гэж 15-17 насынхан, охидууд, эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй/өнчин хүүхдүүдийн өгсөн хариулт орж байна. Энд сонирхол татсан зүйл бол эмэгтэй хүүхдүүдээс сурлага тааруу учраас сургуульд сурдаггүй гэсэн нэг ч хариулт байхгүй байхад харин хөвгүүдийн 16.6 хувь нь энэ хариултыг өгчээ. Сургуульд суралцдаггүй хүүхдүүдийн 48.4 хувийг хамаатан бус айлдаа ажил хийдэг хүүхдүүд өзэлж байгаа ба ар гэрийн гачигдалтай байдал тэдний суралцахгүй байгаа гол шалтгаан болж байна.

Хүүхдүүдээс судалгаа авсаны дараагаар хүүхдүүдэд ямар бэрхшээл тохиолдож байгаа болон цаашид, юу хүсэж мөрөөдөж байдаг, хүүхдүүдийн бисийн срөнхий хөгжил, сэтгэц хэр зэрэг байгааг тандсан юм. Ярилцлагын явцаас ажиглалт хийхэд хэл ярианы хөгжил муу, дүлий сурах боломжгүй 6 хүүхэд байв.

*Одийн 3.3. Сургуульд суралцагчийн хувийн жин, суралцахгүй байгаа шалтгаан, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Суралцагчийн хувийн жин						Сургуульд суралцахгүй байгаа гэрийн үйлчлэгчийн тоо	
	Сурлагатаруу	Ажилладаг	Ар гэрийн гачигдал	Эрүүл мэндийн шалтгаан	Мөнгөний положжүй	Сонирхолтгүй	Бүгд	
<b>Нас</b>								
6-11	-	-	50.0	50.0	-	-	<b>100.0</b>	<b>2</b>
12-14	10.0	10.0	60.0	-	20.0	-	<b>100.0</b>	<b>10</b>
15-17	10.5	21.1	47.4	10.5	10.5	-	<b>100.0</b>	<b>19</b>
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	16.6	5.6	50.0	11.1	11.1	5.6	<b>100.0</b>	<b>18</b>
Эмэгтэй	-	30.8	53.8	7.7	-	7.7	<b>100.0</b>	<b>13</b>
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>								
Хамт амьдардаг	9.5	14.3	52.3	14.3	4.8	4.8	<b>100.0</b>	<b>21</b>
Хамт амьдардагтгүй/Өнчин	10.0	20.0	50.0	-	10.0	10.0	<b>100.0</b>	<b>10</b>
<b>Бүгд</b>	<b>9.7</b>	<b>16.1</b>	<b>51.6</b>	<b>9.7</b>	<b>12.9</b>	-	<b>100.0</b>	<b>31</b>

Сургуульд суралцдаг гэрийн үйлчлэгч хүүхдүүдэд ажиллахын хажуугаар хэр амжилттай суралцаж байгаа, мөн тэдэнд гэрийн даалгавар хийх цаг олддог эсэх талаар судлахыг зорьсон юм. Судалгаанд хамрагдсан сургуульд суралцаж байгаа 59 хүүхдийн 60 орчим хувь нь А, В дүнтэй суралцдаг гэж хариулсан ба аль ч ангид ижилхэн В үнэлгээний эзлэх хувийн жин 40 хувиас дээш байлаа.

*Одийн 3.4. Сургуульд сурдаг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, хүйс болон гэрийн даалгавар хийхдээ зарцуулдаг хугацаагаар*

Гэрийн даалгавар хийхдээ зарцуулдаг хугацаа	Хүйс		Бүгд
	Эрэгтэй	Эмэгтэй	
1 хүртлэх цаг	60.6	30.8	<b>47.5</b>
2 цаг	15.2	38.5	<b>25.4</b>
3 цаг	21.2	26.9	<b>23.7</b>
4 цаг	3.0	3.8	<b>3.4</b>
Дундаж хугацаа, минутаар	93.4	120.0	105.4
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Сургуульд сурдаг гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо</b>	<b>33</b>	<b>26</b>	<b>59</b>

Харин хангалтгүй буюу F үнэлгээтэй сурдаг гэж нэг ч хүүхэд хариулсангүй. Энэ асуултыг гэрийн үйлчлэгч хүүхдүүд хэрхэн үнэн зөв хариулсныг шалгах боломжгүй ч гэсэн сургуулийн гадуур бие даах ажилдаа буюу гэрийн даалгавар хийхдээ хэр хугацаа зарцуулдгийг авч үзье. Хариултаас харахад хүүхдүүд дунджаар 1 цаг 45 минутыг гэрийн даалгавар хийхдээ зарцуулдаг байна.

Сурахын зэрэгцээ гэрийн үйлчлэгч хийдэг хүүхдүүдийн бараг тал орчим хувь нь 1 хүртлэх цагийг гэрийн даалгавар хийхэд зориулдаг байна. Ялангуяа энэ хариултыг эрэгтэй хүүхдүүдийн 60.6 хувь нь өгчээ. Энэ бол сайн суралцахад үнэхээр хангалтгүй хугацаа юм. Үүнийг нэг талаас тэдний идэвх, нөгөө ажил олгогчид хичээллэх цаг бага олгодог гэсэн салаа утгын аль алинаар ч тайлбарлаж болно.

Судалгаагаар уншиж чаддаггүй, бичиж чаддаг эсэхийг тодорхойлохын тулд гарг хамгийн ойрхон байгаагаар нь судалгааны асуулт уншуулж, мөн авч яваа дэвтэр дээрээ нэг өгүүлбэр хэлж бичүүлсэн.

Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 8.9 хувь нь уншиж, 11.1 хувь бичиж чаддахгүй байв. Түүнчлэн 12-14 насныхан, эрэгтэй, шилжин ирсэн хүүхдүүдийн хувьд уншиж, бичиж чаддаггүй гэсэн хувь бусдаас өндөр байлаа. Суурь боловсрол эзэмших насны, шилжин ирсэн өрхийн хүүхдүүд Үндсэн хуулинд заасан боловсрол эзэмших эрхээ эдлэж чадахгүй, тэр бүү хэл уншиж, бичиж чадахгүй байна. (Хүснэгт 3.5).

### *3.5. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, бичиг үсгийн мэдлэг, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Уншиж чаддаг эсэх		Бичиж чаддаг эсэх		Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Тийм	Үгүй	Тийм	Үгүй		
<b>Нас</b>						
6-11	93.3	6.7	86.7	13.3	100.0	15
12-14	86.0	14.0	86.0	14.0	100.0	43
15-17	96.9	3.1	93.8	6.2	100.0	32
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	90.2	9.8	86.3	13.7	100.0	51
Эмэгтэй	93.2	7.7	92.3	7.7	100.0	39
<b>Шилжилтийн байдал</b>						
Шилжигч	89.5	10.5	84.2	15.8	100.0	19
Шилжигч бус	91.5	8.5	90.1	9.9	100.0	71
Бүгд	91.1	8.9	88.9	11.1	100.0	90

### *3.1.3 Орлогийн хувийн жин*

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтэнд нөлөө болж буй нэг хүчин зүйл бол хөдөө орон нутгаас нийслэлийг чиглэсэн их нүүдэл билээ. Өнөөдөр нийслэлийн хүн амын гуравны нэгийг шилжин ирэгсэд бүрдүүлж байгаа бөгөөд хөдөөгөөс шилжин ирэгсэд хотын захын дүүргүүдэд ил задгай газар гэрээ барьж, хотын захыг тэлж, борчуудын эгнээг өргөжүүлэх болов<sup>10</sup>. Түүнчлэн хөдөө орон нутагт боловсролын чанар хангалтгүйгээс ялангуяа, Улаанбаатар хотыг тойрсон Төв аймгийн сумдын хүүхдүүд

<sup>10</sup> Монгол улсын Засгийн Газар, НҮБХХ, 2004. “Монголын хүний хөгжлийн илтгэл, 2003: Хот, хөдөөгийн ялгаатай байдал” Улаанбаатар

нийслэлд ирж суралцах, суралцахын зэрэгцээ ажиллах, эсвэл хөдөлмөр эрхлэх явдал түгээмэл болоод байна<sup>11</sup>.

Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 21.1 хувь буюу таван хүүхэд тутмын нэг нь сүүлийн таван жилд шилжих хөдөлгөөнд оролцогчид байв. Эдгээр хүүхдүүдийн шилжих хөдөлгөөнд оролцох болсон шалтгааныг Зураг 3.1-д харуулав.



Шилжих хөдөлгөөнд оролцсон нийт хүүхдүүдийн 36.8 хувь нь хамаатан саднаа бараадах, 26.3 хувь нь суралцах шалтгаанаар Улаанбаатар хотод шилжин ирсэн байна. Энд сонирхол татсан асуудал бол хамаатан саднаа бараадахаар шилжин ирсэн эмэгтэй хүүхдүүдийн хувь хөвгүүдийнхээс 20.5 пунктээр өндөр байхад харин суралцахаар ирсэн эрэгтэй хүүхдүүдийн хувь охидынхоос 5 дахин өндөр байгаа явдал юм.

Хөдөө орон нутгаас шилжин ирж хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд эцэг, эх хамаатан садны халамж анхаарал, хараа хяналтан доор байна уу эсвэл тэд биеэ даан ажил эрхэлж амьдарч байна уу гэдэг асуудлыг судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Учир нь сүүлийн жилүүдэд улсын хэмжээгээр хараа хяналтгүй хүүхдүүдийн тоо төдийлөн буурч чадахгүй, томчуулын халамж, анхаарал хяналт суларснаас үүдэн хүчирхийлэлд өртөх, гэмт хэрэгт уруу татагдах зэрэг хүүхдийн эрх зөрчигдөх явдал гарсаар байна.

Иймээс хөдөө орон нутгаас ирэхдээ эдгээр хүүхдүүд хэн хэнтэйгээ хамт ирснийг судалж үзсэн юм. Судалгааны дүнгээс харахад айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа шилжигч хүүхдүүдийн 73.7 хувь эцэг эх, ах, хамаатан садантайгаа шилжин ирсэн бол 26.3 хувь нь ганцаараа шилжин ирсэн байна. Ялангуяа ганцаараа шилжин ирсэн

<sup>11</sup> АЙПЕК, ХАССТ, 2002. “Улаанбаатар хотын зах дээр хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн судалгаа”, Улаанбаатар

хүүхдүүдийн хувь 15-17 насныхан дунд, мөн эрэгтэй хүүхдүүдийн дунд өндөр байна (Хүснэгт 3.6).

*Ӧչийн 3.6. Шилжин ирсэн гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, хамт ирсэн хүмүүс ба сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Хамт ирсэн хүмүүс						Бүгд	Шилжих хөдөлгөөнд оролцсон гэрийн үйлчлэгч хүүхдийн тодотоо
	Ган- цаа- раа-	Эцэг эх	Aх эгч ах эгч	Эцэг эх, ах эгч, хамаатан	Эцэг эх, ах эгч, эмэгтэй өвөө			
Нас								
6-11	-	-	-	66.7	-	33.3	100.0	3
12-14	22.2	22.2	11.1	44.5	-	-	100.0	9
15-17	42.9	-	-	42.9	14.2	-	100.0	7
Хүйс								
Эрэгтэй	37.5	12.5	-	37.5	12.5	-	100.0	8
Эмэгтэй	18.2	9.1	9.1	54.5	9.1	-	100.0	11
Бүгд	26.3	10.5	5.3	47.3	5.3	5.3	100.0	19

Дараа дараагийн хэсгүүдийг шилжих хөдөлгөөнтэй холбон тайлбарлах болно.

### 3.1.4 Àð áýðèéí áàéäàë, àì üäðàëüí íºööºë

Хүүхэд яагаад хөдөлмөр эрхлэх болов гэсэн асуудлын цаана мэдээж тухайн хүүхдийн ар гэрийн ядуу амьдрал, элэг бүтэн эсэх гээд нийгмийн олон эмзэг асуудлууд багтаж байгаа. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн эцэг, эхтэй эсэх талаар авч узье.

Хүснэгт 3.7-д судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эцэг, эхтэй эсэхийг сонгосон үзүүлэлтээр харуулав.

Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 60.0 хувийнх нь эцэг, эх хоёулаа амьд сэргүүн байдаг ба 31.1 хувийнх нь эцэг нь нас барсан, 2.2 хувийнх нь эх нь нас барсан, 6.7 хувийнх нь хоёулаа нас барсан байна. Энд нэг зүйлийг хэлэхэд асуулга эцэг, эхтэйгээ хамт амьдардаг гэсэн агуулгаар биш, ер нь эцэг эх нь амьд байдаг уу гэсэн утгаар орсон.

*Одийн үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Эцэг, эх хоёулаа байдал	Өнчин				Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
		Хоёулаа нас барсан	Эцэг нас барсан	Эх нас барсан			
<b>Нас</b>							
6-11	60.0	-	40.0	-	100.0	15	
12-14	76.7	7.0	14.0	2.3	100.0	43	
15-17	37.5	9.4	50.0	3.1	100.0	32	
<b>Хүйс</b>							
Эрэгтэй	54.9	5.9	35.3	3.9	100.0	51	
Эмэгтэй	66.7	7.7	25.6	-	100.0	39	
<b>Шилжилтийн байдал</b>							
Шилжигч	63.2	-	36.8	-	100.0	19	
Шилжигч бус	59.2	8.5	29.5	2.8	100.0	71	
Бүгд	60.0	6.7	31.1	2.2	100.0	90	

Харин одоо аав ээж нь хоёулаа буюу аль нэг нь амьд байгаа гэрийн үйлчлэгч хүүхдүүдээс одоо хэнтэй амьдарч байгааг Хүснэгт 3.8-д харуулья.

*Одийн үзүүлэлтээр*


Сонгосон үзүүлэлт	Хэн хэнтэйгээ хамт амьдардаг				Бүгд	Бүгдэн өнчин биш гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Эцэг, эхтэйгээ	Ээжтэйгээ	Аавтай-гаа	Хамт амьдардаггүй		
<b>Нас</b>						
6-11	13.3	33.3	-	53.4	100.0	15
12-14	32.5	17.5	5.0	45.0	100.0	40
15-17	17.2	41.4	-	41.4	100.0	29
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	29.2	29.2	-	41.6	100.0	48
Эмэгтэй	16.7	27.7	5.6	50.0	100.0	36
<b>Шилжилтийн байдал</b>						
Шилжигч	26.3	10.5	5.3	57.9	100.0	19
Шилжигч бус	23.2	33.8	1.5	41.5	100.0	65
Бүгд	23.8	28.6	2.4	45.2	100.0	84

Хэдийгээр гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 60 хувь нь эцэг, эх байгаа гэж хариулсан боловч Хүснэгт-8-аас харахад одоо эцэг, эх хоёулантай нь хамт амьдардаг гэж хүүхдүүдийн дөнгөж 23.8 хувь хариулжээ.

Одоо аав, ээжийнхээ хэнтэй ч хамт амьдардаггүй гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн тал орчим хувь нь хариулжээ. Насны бүлгээр авч үзвэл 6-11 настай

хүүхдүүдийн аав, ээжийнхээ хэнтэй ч хамт амьдардаггүй гэсэн хувь бусдаас өндөр байна. Түүнчлэн шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдийн 57.9 хувь нь аав, ээжийнхээ хэнтэй нь ч хамт амьдрахгүй байна. Үүнийг нэг талаас хүүхдүүд ажил олгогчийнд амьдардаг, нөгөөтэйгүр хамаатан садныдаа болон өөр бусад газар амьдардаг гэдгээр тайлбарлаж болно. Энд анхаарал татсан асуудал бол бид өнөөг хүргэл өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхийн талаар байнга анхаарал хандуулж, эдгээр өрхүүдэд чиглэсэн нийгмийн олон талт арга хэмжээг авч явуулж байгаа билээ. Гэтэл судалгаагаар зөвхөн аавтайгаа амьдардаг хүүхдүүд цөөн гэсэн тохиолдов. Иймээс өрх толгойлсон аавуудтай, эмзэг өрхүүдийн талаар цаашид анхаарах, ийм өрхүүд хичнээн байгаа талаар нарийвчлан судлах шаардлагатай байна.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүд одоо ямар орон сууцанд амьдарч байгааг шилжих хөдөлгөөнд оролцсон эсэхээр нь Зураг 3.2-т харуулав.



Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 52.2 хувь гэрт, 25.5 хувь нь сууцны туудаа байшинд амьдарч байна. Энд сэтгэл эмзэглүүлсэн асуудал бол хүүхдүүдийн 12.3 хувь өөрийн гэсэн гэр оронгүй хaa тааралдсан газраа амьдарч явна. Зургаас харахад шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүд бүгд гэр оронтой, дийлэнх нь гэрт амьдардаг бол байхад шилжигч бус хүүхдүүдийн хувьд бүх төрлийн сууцанд амьдардгаас гадна гэр оронгүй хүүхдүүдийн эзлэх хувь ч багагүй байна.

Судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн 48.9 хувь буюу 44 хүүхэд ажил олгогчийнхоо гэрт амьдардаг ажээ.

Ажил олгогчийн гэрт амьдардаг хүүхдүүдээс гэртээ харихыг зөвшөөрдөг эсэхийг лавлахад хүүхдүүдийн 52.3 хувь нь зөвшөөрдөг, 47.7 хувь нь зөвшөөрдөггүй гэсэн хариултыг өглөө. Гэртээ харих зөвшөөрөл өгдөг эсэх нас, хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдсангүй. Харин хөдөөнөөс шилжин ирсэн хүүхдүүдийн зөвшөөрдөг гэж хариулсан хувь харьцангүй өндөр (81.8 хувь) байсныг хэлэх нь зүйтэй болов уу. Гэртээ харихыг зөвшөөрдөг гэж хариулсан хүүхдүүдээс гэртээ ямар хугацааны

давтамжтай очдогийг асуухад долоо хоногт нэг удаа (26.1 хувь), хоёр долоо хоногт нэг удаа (17.4 хувь), улиралд нэг удаа (17.4 хувь) очдог гэсэн хариулт бусдаас өндөр хувьтай байв. Мөн хагас жилд, бүтэн жилд ганцхан удаа гэртээ харихыг зөвшөөрдөг гэж тус бүр нэг хүүхэд хариулжээ.

Ажил олгогч гэртээ очихыг зөвшөөрдөггүй гэж хариулсан хүүхдүүдээс шалтгааныг торуулбал, хүүхэд харуулдаг учраас ажил цалгардана (2 хүүхэд), өөрийн гэсэн гэр оронгүй аввайж байдаг (2 хүүхэд), гэр байхгүй ээж гадаадад (2 хүүхэд), гэргүй (2 хүүхэд), гэрээ хураачихсан очих газар байхгүй (2 хүүхэд), ирээд удаагүй (3 хүүхэд), 2 жилийн гэрээ хийсэн гэрээгээ дуусаагүй (3 хүүхэд), ээж бие муутай (1 хүүхэд) гэсэн хариултуудыг өгсөн юм.

Ажил олгогчийн гэр хүүхдүүдийн гэрээс хамгийн ойр нь 5 метр, хамгийн хол нь 550 километрийн зайнд байдаг ажээ.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн бичиг баримттай эсэхийг сонгосон үзүүлэлтээр Хүснэгт 3.9-д харуулав.

*Одой 3.9. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, бичиг баримтын бүрдэл, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Төрсний гэрчилгээ/Иргэнийүнэмлэх			Эрүүл мэндийн даатгалын дэвтэр			Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Байгаа	Байхгүй	Мэдэхгүй	Байгаа	Байхгүй	Мэдэхгүй		
Нас								
6-11	86.6	6.7	6.7	93.3	6.7	-	100.0	15
12-14	93.0	7.0	-	86.0	9.3	4.7	100.0	43
15-17	84.4	15.6	-	87.5	12.5	-	100.0	32
Хүйс								
Эрэгтэй	86.2	11.8	2.0	88.2	7.8	4.0	100.0	51
Эмэгтэй	92.3	7.7	-	87.2	12.8	-	100.0	39
Шилжилтийн байдал								
Шилжигч	89.5	10.5	-	78.9	15.8	5.3	100.0	19
Шилжигч бус	88.7	9.9	1.4	90.1	8.5	1.4	100.0	71
Бүгд	88.9	10.0	1.1	87.8	10.0	2.2	100.0	90

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 88.9 хувь нь төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхтэй, 87.8 хувь эрүүл мэндийн даатгалын дэвтэртэй, үлдсэн хувь нь байхгүй, мэдэхгүй гэж хариулсан. Энд онцолж хэлэхэд эрэгтэй хүүхдүүдийн дээрх бичиг баримт байгаа эсэхийг мэдэхгүй гэж хариулсан хувь өндөр байв. Түүнчлэн 15-17 настай хүүхдүүдийн төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэх байхгүй (15.6 хувь), эрүүл мэндийн даатгалын дэвтэр байхгүй (12.5 хувь), шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдийн эрүүл мэндийн даатгалын дэвтэр байхгүй (15.8 хувь) гэсэн хувь өндөр байлаа.

Энд анхаарал татсан нэг асуудал бол олон түмний дунд шилжин ирсэн хүүхдүүд л эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй, бичиг баримтгүй байна гэсэн ойлголтой байдаг. Гэтэл судалгааны дүнгээс харахад шилжих хөдөлгөөнд оролцсон болон оролцогүй хүүхдүүдийн бичиг баримтгүй гэж хариулсан хувь ойролцоо түвшинд

байна. Энэ нь бичиг баримтжуулах асуудлыг хотын уугуул хүүхдүүдийн хувьд ч анхаарах шаардлагатай гэдгийг харуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд 16 хүртлэх насны бүх хүүхдийн эрүүл мэндийн даатгалыг төр хариуцна гэж заасан байдал хэдий ч эцэг, эхийн хариуцлагагүйгээс хүүхдүүд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдаж чадахгүй (төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэх байхгүй 10 хувь, эрүүл мэндийн даатгалын дэвтэргүй 10 хувь) байна. Иймээс, иргэний бүртгэл мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын албадаас хүүхдүүдийг бүртгэл, даатгалд хамруулах ажлыг нэн даруй зохион байгуулах шаардлагатай байна.

### 3.2 Өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт

Энэхүү хэсэгт айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийн анхны болон одоогийн ажил эрхлэлт ажлын төрөл, ажил хийх болсон шалтгаан, ажил эрхлэх үедээ сургуульд суралцаж байсан эсэх, анх ажил хийхийг хэн санаачилсан, хэрвээ ажлаа өөрчилсөн бол өөрчлөх болсон шалтгаан зэргийг авч үзэх болно.

#### *3.2.1 ÁÍ ÓÍ Ú àæèëé ýððëéýëö*

Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүд амьдралын шаардлагаар томчуулын тэр болгон дурлаад байдаггүй хүүхэд асрах, гэр орон цэвэрлэх, хоол хийх гээд цаг наргүй ажлыг хүүхэд насаа мартан өглөөнөөс үдэш болтол борви бохис хийлгүй ажилладаг нь судалгааны явцад ажиглагдлаа.

#### *Öjöö yäö 3.10. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, анх хийж байсан ажлын төрөл, нас, хүйсээр*

Ажлын төрөл								
Нас, хүйс	Мал маллах	Гэрийн үйлчлэгч	Гар дээрээс худалдаа хийх	Яс, шил цуглуулах	Дуулах, тоглоом тоглуулах	Машин угаах/харах	Ачаа зөөв	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
Нас								
6-11	20.0	93.3	-	-	-	-	6.7	15
12-14	11.6	93.0	9.3	4.7	-	-	2.3	43
15-17	12.5	84.4	9.4	3.1	6.3	6.3	3.1	32
Хүйс								
Эрэгтэй	13.7	88.2	5.9	5.9	3.9	2.0	3.9	51
Эмэгтэй	12.8	92.3	10.3	-	-	2.6	2.6	39
Бүгд	13.3	90.0	7.7	3.3	2.2	2.2	3.3	90

Томчуул хүүхдүүдээ гэрийн ажил сайн хийж сурх хэрэгтэй гэж үргэлж үглэж байдал боловч балчир хүүхдүүдийг гарын үзүүртээ зарчихаад тэдний хөдөлмөрийг үнэлдэггүй шиг ажил олгогч ч гэсэн ойр зуурын ажилдаа туслашцуулдаг, харин ч хооллож тэжээж, хөлс олгож байна гэсэн байр сууринаас хандаж байсан.

Судалгаанд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийн анх ажил хийж эхэлсэн дундаж нас 10 байгаа ба эрэгтэй хүүхдүүдийн хувьд 9, эмэгтэй хүүхдүүдийн хувьд 11 байна. Бид гэрийн үйлчлэгч хүүхдүүд одоогийн эрхэлж буй ажлаасаа өмнө анх ямар

ажил хийж байсан талаар асууж, эрхэлж байсан ажлын төрлийг тодорхойлох зорилоо. Гэхдээ анх гэрийн үйлчлэгчийн ажлаар ажиллаж эхэлсэн хүүхдүүд ч энд багтаж байгаа юм (Хүснэгт 3.10).

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дийлэнх буюу 90.0 хувь нь анхныхаа өрхөөс гадуур эрхэлсэн ажлыг гэрийн үйлчлэгчээр эхэлжээ. Мөн өмнө нь мал маллаж байсан хүүхдүүдийн хувийн жин багагүй (13.3 хувь) байна. Ялангуяа эрэгтэй хүүхдүүд яс, шил цуглуулах, дуулах, тоглоом тоглуулах, машин угаах, ачаа зөөх ажлуудыг анх хийж байжээ.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн анх ажил хийхдээ сургууль завсардсан байсан эсэхийг Хүснэгт 3.11-т харуулав.

*Одийд 3.11. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, анх ажил хийхдээ сургуулиас завсардсан байсан эсэх, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Анх ажил хийхдээ сургуулиас завсардсан байсан эсэх				Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Завсардсан байсан	Ажил хийхийн тулд завсардсан	Үгүй	Бүгд	
Нас					
6-11	6.7	-	93.3	100.0	15
12-14	23.3	4.7	72.0	100.0	43
15-17	28.1	6.3	65.6	100.0	32
Хүйс					
Эрэгтэй	19.6	3.9	76.5	100.0	51
Эмэгтэй	25.6	5.1	69.2	100.0	39
Өрхөд амьдарч байгаа хүний тоо					
1-3	7.4	3.7	88.9	100.0	27
4-5	27.6	-	72.4	100.0	29
6 ба түүнээс дээш	29.4	8.8	61.8	100.0	34
Бүгд	22.2	4.4	73.4	100.0	90

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 22.2 хувь нь анх ажил хийхдээ сургууль завсардсан байсан бол 4.4 хувь нь ажил хийхийн тулд сургуулиас гарсан байна. Сургуулиас гарсан байсан гэж хариулагсдын хувь нас ахих тусам, мөн өрхөд амьдарч байгаа хүний тоо өсөх тусам нэмэгдэж байна. Гэрийн үйлчлэгч эрэгтэй хүүхдүүдийн ажил хийхээс өмнө сургууль завсардсан хувь эмэгтэй хүүхдүүдийнхээс 6.0, ажил хийхийн тулд сургуулиас завсардсан хувь 1.2 пунктээр тус доогуур байна.

Хүүхдүүдийн ажил хийх санаачлагыг хэн анх гаргасан бэ гэдгийг Хүснэгт 3.12-т харууллаа.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 46.7 хувь нь өөрөө анх ажил хийх санаачлагыг гаргажээ. Түүнчлэн эцэг, эх ажил олгогчид ч гэсэн багагүй санаачлага гаргадгийг хүснэгтээс харж болно. Насны бүлэг ахих тусам санаачлагыг өөрөө гаргасан хувь

нэмэгдэж байгаа ба мөн эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдийг бодвол илүү түлхүү ажил хийх санаачлагыг өөрөө гаргадаг ажээ.

*Одийн үзүүлэлтээр 3.12. Гэрийн үйлчилгэч хүүхдүүдийн хувийн жин, анх ажил хийхийг санаачилсан хүмүүс болон сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Анх ажил хийх санаачлагыг гаргасан хүмүүс							Гэрийн үйлчилгэч хүүхдийн тоо
	Өөрөө	Эцэг/ Эх	Ах/Эгч/ Эмээ/ Өвөө	Хамаа- тан	Найз	Ажил олгогч	Бүгд	
Нас								
6-11	40.0	26.7	20.0	-	-	13.3	100.0	15
12-14	46.5	23.3	11.6	2.3	-	16.3	100.0	43
15-17	50.0	9.4	6.3	3.0	6.3	25.0	100.0	32
Хүйс								
Эрэгтэй	54.9	23.5	15.7	-	-	5.9	100.0	51
Эмэгтэй	35.9	12.9	5.1	5.1	5.1	35.9	100.0	39
Өрхөд амьдарч байгаа хүний тоо								
1-3	51.9	11.1	18.5	3.7	-	14.8	100.0	27
4-5	34.5	31.0	6.9	-	6.9	20.7	100.0	29
6 ба түүнээс	52.9	14.7	8.8	2.9	-	20.7	100.0	34
дээш								
Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох								
Өвөө, эмээ, ах, эгч	40.4	29.8	12.8	-	-	17.0	100.0	47
Бусад хамаатан	52.9	5.9	11.8	5.9	-	23.5	100.0	17
Хамаатан бус	53.8	7.7	7.7	3.8	7.7	19.3	100.0	26
Бүгд	46.7	18.9	11.1	2.2	2.2	18.9	100.0	90

Анх ажил хийх болсон шалтгааныг сонгосон үзүүлэлтээр Хүснэгт 3.13-т харуулав.

Хүүхдүүдийн анх ажил хийх болсон гол шалтгаануудад өрхийн орлогоо нэмэгдүүлэх, бусдад туслах зорилгоор, эцэг, эх ажилгүй, өөрийн мөнгөтэй болох гэсэн шалтгаанууд зонхицж байв. Өрхийн орлогоо нэмэгдүүлэх гэсэн шалтгааныг 15-17 насынхан болон 6 ба түүнээс дээш ам бүлтэй хүүхдүүд түлхүү хариулжээ. Мөн эцэг/ эх ажилгүй гэж 6-11 насын хүүхдүүд илүүтэй хариулсан байна. Түүнчлэн өвөө, эмээ, ах, эгчийндээ ажиллаж байгаа хүүхдүүдийн хувьд туслах зорилгоор (36.2 хувь), бусад хамаатныдаа ажиллаж байгаа хүүхдүүдийн хувьд өөрийн мөнгөтэй болох (35.3 хувь), хамаатан бус айлд ажиллаж байгаа хүүхдүүдийн хувьд өрхийн орлогоо нэмэгдүүлэх (50.0 хувь), өөрийн мөнгөтэй болох (38.5 хувь) гэж анх ажил эрхэлсэн гэсэн шалтгаанууд давамгайлж байна.

*Одийн үзүүлэлт 3.13. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, анх ажил эрхлэх болсон шалтгаан, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Анх ажил эрхлэх болсон шалтгаан								Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Эцэг/Эх ажилгүй	Өрхийн орлого нэмэг- дүүлэх	Сургууль завсард- сан	Өөрийн мөнгө- тэй боловх	Эцэгэх шаард -сан	Бусдад туслах зорилгоор	Ажил олгогчийнд амьдардаг	Туршилгатай болох	
<b>Нас</b>									
6-11	26.6	6.7	-	6.7	26.6	40.0	13.3	6.7	15
12-14	23.3	23.3	11.6	18.6	14.0	20.9	9.3	4.7	43
15-17	18.8	37.5	12.5	15.6	15.6	18.8	9.4	3.2	32
<b>Хүйс</b>									
Эрэгтэй	19.6	25.5	11.8	19.6	19.6	17.6	7.8	3.9	51
Эмэгтэй	23.1	25.6	2.6	17.9	12.8	30.8	10.3	2.6	39
<b>Өрхөд амьдарч байгаа хүний тоо</b>									
1-3	18.5	7.4	3.7	3.7	11.1	40.7	22.2	7.4	27
4-5	17.2	27.6	10.0	24.1	24.1	20.7	6.9	3.4	29
6 ба түүнээс дээш	26.5	38.2	14.7	29.4	14.7	11.8	2.9	8.8	34
<b>Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох</b>									
Өвөө, эмээ, ах, эгч	19.1	14.9	2.1	6.4	21.3	36.2	12.8	6.4	47
Бусад хамаатан	23.5	17.6	17.6	35.3	11.8	11.8	17.6	-	17
Хамаатан бус	23.1	50.0	15.4	38.5	11.5	7.7	-	-	26
Бүгд	21.1	25.6	12.2	18.9	16.7	23.3	8.9	3.3	90


Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй

Айлд гэрийн үйлчлэгч хийсэн хугацааг авч үзвэл хүүхдүүдийн 31.1 хувь нь 1 хүртэл жил, 37.8 хувь нь 1-3 жил, 31.1 хувь нь 3 ба түүнээс дээш жил ажиллаж байна. Энд сонирхол татсан үзүүлэлт бол 1-3 жил ажиллаж байгаа гэсэн 6-11 насны хүүхдүүдийн хариулсан хувь хамгийн өндөр буюу 53.3 хувь байлаа.

Өмнө нь одоогийнхоос өөр айлд гэрийн үйлчлэгч хийж байсан уу гэсэн асуултанд хүүхдүүдийн 32.2 хувь нь Тийм гэсэн хариулсан ба энэ хариултыг өгсөн хүүхдүүд өмнө нь гэрийн үйлчлэгчийн ажлыг дунджаар 2 айлд хийж байжээ.

Ажил олгогчоо өөрчилсөн гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн ажил олгогч айлаа өөрчилсөн шалтгааныг хүйсээр Зураг 3.3-т харуулав.

**Соёлаа 3.3 Ажил олгогчоо өөрчилсөн гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, хүйс болон айлаа өөрчилсөн шалтгаанаар**



Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй

Гэрийн үйлчлэгч эрэгтэй хүүхдүүдийн ажиллаж байсан айлаа өөрчилсөн гол шалтгаан нь ажиллуулахаа барьсон, ажил олгогчийнх нүүсэн гэсэн хариулт байсан бол эмэгтэй хүүхдүүдийн хувьд ажиллуулахаа барьсон, шийтгэдэг/ зоддог/ хэл амаар доромжилдог гэсэн шалтгаанууд түлхүү байлаа. Түүнчлэн судалгаанд хамрагдсан охид, хөвгүүдийн 17 орчим хувь нь ажлын нөхцөл хүнд гэж хариулжээ. Энд сэтгэл эмзэглүүлсэн зүйл бол эмэгтэй хүүхдүүдийн хувьд ажил олгогчийнх архи уугаад намайг тайван байлгадаггүйгээс айлаа өөрчилсөн гэсэн хариулт юм.

Гэрийн үйлчлэгч охидын хувьд бэлгийн хүчирхийлэл байна гэдэг нь эндээс харагдаж байна. Мөн хүүхдүүдийг ажил олгогч сургуульд явахыг зөвшөөрдөггүй, хориглодог гэсэн хариулт ч баагүй байна. Эндээс гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн эрх зөрчигдэж байна гэж дүгнэж болно.

### 3.2.2 Î äî îæééí àæèëé ýððöëýéò

Одоо айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн хийж байгаа ажлуудын талаар авч үзье.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүд гэр цэвэрлэх, хүүхэд, настан асрах, хувцас угаах, хоол хийх, гэр сахих, ус зөөх, түлээ мод бэлтгэх, зөөх хагалах зэрэг гэрийн ажлуудыг хийж байна. Хүйссээр авч үзвэл эрэгтэй хүүхдүүд ус зөөх, гэр цэвэрлэх, түлээ мод хагалах, бэлтгэх зөөх зэрэг бисийн хүч шаардсан ажлыг ажлыг түлхүү хийдэг бол эмэгтэй хүүхдүүд гэрийн ажлыг эмэгтэй хүн ёстай гэсэн заншилаар гэр цэвэрлэх, хоол хийх, гэр сахих ажлуудыг голчлон хийж байна (Хүснэгт 3.14).

*Өгүйүүд 3.14.* Тухайн ажлыг хийдэг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, хүйс болон айлд хийдэг ажлуудаар

Айлд хийдэг ажлууд	Хүйс		Бүгд
	Эрэгтэй	Эмэгтэй	
Гэр цэвэрлэх	74.5	100.0	85.6
Хүүхэд, настан асралт	60.8	71.8	65.6
Хувцас угаах	58.8	66.7	62.2
Хоол хийх	64.7	87.2	74.4
Гэр сахих	70.6	82.1	75.6
Ус зөөх	82.4	64.1	74.4
Түлээ мод бэлтгэх, зөөх	54.9	25.6	42.2
Түлээ мод хагалах	72.5	20.5	50.0
Чингэлэг/Лангуу/TҮЦ-нд суух	7.8	7.7	7.8
Мал хариулах	7.8	10.3	8.9
Зараалд гүйх	5.9	20.5	12.1
Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо	51	39	90

Насаар авч үзвэл бага насны хүүхдүүдээр гэр цэвэрлэх, гэр сахих ажлуудыг арай илүү хийлгэдэг бол арай томоохон хүүхдүүдээр хоол түлхүү хийлгэдэг юм байна. Ер нь гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувьд хийдэг ажлын хувьд нас, хүйсийн ялгаа тун бага байна (Хүснэгт 3.15)

Дээр дурьдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хийдэг ажлуудаас ус, түлээ зөөх ажлуудыг тусд нь авч үзлээ. Учир нь хөдөлмөрийн нөхцлийн норм нормативт 16 хүргэл насны хүүхдийг хоёр дугуйтай тэргэнцэрээр ачаа зөөхийг хориглодог, харин 16-17 хүүхдүүдийн нэг удаа тэргэнцэрээр зөөх ачааны хэмжээ 115 килограммаас хэтрэхгүй байхаар заасан байдаг. Мөн хэр хол замыг туулж байгаагаас шалтгаалан хөдөлмөрийн нөхцөл нь тодорхойлогддог.

*Өгүйүүд 3.15.* Тухайн ажлыг хийдэг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, нас болон айлд хийдэг ажлуудаар

Сонгосон үзүүлэлт	Нас			Бүгд
	6-11	12-14	15-17	
Гэр цэвэрлэх	93.3	90.7	75.0	85.6
Хүүхэд, настан асралт	80.0	60.5	65.6	65.6
Хувцас угаах	60.0	69.8	53.1	62.2
Хоол хийх	66.7	76.7	75.0	74.4
Гэр сахих	93.3	72.1	71.9	75.6
Ус зөөх	80.0	72.1	75.0	74.4
Түлээ мод бэлтгэх, зөөх	53.3	37.2	43.8	42.2
Түлээ мод хагалах	60.0	46.5	50.0	50.0
Чингэлэг/Лангуу/TҮЦ-нд суух	13.3	4.7	9.4	7.8
Мал хариулах	30.0	4.7	9.4	8.9
Зараалд гүйх	13.3	9.3	15.6	12.2
Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо	15	43	32	90

Айлд ус зөөдөг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийг зөөвөрлөж буй хэрэгсэл, сонгосон үзүүлэлтээр Хүснэгт 3.16-д харууллаа.

Айлд гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 68.7 хувь нь тэргэнцэрээр, 29.9 хувь нь гараар ус зөөдөг байна. Машин, мотоциклоор ус зөөдөг гэж 15-17 насны цөөхөн эрэгтэй хүүхдүүд хариулжээ. Усаа зөөдөг дундаж зай 617 метр байв. Энд сонирхуулахад ус зөөх зай холдох тусам тэргэнцэрээр зөөх хувь нэмэгдэж байна. Харин эсрэгээр ойртох тусам гараар усаа зөөдөг юм байна.

*Одийд 3.16. Айлд ус зөөдөг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, ус зөөвөрлөдөг хэрэгсэл, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Хэрэгсэл			Бүгд	Ус зөөдөг гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Тэргэнцэрээр	Гараар	Машин/ Мото- циклоор		
<b>Нас</b>					
6-11	75.0	25.0	-	100.0	12
12-14	74.2	25.8	-	100.0	31
15-17	58.3	37.5	4.2	100.0	24
<b>Хүйс</b>					
Эрэгтэй	71.4	26.2	2.4	100.0	42
Эмэгтэй	64.0	36.0	-	100.0	25
<b>Зай</b>					
500 метр хүртэл	66.7	33.3	-	100.0	33
500-1000 метр	67.9	28.6	3.6	100.0	28
1000 метрээс дээш	83.3	16.7	-	100.0	6
<b>Бүгд</b>	<b>68.7</b>	<b>29.9</b>	<b>1.4</b>	<b>100.0</b>	<b>67</b>

Харин айлд түлээ зөөдөг хүүхдүүдийн 44.7 хувь нь тэргэнцэрээр, 50.0 хувь нь үүрч, 5.0 хувь нь машинаар зөөвөрлөдөг ажээ (Хүснэгт 3.17).

*Одийд 3.17. Айлд түлээ зөөдөг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, түлээ зөөвөрлөдөг хэрэгсэл, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Хэрэгсэл			Бүгд	Айлд түлээ зөөдөг хүүхдийн тоо
	Тэргэнцэрээр	Үүрч	Машинаар		
<b>Нас</b>					
6-11	62.5	37.5	-	100.0	8
12-14	18.8	75.0	6.3	100.0	16
15-17	64.3	28.6	7.1	100.0	14
<b>Хүйс</b>					
Эрэгтэй	50.0	42.9	7.1	100.0	28
Эмэгтэй	30.0	70.0	-	100.0	10
<b>Зай</b>					
500 метр хүртэл	35.0	60.0	5.0	100.0	20
500-1000 метр	55.6	33.3	11.1	100.0	9
1000 метрээс дээш	55.6	44.4	-	100.0	9
<b>Бүгд</b>	<b>44.7</b>	<b>50.0</b>	<b>5.3</b>	<b>100.0</b>	<b>38</b>

Хариултаас харахад дээр хэлсэнчлэн бисийн хүч шаарддаг ажил учраас хөвгүүд их зөөвөрлөдөг нь харагдаж байна. Түлээ зөөвөрлөдөг дундаж зай 1125 метр байна.

Хүүхдүүд, ялангуяа бага насын хүүхдүүд бороо, цас, халуун хүйтэн зэрэг цаг агаарын хэцүү хүнд нөхцөлд зөвшөөрсөн хэмжээнээс хүнд ачааг (ус, түлээ) холоос зөөж буй нь гэрийн үйлчлэгчийн ажил хүүхдүүдийн хувьд хүнд нөхцөлтэй хөдөлмөр гэж тооцогдохоор байна.

### 3.2.3 Ааёй ёхийн үзүүлэлт

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг тодорхойлох нэг үзүүлэлт бол ажлын цагийн үргэлжлэх хугацаа юм. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын (ОУХБ) зөвлөмжөөр долоо хоногт ажлын нөхцлөөс үл хамааран 43 болон түүнээс дээш цагаар хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамааруулдаг байна.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн ажлын үргэлжлэх хугацааг Хүснэгт 3.18-д харуулав.

Гэрийн үйлчлэгч эрэгтэй хүүхдүүдийн дийлэнх нь өглөө 8-9 цагт, эмэгтэй хүүхдүүдийн дийлэнх нь 10 цагаас хойш ажлаа эхэлдэг гэж хариулжээ. Гэвч өглөө 8 цагаас өмнө ажлаа эхэлдэг хүүхдүүдийн хувь багагүй (14.4 хувь) байна. Хүүхдүүд орой ажлаа дунджаар 19 цагт дуусдаг гэжээ. Өдрийн ажлын үргэлжлэх дундаж хугацаа 5 цаг 20 минут гарлаа. Гэхдээ өдөрт 9 ба түүнээс дээш цаг ажилладаг хүүхдүүд нийт судалгаанд хамрагдагсдын 13.3 хувийг эзлэж байгаа бөгөөд ялангуяа, хамаатан бус айлд ажиллаж байгаа хүүхдүүдийн хувьд энэ үзүүлэлт бусдаас өндөр, 26.9 хувьтай байна.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүд дунджаар долоо хоногт 6 өдөр ажилладаг ба 7 хоног амралтгүй ажилладаг хүүхдүүд нийт хүүхдүүдийн 65.6 хувийг эзэлж байгаа юм. Эндээс үндэслэн тооцож үзэхэд гэрийн үйлчлэгч хүүхэд дунджаар 7 хоногт 30 гаруй цаг хөдөлмөрлөдөг байна. Энэхүү дундаж тооцоогоор хүүхдүүдийн тодорхой хэсэг нь ОУХБ-ын зөвлөмжинд зааснаас олон цагаар, өөрөөр хэлбэл, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт тооцогдох нөхцөл байдалд<sup>12</sup> ажиллаж байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн 5-р бүлгийн 71.1-д “Долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насын ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насын ажилтанд 36 цаг хүртэл байна” гэсэн заалт судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувьд зөрчигдэж, илүү цагаар хөдөлмөрлөх тохиолдол цөөнгүй байна.

<sup>12</sup> ОУХБ, 2004. Монгол дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, 2002-2003, судалгааны тайлан, Улаанбаатар

*Өжүййэж 3.18.* Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, хүйс болон ажлын цагийн ногдоор

Цагийн ногдол	Хүйс		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Өглөө ажил эхэлдэг цаг			
8 цагаас өмнө	13.7	15.4	14.4
8-9 цагт	49.0	33.3	42.3
10 цагаас хойш	37.3	51.3	43.3
<i>Аёйääæ</i>	<i>9.59</i>	<i>10.00</i>	<i>9.77</i>
Орой ажил дуусдаг цаг			
17 цаг ба түүнээс өмнө	21.6	28.2	24.4
18-19 цагт	35.3	12.8	25.6
20 цаг ба түүнээс хойш	43.1	59.0	50.0
<i>Аёйääæ</i>	<i>18.59</i>	<i>18.74</i>	<i>18.66</i>
Өдрийн ажлын дундаж хугацаа			
3 хүртлэх цаг	31.4	30.7	31.2
4-6 цаг	39.2	43.6	41.1
7-8 цаг	17.6	10.3	14.4
9 ба түүнээс дээш цаг	11.8	15.4	13.3
<i>Аёйääæ</i>	<i>5.12</i>	<i>5.31</i>	<i>5.20</i>
7 хоногт ажилладаг өдөр			
2-оос цөөн өдөр	2.0	10.3	5.6
3-5 өдөр	19.6	23.1	21.1
6 өдөр	5.9	10.3	7.8
7 өдөр	72.5	56.3	65.5
<i>Аёйääæ</i>	<i>6.37</i>	<i>5.82</i>	<i>6.13</i>
Айлд жилд ажилладаг хугацаа			
1-4 сар	7.8	10.3	8.9
5-8 сар	2.0	5.1	3.3
9-12 сар	90.2	84.6	87.8
<i>Аёйääæ</i>	<i>10.90</i>	<i>10.59</i>	<i>10.77</i>
Бүгд	100.0	100.0	100.0
Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо	51	39	90

Одоо гэрийн үйлчлэгч хүүхдүүдийг ажил олгогч шөнийн цагаар ажиллуулдаг эсэх талаар авч үзье (Хүснэгт 3.19).

Хүүхдүүдийн 14.4 хувь нь шөнө болон оройн цагаар заримдаа ажиллуулдаг гэж хариулжээ. Шөнө, оройн цагаар судалгаанд хамрагдсан хүүхдүүд нас харгалзахгүйгээр (6-11 насны хүүхдүүдийн 6.7 хувь нь энэ хариултыг өгсөн) ажилладаг нь хүснэгтээс харагдаж байна. Харин 15-17 насны хүүхдүүдийн 25.0 хувь, хамаатан бус айлд ажилладаг хүүхдүүдийн 30.8 хувь нь шөнө оройн цагаар ажилладаг гэж хариулсан нь хамгийн өндөр хувьтай байв. Хүүхдүүд ажил олгогчийн гэрт гэнэтийн яаралтай ажил гарсан тохиолдолд, түлээ бэлтгэх, хагалах, гэр

дулаацуулахаар, мөн хүүхдийг нь харах хүнгүй тохиолдолд шөнө ажиллаж хонодог гэжээ. Тэд шөнө хамгийн бага нь 1 цаг, хамгийн их нь 4 цаг ажилладаг юм байна.

*Ӧзүйүүд 3.19.* Гэрийн үйлчилгэч хүүхдүүдийн хувийн жин, шөнийн цагаар ажиллуулдаг эсэх, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Шөнийн цагаар ажиллуулдаг		Бүгд	Гэрийн Үйлчлэгч хүүхдийн тоо
	Заримдаа	Эсэх Ажиллуулдаггүй		
<b>Нас</b>				
6-11	6.7	93.3	100.0	15
12-14	9.3	90.7	100.0	43
15-17	25.0	75.0	100.0	32
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	11.8	88.2	100.0	51
Эмэгтэй	17.9	82.1	100.0	39
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг</b>				
<b>эсэх</b>				
Хамт амьдардаг	22.2	77.8	100.0	45
Хамт амьдардаггүй/Өнчин	6.7	93.3	100.0	45
<b>Ажиллаж буй айл нь ямар</b>				
<b>хамааралтай болох</b>				
Өвөө, эмээ, ах, эгч	10.6	89.4	100.0	47
Бусад хамаатан	-	100.0	100.0	17
Хамаатан бус	30.8	69.2	100.0	26
<b>Бүгд</b>	<b>14.4</b>	<b>85.6</b>	<b>100.0</b>	<b>90</b>

Àéëä àì üääàðäää ãýðèéí /éë-ëýä- ð/ ; ðääèéí àæëüí íýä oäoð

<sup>a</sup> ǣoo ëõýá÷ëýí 8 öääò áîñäíã, õýðâýý õçõõýä 1ü ýðò áîñâi ë i ýäýýæ äääàää  
ë áîñäíã Õýäýýá ýöýã, ýó 1ü àæèëääà ýâåòäàð 1ü õçõõäééä 1ü õäðäääã. Õíîë öäéä 1ü  
óóëääæ eäççéíý, õóäöñûä 1ü óääàíà, áýð öýâýðéýíý, ñäeõëíä ãäðääääã. Õýäýýä ë  
°äðèéí õíîë öõéæ eäççëñíéé ääðääà óí òooëäääã. Óí òäæ áàéö õíîðíä 1ü áÿäà  
òäåäàäà óääàäàäàä 1ðíéí õíîëüä 1ü áýëääýã. Áýðèéí õý 1ü ëõýá÷ëýí 1ðíéòäíã ó÷ðäàñ  
çöðäàäò ÷ ççýõ çäâ ääðäääãçé. Í ðíé 23 öääò óí òäàäã. Äîëíî õíííäò 2 óääà óñäáä  
ýääääã.

(ÑÒÄ, Ý, 16 ÍàñÒàé, ýì ýãÒýé)

Àéëä àì üääàðääää; é ãýðèéí ;ééë÷ëýä÷ õ; ;õääééí àæëüí íýä oäoð

<sup>a</sup>ǣeōo 7 öàãò áiñäiã. Öýäýä 8 öàã áyöýä àǣēē öèééäýäýä àééäàà ï÷äiã. Í ïiä ä òýð  
àééüí ïð, äýðèéä íü ööðäààæ äýðèéä öýáýðéýäýä. <sup>a</sup>ǟōð öççöäýä íü öiñiê öíá öèéæ  
ōāōä öýð àééüí áçö öçíèé ööâöàñ ööíàðûñ íü öåâàäàä. Äàðàà íü öjéýý öåâàäéíà.  
<sup>a</sup>ǟōð áçð ööâàä 16 öäãò ííññéöiã 1ü ï÷èæ öñ àâäàä. Öýäýä è íðíéí öiñiê öèéäýä  
äýý. Í ðíé àÿäà öàââèéä 1ü öåâàäæ öàâü÷èöâàä åâéüñ íü ñâéí öjéæ ōāōä íðíé 22

*öàä öíäoðooäooä äýðòýý öàðüäää. Çàðèì ääà äýðèéíöýí íü èö íðîéòåîë öýíäýý öîíäää.*

*(ÑÖÄ, Ä, 15 íàñòàé, ýì ýãòýé)*

Нийт ард иргэд хуулинд зааснаар амралт баяр ёслолын үеэр амрах эрхтэй атал судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 46.7 хувь нь дээрх өдрүүдэд амардаггүй гэсэн хариултыг өглөө (Хүснэгт 3.20). Ялангуяа, өвөө, эмээ, ах, эгчийндээ ажилладаг хүүхдүүдийн дээрх хариултын хувь бусад хамаатан эсвэл хамаатан бус айлд ажилладаг хүүхдүүдийнхээс өндөр байгаа нь нэлээд анхаарал татаж байна.

Амралт баяр ёслолын өдрүүдэд амардаггүй гэж хариулсан хүүхдүүдийн 66.7 ажлын жирийн өдрийнхөөс ачаалал нэмэгддэг, 29.6 хувь ачаалал нэмэгдэдгүй хэвээрээ байдаг, 4.7 хувь нь ачаалал багасдаг гэж хариулав.

*Öðüüð 3.20. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, амралт, баяр ёслолоор амардаг эсэх, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Амралт баяр ёслолын өдрүүлэлд амардаг эсэх				Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Амардаг	Зөвхөн нийтийн амралтын өдрүүдэд амардаг	Зөвхөн Бямба, Ням гаригт амардаг	Амар- даггүй		
<b>Нас</b>						
6-11	6.7	40.0	-	53.3	100.0	15
12-14	25.5	23.3	7.0	44.2	100.0	43
15-17	25.0	25.0	3.1	46.9	100.0	32
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	15.7	27.5	5.8	51.0	100.0	51
Эмэгтэй	30.8	25.6	2.6	41.0	100.0	39
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>						
Хамт амьдардаг	26.7	20.0	6.7	46.6	100.0	45
Хамт амьдардаггүй/ Өнчин	17.8	33.3	2.2	46.7	100.0	45
<b>Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох</b>						
Өвөө, эмээ, ах, эгч	10.6	29.8	2.1	57.5	100.0	47
Бусад хамаатан	35.3	35.3	5.9	23.5	100.0	17
Хамаатан бус	34.6	15.4	7.7	42.3	100.0	26
	22.2	26.7	4.4	46.7	100.0	90
<b>Бүгд</b>						

### 3.3 Хөдөлмөрийн хөлс ба зарцуулалт

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хөдөлмөрийг хэрхэн үнэлж байгаа талаар энэхүү хэсэгт авч үзэх болно. Судалгааны үр дүнгээс харахад гэрийн үйлчлэгчийн ажил хүүхдийн хөдөлмөрийн бусад хэлбэрийг бодвол орлогын хувь маш доогуур, тэр битгий хэл нарийн тогтооход бэрхшээлтэй, зарим тохиолдолд ажлын хөлс аваад байдаггүй, ажил олгогчоос хараат байдалд байна.

Ер нь томчуудын ч гэсэн гэрийн хөдөлмөрийг өнөөг хүргэл үнэлдэггүйтэй адил, хүүхдийн гэрийн үйлчлэгчийн хөдөлмөр нь хамгийн үнэлгээгүй хөдөлмөр юм байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 44.4 хувь айлд гэрийн үйлчлэгч хийгээд ажлын хөлсөө мөнгөн хэлбэрээр авдаг бол, 48.9 хувь нь мөнгөн бус хэлбэрээр, 6.7 хувь нь юу ч авдаггүй ажээ (Хүснэгт 3.21).

Хүснэгтээс харахад нас ахих тусам ажлын хөлсөө мөнгөн хэлбэрээр авдаг хувь нэмэгдэж, эсрэгээр нас багасах тусам мөнгөн бус хэлбэр, мөн хөлсгүй ажилладаг, хувь нэмэгдэж байна. Ажлын хөлсөө мөнгөн хэлбэрээр авдаг хүүхдүүдийн дотор эцэг, эхтэйгээ хамт амьдардаг хүүхдүүдийн авч буй хувь эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй/өнчин хүүхдүүдээс 2.3 дахин өндөр байв. Мөн хамаатан бус айлд ажил эрхэлдэг хүүхдүүдийн мөнгөн хэлбэрээр ажлын хөлсөө авдаг хувь ойрын болон холын хамаатныдаа ажилладаг хүүхдүүдийнхээс өндөр байна.

**Одийн 3.21.** Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, ажлын хөлс авдаг хэлбэр, сонгосон узүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Төлбөрийн хэлбэр			Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Мөнгөн	Мөнгөн бус	Төлбөр өгдөггүй		
<b>Нас</b>					
6-11	26.7	60.0	13.3	100.0	15
12-14	44.2	46.5	9.3	100.0	43
15-17	53.1	46.9	-	100.0	32
<b>Хүйс</b>					
Эрэгтэй	47.1	43.1	9.8	100.0	51
Эмэгтэй	41.0	56.4	2.6	100.0	39
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>					
Хамт амьдардаг	62.2	33.3	4.4	100.0	45
Хамт амьдардаггүй/	26.7	64.4	8.6	100.0	45
<b>Өнчин</b>					
Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох					
Өвөө, эмээ, ах, эгч	34.0	55.3	10.7	100.0	47
Бусад хамаатан	35.3	64.7	-	100.0	17
Хамаатан бус	69.2	26.9	3.8	100.0	26
Бүгд	44.4	48.9	6.7	100.0	90

Мөнгөн хэлбэрээр ажлынхаа хөлсийн авдаг хүүхдүүдээс сүүлийн 12 сард хичнээн төгрөгийн ажлын хөлс авсныг Хүснэгт 3.21-т үзүүлэв.

Хүүхдүүдийн жилийн дундаж ажлын хөлсийг тооцож үзэхэд 134312 төгрөг ( $1\$=1219$  төг) гарав. Өөрөөр хэлбэл, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг бүтэн 12 сар ажилласан гэж тооцоолвол сард дунджаар 11 мянган төгрөг байна гэсэн үг. Мэдээж энэ бол маш баримжаалсан тооцоо юм.

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор 2004 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 40000 төгрөгөөр тогтоосон. Гэтэл гэрийн үйлчлэгч хийдэг хүүхдүүдийн ажлын хөлс (ажлын хөлс авдагтүй хүүхдүүд бас байгаа) үүнээс хэд дахин доогуур, хамгийн бага хөлстэй ажил болох нь харагдаж байна. Хүүхдийн нас бага байх тусам авдаг ажлын хөлсний хэмжээ багасаж байна.

*Одийн 3.22. Бэлэн мөнгөөр хөлс авдаг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, өнгөрсөн 12 сард авсан ажлын хөлсний хэмжээ, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Жилд авдаг ажлын хөлсний хэмжээ			Бүгд	Бэлэн мөнгөөр хөлс авдаг гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	40000 хүргэл	40000- 120000 хүргэл	120000 ба дээш		
Нас					
6-11	50.0	50.0	-	100.0	4
12-14	36.8	36.8	26.4	100.0	19
15-17	35.3	23.6	41.1	100.0	17
Хүйс					
Эрэгтэй	45.8	25.0	29.2	100.0	24
Эмэгтэй	25.0	43.8	31.1	100.0	16
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх					
Хамт амьдардаг	39.3	35.7	25.0	100.0	28
Хамт мъдардаггүй/ өнчин	33.3	25.0	41.7	100.0	12
Бүгд	37.5	32.5	30.0	100.0	40

Хүүхдүүд олсон орлогынхoo дийлэнхийг (60.0 хувь) гэрийнхээ амьдралд нэмэр болох гэж өгдөг нь Хүснэгт 3.23-аас харагдаж байна. Давхардсан тоогоор карманы мөнгөндөө (35.0 хувь), өөртөө хувцас худалдаж авахад (32.5 хувь), хоол авахад (22.5 хувь) хичээлийн хэрэгсэл авахад (20.0 хувь) тус тус зарцуулдаг гэжээ.

Мөнгө зарцуулалтыг нас, хүйсээр харахад нэлээд ялгаатай байна. Бага насны хүүхдүүд олсон мөнгөнийхээ ихэнхийг гэрийнхэндээ болон хармааны мөнгө, чихэр жимсэнд өгдөг бол томчуул нь гэрийнхэндээ болон өөртөө хувцас авахад зарцуулдаг байна. Охид хөвгүүдийг бодвол сургуулийн хэрэгсэл авах болон хармааны мөнгөндөө илүүтэй зарцуулж байна. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн авдаг ажлын хөлсний хэмжээ мөнгө зарцуулалттай нэлээд хамааралтай байна. Тухайлбал, жилийн ажлын хөлсний хэмжээ 120 мянган төгрөгөөс дээш болоход гэрийнхэндээ мөнгө нэмэрлэдэг гэж хэлсэн хүүхдүүдийн хувь өндөр болж байна. Харин эдгээр хүүхдүүдээс хичээлийн хэрэгсэл авахад зарцуулсан гэсэн хариулт огт гарсангүй. Магадгүй эдгээр хүүхдүүд сургуульд суралцдаггүй байж болох юм.

*Өгүйдэл 3.23.* Бэлэн мөнгөөр хөлс авдаг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, ажлын хөлсөө зарцуулж буй байдал, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Ажлын хөлс/Орлогоо зарцуулж буй байдал							Бэлэн мөнгөөр хөлс авдаг гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Түрээ- сийн төлбөр	Хичээлийн хэрэгсэл Авах	Гэрийн- хэндээ нэмэр- лэдэг	Хармааны мөнгө (тамхи, чихэр, жимс авдаг)	Өр зээл төлдөг	Өөртөө хувцас авдаг	Өөртөө хоол авдаг	
<b>Нас</b>								
6-11	-	25.0	50.0	25.0	-	-	-	4
12-14	5.3	21.1	47.4	57.9	-	21.1	21.1	19
15-17	-	17.6	70.6	52.9	11.8	52.9	29.4	17
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	-	2.0	58.3	25.0	8.3	33.3	33.3	24
Эмэгтэй	6.3	18.8	62.5	50.0	6.3	31.3	6.3	16
<b>Жилд авдаг ажлын хөлсний хэмжээ</b>								
40000 хүртэл	-	33.3	46.7	20.0	6.7	20.0	40.0	15
40000-120000 хүртэл	7.7	23.1	46.2	53.8	7.7	30.8	-	13
120000 ба дээш	-	-	83.3	66.7	8.3	50.0	25.0	12
<b>Бүгд</b>	<b>2.5</b>	<b>20.0</b>	<b>60.0</b>	<b>35.0</b>	<b>7.5</b>	<b>32.5</b>	<b>22.5</b>	<b>40</b>

Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй

Ер нь нийт мөнгөн болон мөнгөн бус орлогоосоо гэрийнхэндээ өгдөг эсэхийг асуухад гэрийн үйлчлэгч хийдэг хүүхдүүдийн 48.8 хувь нь өгдөггүй гэж хариулсан. Өгдөггүй гэсэн хариулт эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй (75.6 хувь) бага насны (69.2 хувь), эмэгтэй (52.6 хувь), шилжигч (61.1 хувь) хүүхдүүдийн дунд өндөр байна (Хүснэг 3.24).

Зөвхөн мөнгөн хэлбэрээр ажлынхаа хөлсийг авдаг гэж хариулсан 40 хүүхдүүдийн гэрийнхэндээ мөнгө өгдөг байдлыг харвал, ажлын хөлс бага авдаг хүүхдүүдийн гэрийнхэндээ мөнгө өгдөггүй гэсэн хариулт бусдаас өндөр байна.

Ажил олгогчид хүүхдүүдэд ажлын хөлсийг (мөнгөн болон мөнгөн бус) ихэвчлэн өдөр бүр (35.7 хувь), сард нэг удаа (27.5 хувь) өгдөг гэсэн хувь бусад хариултаас өндөр байлаа. Гэвч жилд (7.1 хувь), хагас жилд (8.3 хувь), улиралд (9.5 хувь) 1 удаа өгдөг гэсэн хариултын хувь багагүй байна.

Ажил олгогчид мөнгөн бус хэлбэрээр давхардсан тоогоор хүүхдүүдийн 84.1 хувьд хоол хүнс, 77.3 хувьд хувцас, 43.2 хувьд хичээлийн хэрэгсэл өгдөг юм байна. Энд сонирхуулахад ажил олгогчид урам хайрладаг гэсэн хариулт 2 байв.

*Одийн үйл 3.24. Мөнгөн/мөнгөн бус хэлбэрээр ажлын хөлс авдаг хүүхдүүдийн хувийн жин, орлогоо гэрийнхэндээ өгч буй эсэх, сонгосон узүүлэлт, хувиар*

Сонгосон узүүлэлт	Ажлын хөлс/Орлогоос гэрийнхэндээ өгдөг эсэх		Бүгд	Хөлс авдаг гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Өгдөггүй	Өгдөг		
<b>Нас</b>				
6-11	69.2	30.8	100.0	13
12-14	53.8	46.2	100.0	39
15-17	34.4	65.6	100.0	32
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	45.7	54.3	100.0	46
Эмэгтэй	52.6	47.4	100.0	38
<b>Шилжилтийн байдал</b>				
Шилжигч	61.1	38.9	100.0	18
Шилжигч бус	45.5	54.5	100.0	66
<b>Эцэг эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>				
Хамт амьдардаг	23.3	76.7	100.0	43
Хамт амьдардаггүй/Өнчин	75.6	24.4	100.0	41
<b>Жилд авдаг ажлын хөлсний хэмжээ*</b>				
40000 хүртэл	26.7	73.3	100.0	15
40000-120000 хүртэл	7.6	92.3	100.0	13
120000 ба дээш	8.3	91.7	100.0	12
<b>Бүгд</b>	<b>48.8</b>	<b>51.2</b>	<b>100.0</b>	<b>84</b>

Тайлбар\* Зөвхөн ажлын хөлс авдаг 40 хүүхдийн хувьд тооцов.

### 3.4 Хөдөлмөрийн харилцаа ба хүүхдүүдэд тохиолдож буй бэрхшээл

Гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүд Хөдөлмөрийн тухай Монгол улсын хуулийн дагуу хөдөлмөрийн харилцааг албан ёсоор үүсгэхгүй, тодруулбал, хөдөлмөрийн гэрээ хэлцэл байгуулахгүйгээр хөдөлмөр эрхэлж байна. Үнэндээ тэд нарын хувьд хөдөлмөрийн гэрээ гэж юу байдал, хэнтэй байгуулах, хэнээс дэмжлэг авах хэнээр өөрийгөө хамгаалуулах вэ гэдэг талаар наад захын ойлголт, мэдлэг байхгүй, нөхцөл боломж ч алга байна. Хүүхдүүдийн хувьд ямар ч хамаагүй ажил хийж хэдэн төгрөг олох нь л тэдний гол зорилго болж байна. Иймээс ч хөдөлмөрийн хөлсөө тогтмол олж авч чадахгүй, эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохироод үлдэх тохиолдол цөөнгүй гардаг байна.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүд ажил олгогчтой гэрээ байгуулсан эсэх талаар Хүснэгт 3.25-д харуулав.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 86.7 хувь нь ажил олгогчтойгоо хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ажиллаж байна. Насны бүлгээр авч үзэхэд 6-11 насныхан хөдөлмөрийн гэрээг бичгээр болон аман гэрээний аль алиныг байгуулаагүй ажиллаж байгаа бөгөөд энэ нь хөдөлмөрийн гэрээ байгуулах эрх зүйн ямар ч үндэсгүй юм. Харин 15-17 насны хүүхдүүдийн хувьд хөдөлмөрийн гэрээ байгуулах эрх зүйн үндэстэй бөгөөд тэдний дөнгөж 3.1 хувь нь бичгээр, 15.6 хувь аман гэрээ байгуулжээ. Хүснэгтээс харахад нас ахих тусам гэрээ байгуулсан хувь нэмэгдэж байна. Мөн охидууд, шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдүүдийн гэрээний талаарх мэдлэг бусдаас өндөр байна.

*Одийн үзүүлэлтээр хүүхдүүдийн хувийн жин, ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан эсэх, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Гэрээ байгуулсан эсэх			Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Бичгээр гэрээ байгуулсан	Аман гэрээ байгуулсан	Гэрээ байгуулаагүй		
<b>Нас</b>					
6-11	-	-	100.0	100.0	15
12-14	-	14.0	86.0	100.0	43
15-17	3.1	15.6	81.3	100.0	32
<b>Хүйс</b>					
Эрэгтэй	-	2.0	98.0	100.0	51
Эмэгтэй	2.6	25.6	71.8	100.0	39
<b>Шилжилтийн байдал</b>					
Шилжигч	5.3	21.1	73.6	100.0	19
Шилжигч бус	-	9.9	90.1	100.0	71
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>					
Хамт амьдардаг	-	15.6	84.4	100.0	45
Хамт амьдардаггүй/	2.2	8.9	88.9	100.0	45
Өнчин					
<b>Жилд авдаг цалингийн хэмжээ*</b>					
40000 хүртэл	-	6.7	93.3	100.0	15
40000-120000 хүртэл	-	23.1	76.9	100.0	13
120000 ба дээш	8.3	25.0	66.7	100.0	12
Бүгд	1.1	12.2	86.7	100.0	90

Тайлбар\* Зөвхөн цалин авдаг 40 хүүхдийн хувьд тооцов.


Мөнгөн хэлбэрээр ажлын хөлс авдаг хүүхдүүдийн ажлын хөлсний хэмжээ өндөр болох тутам бичгээр болон амаар гэрээ хийсэн хувь нэмэгдэж байна.

Ажил олгогчтой бичгээр болон амаар гэрээ байгуулсан хүүхдүүдээс гэрээний гол агуулгыг асуухад тогтсон хугацаанд бэлэн мөнгөөр ажлын хөлс төлөх, ажлын чанартай холбоотойгоор тохирсон хөлсийг өөрчлөх, хоол эд зүйлс авах гэсэн гэрээний нөхцлүүдийг оруулснаа ярьж байлаа. Зарим хүүхдүүд амрахгүй харихгүй, байшиг нь түрээслээд оронд нь ус авч өгч байна ч гэсэн гэрээг хийсэн байна. Мэдээж эдгээр гэрээний агуулга хэдийгээр гэрээ гэж хэлэхэд хэцүү боловч огт гэрээ хийгээгүй хүүхдүүдийг бодвол арай л дээр дэвшилтэй гэж хэлж болно. Гэхдээ ажил олгогчид гэрээгээ баримталдаггүй цаг хугацаандаа мөнгөө өгдөггүй тохиолдол нэлээд гардаг юм байна.

Хөдөлмөрийн хуулинд насанд хүрээгүй хүүхдийг 14-15 нааснаас эцэг эхийнх нь зөвшөөрлөөр, мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор, харин 16 нааснаас нь хүүхдийн эрүүл мэнд, ёс суртахуунд харшилахгүй ажилд хөдөлмөрийн гэрээ

байгуулж, холбогдох хөнгөлөлтийг үзүүлсний үндсэн дээр хөдөлмөр эрхлүүлж болохоор хуульчилж өгсөн боловч энэ нь амьдрал дээр хэрэгжихгүй байна.


Хүүхдүүдээс ажил олгогчид тэдэнтэй хэрхэн харьцаг талаар асуухад бараг ихэнх хүүхдүүд нас хүйс харгалзахгүйгээр сайн харьцаг (85.6 хувь) гэсэн хариултыг өгсөн юм. Сайхан харьцаг гэж үзэж байгаа гол шалтгаан нь хөвгүүдийн хувьд сайн хооллодог, хувцас хунаар өгдөг, хөлс өгдөг гэдгээр тодорхойлогдож байгаа бол охидуудын хувьд сайн хооллодог, хувцас өгдөг, гэртээ байлгадаг, сургуульд явуулдаг гэдгээр сайн харьцаг гэж дүгнэдэг юм байна (Зураг 3.4).



Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй

Харин ажил олгогч таагүй харьцаг гэж хариулсан хүүхдүүдээс шалтгааныг тодруулбал, хүйс харгалзахгүйгээр ашилж загнадаг, зоддог гэсэн хариултууд давамгайлж байлаа (Зураг 3.5).

**Соёлд 3.5 Ажил олгогч таатгүй харьцааг гэж үзж буй гэрийн  
үйлчлэгч хүүхдүүдийн хувь, хүйс болон шалтгаанаар**



Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй

Айлд амьдардаг гэрийн үйлчлэгч хүүхдүүд ажлаа бүрэн дуусгасан үед ажил олгогчийн зүгээс гэртээ харихыг нь зөвшөөрдөг эсэхийг асуухад хүүхдүүдийн 60.9 хувь зөвшөөрдөг, 8.7 хувь нь хааяа зөвшөөрдөг, 30.4 хувь нь зөвшөөрдөггүй гэсэн хариултыг өгөв. Харин амралт, баяр ёслолын үеэр ажил хүүхдүүдийн 68.2 хувийг гэртээ харихыг зөвшөөрдөг, 6.8 хувийг хааяа харихыг ажил олгогчид зөвшөөрдөг ажээ.

Ажил олгогчийн зүгээс хүүхдүүдэд ямар бэрхшээлүүд тулгардаг вэ гэхэд хэл амаар доромжилдог гэж хүүхдүүдийн талаас илүү хувь нь хариулсан юм (Хүснэгт 3.26).

**Одойд 3.26. Ажил олгогчийн зүгээс бэрхшээлтэй тулгарч байсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, хүйс ба ажил эрхэлж байхад тохиолддог бэрхшээлээр**

Шалтгаан	Хүйс			Нас			Бүгд
	Эрэгтэй	Эмэгтэй	6-11	12-14	15-17		
Айлын эзэн/эзэгтэй зоддог	17.6	23.1	40.0	11.6	21.9	20.0	
Хэл амаар доромжилдог	52.9	53.8	73.3	44.2	56.3	53.3	
Бэлгийн хүчирхийлд өртсөн	-	2.6	-	-	3.1	1.1	
Айлан сүрдүүлдэг	13.7	28.2	13.3	18.6	25.0	20.0	
Бага хоол өгдөг/Хоол өгөхгүй байдаг	9.8	12.8	13.3	7.0	15.6	11.1	
Бага хөлс төлдөг	9.8	12.8	20.0	4.7	15.6	11.1	
Хөлс төлбөр өгдөггүй	13.7	7.7	26.7	9.3	6.3	11.1	
Бүгд	51	39	15	43	32	90	

Түүнчлэн зоддог, айлан сүрдүүлдэг гэж хүүхдүүдийн нэлээд хувь нь хэлж байлаа. Ялангуяа, бага насны хүүхдүүдийг их зоддог, хөлс төлбөрийг нь бага төлдөг заримдаа бүр өгөхгүй байх тохиолдол ч гардаг нь судалгааны дүнгээс харагдлаа. Түүнчлэн гэрийн үйлчлэгч охидыг айлан сүрдүүлдэг, тэр битгийн хэл бэлгийн

хүчирхийлэлд оруулах тохиолдол гардаг байна. Энэ дашрамд судалгааны асуулгыг авахдаа бэлгийн хүчирхийлэл гэж юуг хэлдэг талаар судлаачдын зүгээс тайлбар хийж өгснийг энд дурдах нь зүйтэй. Эндээс Монголд гэрийн үйлчлэгчийн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн Хүүхдийн эрхийн Конвенцид заасан бараг бүх эрхүүд зөрчигдэж, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр илэрч байна гэсэн дүгнэлт гаргаж болно.

*Î èí èé àæéëæ áàéäà àéëñí ýçýí èõ óóðòàé. Áè òýäí èé 2-3 íàñí û 2 õçööäééä íü àñàðäää. Õçööýä óéëööééä àýæ àáí ääà çäáí àääää, áð öî ñðèæ ÷ àääää. Î "íàééä -èí ü "ä "õäçé àýæ ïçðäçééäýä.*

(ÓÁ, ÁÇÄ, Õ, 15 íàñòàé ýì ýäòýé)

*Àð íü àéëä àýðèéí çéë÷éýä÷ ñðèéöýä èõ õýöç áàéäàä. Õçööýä àñðàð ÷ áàñ áàéäçé. Õàí àééí õýöç íü òýäí èéõ áàéí àà àððè óóöäääàä. Òýäýä òýäí èéä èðñýí óéñóóä íàí àéä òíí áéäòýé áí èí ñðí ð ÷ òýðç í àø èõ íðí èääíä*

(ÓÁ, ÑÖÄ, Ý, 16 íàñòàé, ýì ýäòýé)

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн 3.3 хувь, тэдний эцэг, эхчүүдийн 6.7 хувь нь ажил олгогчид өртэй байна. Судалгааны явцад хүүхдийг өрийн барьцаанд тавин ажиллуулж байгаа явдал гарсан.

*Óðä íü áé "oð àéëä àæéëéäàä áàéñäí þì. Áýòýé òýð àéëñí ñðàí "oð àéëä "ðòýé áàéñí ààñ áí èæ íàí àéä "ðèéí ñðàä áàðñöäàí ä ýí ý àéëä àæéëéööéæ áàéí à.*

(ÓÁ, ÁÇÄ, Õ, 16 íàñòàé ýì ýäòýé)

Гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн цар хүрээ, холбоог тодорхойлох зорилгоор тэднээс гэрийн үйлчлэгч хийдэг өөр хүүхдүүдийг мэдэх үү гэж асуухад 32.2 хувь нь мэднэ гэж хариулсан ба нэг хүүхэд дунджаар 2 гэрийн үйлчлэгч хүүхдийг таньж байлаа. Судалгаанаас хүүхдүүд нийтдээ 61 гэрийн үйлчлэгчийн ажил хийдэг хүүхдүүдийг таньдаг гэсэн дүн гарсан. Мөн гэрийн үйлчлэгч хийж байгаа больсон хүүхдүүдийг мэдэх үү гэж асуухад хүүхдүүдийн 11.1 хувь нь мэднэ гэсэн хариултыг өглөө.

Хүүхдүүдийн 22.2 хувь нь гэрийн үйлчлэгчийн ажлын хажуугаар өөр ямар нэгэн ажил тухайлбал, гар дээрээс худалдаа хийх, зах дээр мод хагалах шуудайлах, микро автобусны кондуктор хийх, машин засаж, харах зэрэг ажлуудыг хийдэг ажээ. Тэд дээрх ажилдаа долоо хоногт дунджаар 3 өдрийг зориулдаг бөгөөд ихэвчлэн жилийн туршид хийдэг байна.

### 3.5 Хүүхдийн эрүүл мэнд ба хөдөлмөр хамгаалал

Айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа 6-14 насын хүүхдүүдийн гуравны хоёр нь ажиллаж байхдаа өвдсөн гэж хариулжээ. Хүйсээр авч үзвэл 6-11 насын эрэгтэй, 12-14 насын эмэгтэй хүүхдүүдийн өвчилсөн гэсэн хариултын хувь бусдаас өндөр байна (Хүснэгт 3.27).

*Одийн үйлчилгээний хүчинчлийн хувийн жин, хүйс, нас болон ажиллаж байхдаа өвдсөн эсэхээр*

Ажиллаж байхдаа өвдсөн эсэх	Эрэгтэй			Эмэгтэй			Бүгд		
	6-11	12-14	15-17	6-11	12-14	15-17	6-11	12-14	15-17
Тийм	72.7	56.5	29.4	50.0	80.0	66.7	66.7	67.4	46.9
Үгүй	27.3	43.5	70.6	50.0	20.0	33.3	33.3	32.6	53.1
Бүгд Гэрийн үйлчилгэч хүчинчлийн тоо	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
	11	23	17	4	20	15	15	43	32

Ажиллаж байх үедээ өвдсөн гэж хариулсан 6-11 насны хүчинчлийн 30 хувь, 12-14 насны хүчинчлийн 17.2 хувь 15-17 насны 33.3 хувь одоог хүртэл өвдсөөр байгаа гэж хариулжээ. Тэдний талаас илүү хувь нь эмнэлгийн тусlamж авч чадсан байна.

*Одийн үйлчилгээний хувийн жин, хүйс, нас болон сонгосон*

*үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Эрэгтэй			Эмэгтэй			Бүгд		
	6-11	12-14	15-17	6-11	12-14	15-17	6-11	12-14	15-17
Одоог хүртэл өвчтэй байгаа эсэх									
Тийм	37.5	15.4	40.0	-	18.8	40.0	30.0	17.2	33.3
Үгүй	62.5	84.6	60.0	100.0	81.2	60.0	70.0	82.8	66.7
Эмч, эмнэлгийн ажилтнаас зөвлөгөө, тусlamж авсан эсэх									
Тийм	75.0	46.2	60.0	100.0	56.3	50.0	80.0	51.7	53.3
Үгүй	25.0	53.8	40.0	-	43.7	50.0	20.0	48.3	46.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Ажиллаж байхдаа өвдсөн гэрийн үйлчилгэч хүчинчлийн тоо	8	13	5	2	16	10	10	29	15

Одоо хүртэл өвдөж байгаа өвчнийг тодруулбал, давхардсан тоогоор 84.6 хувь нь ханиадаар, 38.5 хувь нь толгойн өвчинөөр, 15.4 хувь нь хоолой, арьсны тууралт, гэдэсний өвчин, харшилаар тус бүр 7.7 хувь нь өвчилсөн байна.

Өвчилсөн хүчинчлийн 77.4 хувь нь өрхийн эмчээс, 19.4 хувь нь нарийн мэргэжлийн эмчээс, 3.2 хувь нь лам/бариачаас тусlamж авчээ. Энд сонирхол татсан үзүүлэлт бол хөвгүүд лам/бариачаас тусlamж срөөсөө авдаггүй, харин охид тусlamж авдаг нь судалгааны дүнгээс харагдлаа. Тусlamж авсан хүчинчлийн 67.7 хувь нь төлбөр төлөөгүй, 25.8 хувийнх нь төлбөрийг эцэг, эх, хамаатан садан нь хийсэн, харин 6.5 хувь нь төлбөрөө өөрөө хийжээ.

Эмнэлгийн тусlamж авч чадаагүй гэж хариулсан хүчинчлийн 39.1 хувь нь тусlamж авахыг хүсээгүй, 21.7 хувьд нь мөнгө байгаагүй, 17.4 хувийнх нь эцэг, эх өөрсдөө эм

уулгаж эмчилсэн, үлдсэн хувь нь эмнэлэг хол, карт байхгүй гэсэн шалтгааны улмаас тусlamж аваагүй байна.

Ажил хийж байхдаа хүүхдүүдийн 43.3 хувь нь ажлын хувцас өмсдөг гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүд хариулсан. Ажлын хувцасны төрлийг Хүснэгт 3.29-өөс харна уу.

*Одийн 3.29. Ажлын хувцас, хэрэгсэл өмсдөг гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувь, хувцасны төрөл, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Ажлын/Хамгаалалтын хувцасны төрөл					Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Дулаан хувцас	Бээлий	Малгай	Ороолт	Хормогч	
<b>Нас</b>						
6-11	16.7	83.3	50.0	16.7	-	6
12-14	43.8	93.8	56.3	25.0	-	16
15-17	23.5	70.6	35.3	35.3	5.9	17
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	38.1	85.7	61.9	28.6	-	21
Эмэгтэй	16.7	88.9	27.8	27.8	5.6	18
Бүгд	28.2	89.7	46.2	30.8	2.6	39

Давхардсан тоогоор ажлын/дулаан хувцас/хэрэгсэл өмсдөг хүүхдүүдийн дийлэнх буюу 89.7 хувь нь бээлий, 46.2 хувь нь малгай, 30.8 хувь нь ороолт, 28.2 хувь нь дулаан хувцас өмсдөг гэжээ. Энд дулаан хувцас, малгай өмсдөг гэж хариулсан хөвгүүдийн тоо охидынхаос ойролцоогоор 2 дахин өндөр байгаа нь хөвгүүд гадаах ажил их хийдэг, охидууд гэр зуурын ажил хийдэгтэй холбоотой болов уу. Хүүхдүүд өвөл бээлий байхгүй ус зөөхөд маш их даардаг гэж ярыцгааж байлаа.

Ажил хийж байгаа хүүхдүүд амьдралын тарчиг байдлаас болж өлмөн зэлмүүн явж, эрүүл мэндээр хохирох тохиолдол нэлээд гардаг. Ажлынхаа үеэр хүүхдүүдийн 22.2 хувь нь гертээ, 73.3 хувь нь ажил олгогчийндоо, 4.4 хувь нь гуанз хоолны газар хооллодог байна.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн өдөр иддэг халуун хоолны давтамжийг сонгосон үзүүлэлтээр Хүснэгт 3.30-д үзүүлэв.

Хүүхдүүдийн 52.2 хувь нь өдөрт 1 удаа, 36.7 хувь нь өдөрт 2 удаа халуун хоол иддэг гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзлэж байна. Энд сэтгэл эмзэглүүлсэн асуулт бол ид өсч байгаа хүүхдүүд, ялангуяа 6-11 насныхны өдөрт нэг удаа л халуун хоол иддэг гэж хариулсан хувь өндөр байгаа явдал юм. Өдөрт халуун хоол иддэгтүй гэж нийт хүүхдүүдийн 1.1 хувь нь хариулжээ.

*Огийн үзүүлэлт* 3.30. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, өдөрт иддэг халуун хоолны давтамж, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Өдөрт иддэг халуун хоолны тоо				Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Халуун хоол иддэгтүй	1 удаа	2 удаа	3 удаа		
<b>Нас</b>						
6-11	-	66.7	26.7	6.7	100.0	15
12-14	2.3	46.5	41.9	9.3	100.0	43
15-17	-	53.1	34.4	12.5	100.0	32
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	-	54.9	37.3	7.8	100.0	51
Эмэгтэй	2.6	48.7	35.9	12.8	100.0	39
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг сэх						
Хамт амьдардаг	-	57.7	35.6	6.7	100.0	45
Хамт амьдардаггүй/Өнчин	2.2	46.7	37.8	13.3	100.0	45
Бүгд	1.1	52.2	36.7	10.0	100.0	90

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдээс нэг удаагийн хоолондоо цаддаг уу гэж асуухад 19.1 хувь нь Үгүй цаддагтүй гэж хариулав. Энэ хариултыг 6-11 насныхан, эрэгтэй хүүхдүүд түлхүү хариулж байв. Судалгаа явагдахаас өмнө долоо хоногт хүүхдүүдийн 22.2 хувьд халуун хоол идэхгүй хонож байсан тохиолдол гарч байжээ. Тохиолдлын тоог авч үзэхэд тэр долоо хоногт эдгээр хүүхдүүд 2 өдөр хоол идээгүй байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 30 хувь нь шалан дээр, 5.6 хувь ганцхан хөнжилтэй, 1.1 хувь ганцхан гудастай, 11.1 хувь өөрт нь зориулсан тусдаа хөнжил гудасгүй тав тух муутай унтаж байна.

### 3.6 Дадал зуршил ба чөлөөт цаг

#### 3.6.1 I óó äàäàë, çóðøèë

Гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн дунд тамхи татаж, олсон хэдэн төгрөгөө үргүй зарцуулдаг хүүхдүүдийн тоо багагүй байна. Насны бүлгээр авч үзэхэд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй 12 ба түүнээс дээш насны бүх хүүхдүүдийн 10 гаруй хувь нь тамхи татаж байна. Ахь тамхи татаж эхэлсэн дундаж нас 11 байна (Хүснэгт 3.31).

*Одийн юйдаа 3.31. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, хүйс, нас болон дадал зуршилаар*

Дадал, зуршил	Эрэгтэй			Эмэгтэй			Бүгд		
	6-11	12-14	15-17	6-11	12-14	15-17	6-11	12-14	15-17
<b>Тамхи татдаг эсэх</b>									
Тийм	-	8.7	17.6	-	10.0	6.7	-	9.3	12.5
Үгүй	100.0	91.3	82.4	100.0	90.0	93.3	100.0	90.7	87.5
<b>Согтууруулах ундаа хэрэглэж үзсэн эсэх</b>									
Тийм	18.2	13.0	11.8	-	10.0	33.3	13.3	11.6	21.9
Үгүй	81.8	87.0	88.2	100.0	90.0	66.7	86.7	88.4	78.1
<b>Мансууруулах бодис хэрэглэж үзсэн эсэх</b>									
Тийм	-	4.3	-	-	5.0	6.7	-	4.7	3.1
Үгүй	100.0	95.7	100.0	100.0	95.0	93.3	100.0	93.3	96.9
<b>Бүгд</b>	<b>100.0</b>								
<b>Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо</b>	<b>11</b>	<b>23</b>	<b>17</b>	<b>4</b>	<b>20</b>	<b>15</b>	<b>15</b>	<b>43</b>	<b>32</b>

Согтууруулах ундааг 6-11 насны охид л бүгд хэрэглэж үзээгүй гэж хариулсан ба харин бусад насны бүлэгт хэрэглэж үзсэн гэсэн хувь багагүй байгааг хүснэгтээс харж болно. Согтууруулах ундаа анх хэрэглэж үзсэн дундаж нас 14 байна.

Мансууруулах бодис тодруулбал өвс, хар тамхи, бензинийг ч хэрэглэж үзсэн гэж хариулсан хувь цөөн боловч байна. Ялангуяа, хэрэглэж үзсэн гэж хариулсан охидын эзлэх хувийн жин хөвгүүдийнхөөс өндөр байгаа нь маш харамсалтай бөгөөд эмгэнэлтэй. Хэрэглэж үзсэн гэсэн хүүхдүүдийн давтамжийн дундаж 2 удаа байлаа.

Түүнчлэн сэргийлэх/цагдаад баригдаж/дуудагдаж байсан уу гэсэн асуултанд хөвгүүдийн 11.8 хувь, охидын 5.1 хувь нь тийм гэсэн хариултыг өгчээ. Сэргийлэх/цагдаад баригдаж/дуудагдсаны гол шалтгаан нь эрэгтэй хүүхдүүдийн хувьд: 16.7 хувь нь хулгай, 33.3 хувь нь зодоон, 50.0 хувь нь танхайн хэрэг байхад баригдаж/дуудагдсан 2 охины нэг нь танхай, нөгөө нь зөвшөөрөлгүй газар наймаа эрхэлснээс болжээ. Тэдний тал хувь нь цагдаагаас, үлдсэн тал хувь нь эцэг эх/ах эгчээсээ аиж байжээ.

Дээрх байдлаас хүүхдүүд өөрсдийнхөө чөлөөт цагийг зөв өнгөрөөж чадахгүй байна гэж дүгнэж болохоор байна. Энэ асуудлыг цаашид тодруулан авч үзье. Эрэгтэй хүүхдүүд чөлөөт цагаа ихэвчлэн гэртээ, гудамжинд, найз нөхдийндөө болон үзвэр үйлчилгээний газар өнгөрөөдөг бол эмэгтэй хүүхдүүд ихэвчлэн гэртээ, ажил олгогчийнхoo гэрт, үзвэр үйлчилгээний газар өнгөрөөдөг гэжээ. Ер нь хүүхдүүд эдгээр газруудад чөлөөт цагаа хэрхэн өнгөрөөдөг вэ гэсэн асуултанд давхардсан тоогоор 53.3 хувь нь тоглодог, 28.9 хувь нь гэрийнхэндээ тусладаг, 26.7 хувь нь тэнд өөр хүүхдүүд байдаг учраас гэж хариулжээ. Харин ажлын бус цагаар хүүхдүүд ихэвчлэн тоглож, телевизор үзэж, унтаж өнгөрөөдөг юм байна. Цөөн тооны хүүхдүүд бассейн, дугуйланд хамрагддаг ном уншдаг гэсэн хариултыг өгчээ.

Хүүхдүүдээс сонирхол хоббиг нь асуухад хөвгүүдийн 58.8 хувь нь спорт, 11.8 хувь хөгжим сонсох гэсэн бол охидын 30.8 хувь нь хөгжим сонсох, 20.5 хувь нь тоглоом тоглох ном унших, 12.8 хувь нь спорт сонирхдог гэсэн хариултууд хамгийн их хувийг эзлэж байв.

### *3.6.2 1 ýäéýä õàí äéàää, èdýýä¿éí õzþýë ýðì ýéçéýë*

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдээс ер нь сургуульд сурах ажил хийх боломжийн алийг сонгох вэ гэхэд нийт хүүхдүүдийн 86.7 хувь сургуульд сурна гэсэн хариултыг сонгосон (Хүснэгт 3.32). Эндээс хүүхдүүдийн дийлэнх нь амьдралын эрхээр ажил эрхэлдэг нь харагдаж байна.

*3.32. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, цаашдын сонголт болон сонгосон үзүүлэлтээр*


Сонгосон үзүүлэлт	Цаашдын сонголт		Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Сургуульд сурах	Ажил хийх		
<b>Нас</b>				
6-11	100.0	-	100.0	15
12-14	90.7	9.3	100.0	43
15-17	75.0	25.0	100.0	32
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	62.4	17.6	100.0	51
Эмэгтэй	92.3	7.7	100.0	39
<b>Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх</b>				
Хамт амьдардаг	82.2	17.8	100.0	45
Хамт амьдардаггүй/ Өнчин	91.1	8.9	100.0	45
<b>Шилжилтийн байдал</b>				
Шилжигч	94.7	5.3	100.0	19
Шилжигч бус	84.5	15.5	100.0	71
<b>Бүгд</b>	<b>86.7</b>	<b>13.3</b>	<b>100.0</b>	<b>90</b>

Насны бүлэг нэмэгдэх тутам сурна гэсэн сонголтын хувь багасаж, харин буурах тутам нэмэгдэж, 6-11 насны бүх хүүхдүүд боломж нь олдвол сурна гэсэн хариултыг өгчээ. Энэ хариултыг эрэгтэй хүүхдүүд эмэгтэй хүүхдүүдээс 29.9 пунктээр доогуур хариулав. Өөрөөр хэлбэл, охид хөвгүүдийг бодвол илүү сурах хүсэлтэй байна.

Судалгаагаар хүүхдүүдийн 75.6 хувь нь ер нь ажил хийх дуртай, 24.4 хувь нь ажил хийх дургүй гэж хариулсан. Нас, хүйсийн хульд онцын ялгаагүй байсан боловч ажил хийх дургүй гэж 6-11 насны хүүхдүүдийн хариулсан бусдаас бага байлаа.

Ажил хийх дуртай байгаа шалтгааныг Зураг 3.6-д харуулав.

**Соодлал 3.6 Ажил хийх дуртай гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, хүйс болон шалтгаанаар**



Ажил хийх дуртай гэж хариулагчдаас шалтгааныг тодруулбал, хөвгүүдийн хувьд өөрийн гэсэн мөнгөтэй болдог (30.0 хувь), гэрийнхэндээ тус дэм дэм болдог (22.5 хувь), ажил хийхэд урамтай/зүгээр сууснаас дээр (17.5 хувь) гэсэн хариултууд давамгайлж байхад, охидын хувьд ажил хийхэд урамтай байдаг/зүгээр сууснаас дээр (35.7 хувь), гэрийнхэндээ дэм болдог (28.6 хувь), өөрийн гэсэн мөнгөтэй болдог (17.8 хувь) гэсэн хариултууд давамгайлж байлаа. Насны бүлгээр авч үзэхэд 6-11 настай хүүхдүүдийн гэрийнхэндээ тус дэм болдог (40.0 хувь), 12-14 настай хүүхдүүдийн ажил хийхэд урамтай байдаг/зүгээр сууснаас дээр (29.5 хувь), 15-17 настай хүүхдүүдийн өөрийн гэсэн мөнгөтэй болдог (33.3 хувь) гэсэн хариултын хувь бусад хариултаас өндөр хувьтай байв. Ажил хийх дуртай гэж хариулсан хүүхдүүдийн эхний гурван гол шалтгааныг байр эзлүүлэхэд хөвгүүд, охидын аль аль нь дэс дугаар нь таарахгүй болохоос биш ижил гурван шалтгааныг сонгосон байна. Гэтэл насны бүлгээр хамгийн гол нэг шалтгааныг гаргахад мөн л эдгээр гурван шалтгааны хариулт хамгийн өндөр байлаа. Сонирхолтой нь тухайн насныхны сэтгэл зүйн онцлог, хэрэгцээнээс шалтгаалан өөр өөр байгаа явдал юм. Тухайлбал, бага насны хүүхдүүд гэрийнхэндээ л тус болохыг илүүтэй эрмэлзэдэг бол томрох тусмаа өөрийнхөө хэрэгцээг хангах зорилго тавьдаг нь харагдаж байна.

Тэгвэл ажил хийх дургүй гэж хариулсан хүүхдүүдийн шалтгааныг авч үзье (Хүснэгт 3.33).

*Огийн үзүүлэлт* 3.33. Ажил хийх дургүй гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, шалтгаан болон сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Шалтгаан			Бүгд	Ажил хийх дургүй гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Сургуульд сурч чаддаггүй	Энэ ажилдаа сонирхолгүй	Их ядардаг		
<b>Нас</b>					
6-11	-	40.0	60.0	100.0	5
12-14	11.2	44.4	44.4	100.0	9
15-17	37.5	25.0	37.5	100.0	8
<b>Хүйс</b>					
Эрэгтэй	18.2	36.4	45.4	100.0	11
Эмэгтэй	18.2	36.4	45.4	100.0	11
Бүгд	18.2	36.4	45.4	100.0	22

Ажил хийх дургүй гэж хариулсан хүүхдүүдийн 18.2 хувь нь сургуульд сурдаггүй учраас, 36.4 хувь нь энэ ажилдаа сонирхолгүй учраас, 45.4 хувь нь их ядардаг учраас ажил хийх дургүй гэж хариулжээ. Энд сонирхолтой нь хүйсийн хувьд ялгаагүй ижил, харин насны бүлгийн хувьд нас ахих тусам сургуульд сурдаггүй учраас ажил хийх дургүй гэсэн хариулт нэмэгдэж байна. Мөн анхаарал татсан зүйл бол 6-11 насны хүүхдүүд их ядардаг тул ажил хийх дургүй гэсэн хариултын хувь хамгийн өндөр байна. Дээрх байдлаас дүгнэхэд гэрийн үйлчлэгчийн хөдөлмөр эрхэлдэг бага насны хүүхдүүдийн хувьд хийж буй ажлын нөхцөл нь хүүхдийн нас, бие бялдарт тохирохгүй, хэт ачаалалтай байdag нь харагдаж байна.

Хүснэгт 3.34-т гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн ажил эрхлэлтийн талаарх хандлагыг сонгосон үзүүлэлтээр харуулав.

Одоогийн хийж буй ажил эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг эсэх талаар үзэл бодлыг нь асууж сонирхоход судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 26.7 хувь нь сөрөг нөлөөтэй, 73.3 хувь нь сөрөг нөлөөгүй гэж хариуллаа. Сөрөг нөлөөтэй гэж хариулагчдын тоо насны бүлэг нэмэгдэх тутам нэмэгдэж байгаа ба хөвгүүдийн хариулсан хувь охидынхоос 7.3 пунктээр доогуур байна.

Хүүхдүүдээс ажиллах бус сургуульд суралцах ёстой гэдгээ мэддэг үү гэж асуухад нийт хүүхдүүдийн 70.0 хувь мэднэ гэж хариуллаа. Энд бас л 6-11 насны хүүхдүүдийн мэднэ гэж хариулсан хувь бусдаас бага байв.

*Огийн үзүүлэлт* 3.34. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, ажил эрхлэлтийн хандлага, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Одоогийн хийж буй ажил		Ажиллах бус сургуульд суралцах ёстой гэдгээ мэддэг эсэх		Бүгд	Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо
	Эрүүл мэндэд нь сөрөг нөлөөтэй талаархи үзэл бодол	Сөрөг нөлөөтэй	Мэднэ	Мэдэхгүй		
Нас						
6-11	13.3	86.7	53.3	46.7	100.0	15
12-14	23.3	76.7	76.7	23.3	100.0	43
15-17	37.5	62.5	68.8	31.3	100.0	32
Хүйс						
Эрэгтэй	23.5	76.5	68.6	31.4	100.0	51
Эмэгтэй	30.8	69.2	71.8	28.2	100.0	39
Бүгд	26.7	73.3	70.0	30.0	100.0	90


Судалгааны асуулгад хүүхдүүдээс хөдөлмөр эрхлэх насын тухай хөдөлмөрийн хуулийн талаар хэр зэрэг мэдлэгтэй байдгийг тандах зорилгоор асуулт оруулсан юм (Хүснэгт 3.35).

*Огийн үзүүлэлт* 3.35. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, хуулиар ажил хийж болох насыг тодорхойлсон байдал, хүйсээр

Хуулиар ажил хийж болох доод насыг тодорхойлсон байдал	Хүйс		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
8 ба түүнээс доош	9.8	10.3	10.0
9-13	17.7	2.6	11.1
14-15	5.9	2.6	4.4
16	25.5	15.4	21.1
17 ба дээш	15.6	43.5	27.8
Мэдэхгүй	25.5	25.6	25.6
	100.0	100.0	100.0
Бүгд			
Гэрийн үйлчлэгч хүүхдийн тоо	51	39	90

Хүүхдүүдийн 25.6 хувь нь энэ асуултанд мэдэхгүй гэсэн хариулт өгсөн. Харин 10.0 хувь нь 8 ба түүнээс доош нас, 11.1 хувь нь 9-13 нас, 4.0 хувь нь 14-15 нас, 21.1 хувь нь 16 нас, 27.8 хувь нь 17 ба дээш насыг хүүхдийн хөдөлмөр эрхлэж болох нас гэж хариуллаа. Эндээс хүүхдүүд хөдөлмөр эрхлэх насыг талаар тун хангалтгүй мэдлэгтэй байдаг нь харагдаж байна. Түүнчлэн хүүхдүүд хөдөлмөр эрхлэх насыг цэрэг татлагын, сонгуульд оролцох, гэр бүл болох 18 настай эндүүрч ойлгох тохиолдол тухайлбал, охидын дунд их (35.9 хувь) байлаа. Эрэгтэй 4 хүүхдийн нэг, эмэгтэй 6 хүүхдийн нэг нь л зөв хариултыг өгсөн. Иймд хүүхдүүдийн хууль эрхийн мэдлэгийг дээшилүүлэх талаар албан албан бус сургалтын хүрээнд тодорхой хөтөлбөр боловсруулан сургах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Ингэснээр хүүхдүүд эрхээ ч мэддэг, үүргээ ч ухамсарладаг болон хүмүүжих учиртай.

Гэрийн үйлчлэгч хүүхдүүдээс амьдрахын тулд ирээдүйд ямар ажил хийж чадна гэж бодож байна вэ гэхэд тэдний дийлэнх нь буюу 75.6 хувь нь ХАА- бус ажил хийж чадна гэж хариуллаа. Ямар ч хамаагүй ажил хийнэ гэж хүүхдүүдийн 7.7 хувь нь хариулсан юм (Зураг 3.7).



Хүүхдүүдээс гэрийн үйлчлэгчийн ажил хийхийг ах, эгч, дүү, эсвэл найзууддаа санал болгох уу гэхэд тэдний 23.3 хувь нь санал болгоно гэж хариулсан юм. Энд санал болгоно гэж хариулсан охидын хувь хөвгүүдийнхээс 4 пунктээр өндөр байв. Хүүхдүүдийн 63.3 хувь нь, тодруулбал, хөвгүүдийн 60.8 хувь, охидын 66.7 хувь нь цаашид гэрийн үйлчлэгчийн ажлаа үргэлжлүүлэн хийнэ гэсэн бодолтой байлаа. Хэр удаан хугацаагаар гэрийн үйлчлэгч хийхээ ихэнх хүүхдүүд тодорхойлж чадахгүй байсан ба зарим нь сургууль төгстлөө, том болтлоо, насан туршдаа хийнэ гэсэн хариултуудыг өгч байлаа. Харин цаашид гэрийн үйлчлэгчийн ажлаа үргэлжлүүлэн хийхгүй гэж хариулсан хүүхдүүдийн дийлэнх нь суралцана гэж хариуллаа.

Хүүхдүүдээс том болоод ямар ажил хийдэг хүн болох вэ? гэж асуухад тэдний 6.7 хувь нь хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын албан тушаалтан, менежер, 42.2 хувь мэргэжилтэн, 7.8 хувь нь инженер техникийн ажилтан, 8.9 хувь нь үйлчилгээний ажилтан, 6.7 хувь нь хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан, 12.2 хувь нь машин/тоног төхөөрөмжийн операторч, угсралч, 12.2 хувь нь энгийн ажил мэргэжил, 3.3 хувь нь ямар ч хамаагүй цалинтай ажил хийхийг хүсч байна гэж хариуллаа.

Дээрх хариултаас хамгийн их давтамжтай нь хөвгүүдийн хувьд машин тоног төхөөрөмжийн операторч, угсралч, энгийн ажил мэргэжил байхад охидын хувьд дээд мэргэжил шаардах ажлууд байв.

Судалгаанд хамрагдсан 90 хүүхдийн 31 нь ямар нэгэн төрийн бус байгууллагаас тодорхой хэмжээний тусламж авч байжээ. Хүүхдүүдийн 91.1 хувь нь ийм төрлийн судалгаанд анх удаа хамрагдсан байна.

## **БҮЛЭГ 4. ХӨДӨӨД АЙЛД МАЛ МАЛЛАЖ, ГЭРИЙН ҮЙЛЧЛЭГЧИЙН АЖИЛ ХИЙЖ БАЙГАА ХҮҮХДҮҮД**

Энэ бүлэгт хөдөөд айлд мал маллаж буй болон гэрийн үйлчлэгч хийж байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг тодорхой харуулах болно. Хөдөөд гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй хүүхдүүдийн бодит байдал хотод гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдээс нэлээд ялгаатай юм. Монголын хөдөөгийн дийлэнх аймгуудад нүүдлийн мал аж ахуй чухал байр суурь эзэлдэг. Хүүхдүүд мал маллах үйл ажиллагаанд голдуу оролцохын зэрэгцээ *а́йд* сууц нь тэднийг гэр орны өдөр тутмын ажилд оролцох хэрэгцээг бий болгодог. *Өөрөөр* хэлбэл, тухайн хүүхэд өөрийн гэртээ эсвэл өөр айлд ажиллаж байгаагаас үл хамааран мал маллах болон гэр орны ажлуудад аль алинд л оролцож байдаг.

Хөдөөд гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй хүүхдүүдийн судалгааг Өвөрхангай, Ховд, Хөвсгөл гэсэн гурван аймагт сонгож явуулсан юм. Айлд маллаж буй хүүхдүүдийн шинж байдал, айлын мал маллахаас гадна тухайн айлын гэр орны ажилд зарцуулж буй цаг, тэдний хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн хөлс, хүүхдүүдийн эрүүл мэнд, боловсролын асуудлыг энд дэлгэрэнгүй авч үзэх болно.

#### **4.1 Айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн шинж байдал**

#### 4.1.1 *Ōjí àì ç̄jéí øèíæ áàéääë*

Сонгогдсон (Өвөрхангай, Ховд, Хөвсгөл) 3 аймгаас айлд мал маллаж буй 270 хүүхэд судалгаанд хамрагдсны 64,4 хувь нь эрэгтэй, 35,6 хувь нь эмэгтэй хүүхдүүд байв. Насны бүлгийн хувьд, хүүхдүүдийн 21,5 хувь нь 6-11 насны, 36.7 хувь нь 12-14 насны, 41.9 хувь нь 15-17 насны бүлэгт хамарагдаж байна.

Эдгээр хүүхдүүдийн дийлэнх нь (99 хувь) өөрийн төрсөн аймагтаа байгаа боловч 28,5 хувь нь төрсөн сумандaa бус өөр суманд амьдарч, ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан айлд мал малгаж буй 270 хүүхдүүдээс ердөө 8 эрэгтэй хүүхэд (3 хувь) судалгаанаас өмнөх таван жилийн хугацаанд одоогийн амьдарч буй аймгаасаа өөр аймагт амьдарч байжээ. Хамаатан саднаа бараадах (4 хүүхэд), ажил хийх (3 хүүхэд) гэсэн шалтгаанаар хүүхдүүд эцэг эх, эмээ өвөөгөө даган (3 хүүхэд ганцаараа шилжин ирснийг эс тооцвол) шилжих хөдөлгөөнд оролцсон байна.

Судалгаанд хамрагдсан мал маллаж буй хүүхдүүдийн 30 хувь нь өвөө, эмээ, ах, эгчийндээ, 41,9 хувь нь бусад хамаатныдаа, үлдсэн 28, 1 хувь нь хамаатан бус айлд ажиллаж байна. Насны бүлгийн хувьд, бага буюу 6-11 насны хүүхдүүд эмээ, өвөө, ах эгчийндээ (43.1 хувь), харин 12-14 насны хүүхдүүдийн хувьд хамаатан бус айлд (34.3), 15-17 насны хүүхдүүдийн бусад хамаатныдаа ажилладаг гэсэн хувь тус тус хамгийн өндөр байна.

#### *4.1.2 Айлд маллаж бий хүүхдийн хувьд эцэг эхийн хараа, хяналт нэн чухал юм. Учир нь хүүхэд тухайн айлдаа ажиллахын зэрэгцээ зарим нь тодорхой хугацаагаар тэндээ амьдарч байгаагаас эцэг эхийн халамж, анхаарал дор тэр бүр байж чадлагчай. Цаашилбал, айлд ажиллаж буй өнчин/хагас өнчин хүүхдүүдийн хувьд халамж анхаарал тавих эцэг, эх байхгүйгээс ажил олгогчдод хөндлөнгийн хяналт тавих, хүүхдийн эрхийг хамгаалах асуудал орхигдож болох юм. Магадгүй эдгээр нөхцөл байдал нь эргээд айлд ажиллаж, амьдарч байгаа хүүхдийг бусдаас илүү хараат, бусдын нөлөөнд өртөмтгий байдал бий болдгийг үгүйсгэх аргагүй юм. Иймд бид айлд маллаж бий хүүхдүүдийн төрсөн эцэг, эх нь амьд сэргүүн байгаа эсэхийг тодруулан асуусан бөгөөд үр дүнг Хүснэгт 4.1-д хүүхдийн хүйс болон насын бүлгээр харуулав.*

Нийт хүүхдүүдийн 76,7 хувийнх нь эцэг, эх хоёулаа амьд, харин 17,8 хувь нь хагас өнчин, 5,6 хувь нь бүтэн өнчин хүүхдүүд байна. Эндээс судалгаанд хамрагдсан айлд мал маллаж бий дөрвөн хүүхэд тутмын нэг нь өнчин/хагас өнчин<sup>13</sup> хүүхэд байна гэсэн үг юм. Хагас өнчин хүүхдийн дунд эцэг нь нас барсан хүүхдүүдийн (15,6 хувь) хувь болон хагас өнчин эмэгтэй хүүхдийн (20,8 хувь) хувь харьцангуй өндөр байна. Өрхийн гол тэжээгч нь нас барсан, өнчин хүүхдүүд айлд ажиллаж байгаа нь тэдгээр хүүхдүүдийг бусдаас илүү хамааралтай, илүү эмзэг, хүнд нөхцөлд оруулж болох талтай.

*Одийн 4.1 Айлд мал маллаж бий хүүхдүүдийн хувийн жин, эцэг, эхийн байдал, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Эцэг, эх хоёулаа нас барсан байдал	Өнчин			Бүгд	Айлд мал маллаж бий хүүхдийн тоо
		Хоёулаа нас барсан	Эцэг нас барсан	Эх нас барсан		
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	78,2	5,8	12,6	3,4	100,0	174
Эмэгтэй	74,0	5,2	20,8	-	100,0	96
<b>Нас</b>						
6-11	91,4	3,4	5,2	-	100,0	58
12-14	75,8	9,1	14,1	1,0	100,0	99
15-17	69,9	3,5	22,1	4,5	100,0	113
Бүгд	76,7	5,6	15,6	2,2	100,0	270

Айлд мал маллаж бий хүүхдүүдийн нас ахих тусам өнчин хүүхдүүдийн хувийн жин өсч байна. Өөрөөр хэлбэл, өнчин хүүхдүүдийн нас ахих тутам өрх гэртээ эдийн засгийн хувь нэмэр үзүүлэх, эсвэл эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох оролцооны түвшин нэмэгдэж байгааг судалгааны үр дүн харуулж байна. Тухайлбал, 6-11 насын хүүхдүүдийн 91,4 хувийнх нь эцэг эх амьд байхад, 15-17 насын хүүхдүүдийн 70 хүрэхгүй хувь л нь элэг бүтэн амьдарч байна.

<sup>13</sup> Төрсөн эцэг, эх нь хоёулаа эсвэл аль нэг нь нас барсан хүүхдүүдийг судалгаанд өнчин/хагас өнчин хүүхдүүд гэж тодорхойлов.

Эцэг эх нь хоёулаа амьд, эсвэл хэн нэг нь амьд байгаа хүүхдүүд айлд мал маллаж байгаа хэдий ч эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэхийг тодруулан Хүснэгт 4.2-оор харуулав.

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 44,7 хувь нь эцэг, эхтэйгээ, 14,9 хувь эцэг, эхийнхээ аль нэгтэй нь хамт амьдардаг гэжээ. Хэдийгээр бүтэн өнчин биш ч гэсэн эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй гэж хүүхдүүдийн 39,6 хувь нь хариулсан байна. Энэ нь айлд мал маллаж буй 5 хүүхэд тутмын нэг нь асран хамгаалагч буюу эцэг, эхийн өдөр тутмын хараа хяналтаас хол амьдарч байна гэсэн үг юм.

*Одийн 4.2 Айлд мал маллаж буй бүтэн өнчин бус хүүхдүүдийн хувийн жин, эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх, сонгосон узуулэлтээр*


Сонгосон Узуулэлт	Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх						Бүгд	Бүтэн өнчин бус хүүхдийн тоо
	Хоёулан- тай нь хамт	Зөвхөн зээжтэйгээ	Зөвхөн авттайгаа	Ээж, хойд эцэг	Аав, хойд эх	Хоёулантай нь хамт амьдардаггүй		
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	45,1	12,2	2,4	-	0,6	39,6	100,0	164
Эмэгтэй	44,0	14,3	1,1	1,1	-	39,5	100,0	91
<b>Нас</b>								
6-11	51,8	7,1	3,6	-	1,8	35,7	100,0	56
12-14	44,4	14,5	1,1	1,1	-	38,9	100,0	90
15-17	41,3	14,7	1,8	-	-	42,2	100,0	109
<b>Бүгд</b>	<b>44,7</b>	<b>12,9</b>	<b>2,0</b>	<b>0,4</b>	<b>0,4</b>	<b>39,6</b>	<b>100,0</b>	<b>255</b>

Судалгаанд хамрагдсан айлд мал малладаг нийт 270 хүүхдийн 116 нь буюу 43 хувь нь өөрийн гэртээ эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй гэжээ. Эдгээр хүүхдүүдийн 94 хувь нь мал малладаг айлдаа, үлдсэн 6 хувь нь сургуулийн дотуур байранд амьдарч байна (Хүснэгт 4.3). Насны бүлгээр авч үзвэл онц ялгаа байхгүй харин хүйсийн хувьд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, эрэгтэй хүүхдүүд бараг бүгд (99 хувь) мал маллаж буй айлдаа амьдарч байхад охидын 85 хувь нь айлдаа, үлдсэн 15 хувь нь дотуур байранд амьдардаг гэжээ.

*Одийн 4.3 Айлд мал маллаж буй эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдүүдийн хувийн жин, амьдардаг айл, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Амьдардаг айл		Бүгд	Айлд мал маллаж буй эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдийн тоо
	Ажил олгогчийнд	Дотуур байранд		
Нас				
6-11	95,5	4,5	100,0	22
12-14	90,9	9,1	100,0	44
15-17	96,0	4,0	100,0	50
Хүйс				
Эрэгтэй	98,7	1,3	100,0	75
Эмэгтэй	85,4	14,6	100,0	41
Бүгд	<b>94,0</b>	<b>6,0</b>	<b>100,0</b>	<b>116</b>

Мал маллаж буй айлдаа амьдарч байгаа хүүхдийг өөрийн төрсөн гэртээ харихыг нь зөвшөөрдөг эсэхийг Зураг 4.1-д хүүхдийн насны бүлэг, хүйс болон хэнийд ажиллаж байгаагаар нь дэлгэрэнгүй харуулав.



Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 78 хувь нь ажил олгогч гэртээ харихыг зөвшөөрдөг гэжээ. Эмэгтэй хүүхдүүдийн 74 хувь нь гэртээ харих зөвшөөрөл олдог гэсэн нь хөвгүүдийнхээс 6 пунктээр доогуур байна. Малчин эмэгтэйчүүдийн нэгэн

адил айлд мал маллаж буй охид мал аж ахуйн өдөр тутмын ажилд голлох үүрэгтэй эсвэл тухай айлын өдөр тутмын гэрийн болон мал аж ахуйн ажлыг нугалахад чухал оролцоотой байдгаас эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад өөрийн гэртээ харих боломж, зөвшөөрлийг ажил олгогч нь олгохыг дургүйлхдэг байж болох юм. Ойрын хамаатан садныдаа (өвөө, эмээ, ах эгчийндээ) ажиллаж байгаа хүүхдүүдийн хувьд гэртээ харих боломж холын хамаатан эсвэл хамаатан бус айлд ажиллаж буй хүүхдүүдийнхээс харьцангуй өндөр байна.

Насны бүлгийн хувьд, бага насы (12-оос доош) хүүхдүүдийн 90 гаруй хувь нь гэртээ харих зөвшөөрлийг ажил олгогч өгдөг гэжээ. Энэ нь дээр өгүүлж байсанчлан айлд мал маллаж буй энэ насы хүүхдүүдийн дийлэнх нь элэг бүтэн гэр бүлд амьдардаг (Хүснэгт 4.1), төрсөн эцэг эх нь амьд сэргүүн байгаа (Хүснэгт 4.2) учир гэртээ харьдаг байж болох юм. Харин 12-оос дээш насы хүүхдүүдийн хувьд байдал эрс ялгаатай байна. 12-14 насы хүүхдүүдийн 70 хувьд нь гэртээ харих зөвшөөрөл олддог нь 15-17 насы хүүхдүүдийнхээс 9 орчим пунктээр доогуур байна.

Гэртээ харьж буй давтамжийг авч үзэхэд, сардаа нэг удаа гэртээ хариад ирдэг (27,1 хувь) хүүхдүүдийн хувийн жин хамгийн өндөр байна. Долоо хоногтоо нэг удаа (18,8 хувь), хоёр долоо хоногтоо нэг удаа (16,5 хувь) гэртээ очдог гэсэн хүүхдийн хувь бусад давтамжаас харьцангуй өндөр байна. Гэртээ харих зөвшөөрөл олддог ч гэртээ харьдагтүй гэж хүүхдүүдийн 3,5 хувь хариулжээ.

Өнчин, эцэг, эхгүй (24 хүүхдээс 15 нь) учраас ажил олгогч гэртээ харихыг нь зөвшөөрдөггүй гэж мал маллаж буй айлдаа амьдарч буй хүүхдүүдийн гуравны нэг нь хариулжээ.

Айлд мал маллаж буй хүүхдүүд өөрийн гэрээсээ дундажаар 14 км зайд алслагдсан газарт байрладаг айлд ажиллаж байна. Судалгаанд хүүхдүүд ялангуяа бага насы хүүхдүүд ажиллаж буй айл болон өөрийн гэр хоёрын хоорондох зайл нэлээд таамаглаж хэлсэн байж болохыг анхаарах хэрэгтэй. Гэхдээ айлд ажиллаж буй хүүхдийн нас ахих тусам гэрээсээ илүү хол байрлах айлд ажиллах хандлагатай байна.

#### 4.1.3 Èđäýí èé áè÷èä áàđèì Ò, ýđččë i ýí äèéí äààòääëä õàì ðääääëö

Орон нутагт амьдарч буй хүүхдүүдийн иргэний бичиг баримтын бүрдэл, цаапилбал эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнээс хүртэх боломж ямар байгааг энд судалж үзсэн юм. Үр дүнг хүүхдүүдийн насы бүлгээр Хүснэгт 4.4-д харуулав.

Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй нийт хүүхдүүдийн 82,6 хувь нь төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхтэй, 78,5 хувь нь эрүүл мэндийн даатгалтай гэж хариулжээ. Монгол улсын “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”<sup>14</sup>-иар 16 хүртэлх насы хүүхэд (ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 наас хүртэлх) эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна гэж заасан байдаг ч эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлага сулаас хүүхдүүд эрүүл мэндийн даатгалд бүрэн

<sup>14</sup> Монгол Улсын Эрүүл Мэндийн Даатгалын Хууль, 3-р бүлэг 7.1

хамрагдаж чадаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын дэвтрээ нээлгээгүй, эсвэл даатгалын дэвтэрт бүртгэлийг бүрэн гүйцэд хийлгээгүй хүүхдүүд эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүртэх боломжгүй юм.

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн нас ахих тусам төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхгүй эсвэл эрүүл мэндийн даатгалгүй хүүхдүүдийн хувийн жин нэмэгдэж байгаа нь нийгмийн үйлчилгээнээс хүртэх боломжийг төдийгүй иргэний үндсэн эрхээ (тухайлбал, 16 нас хүрсэн хүүхдийн хувьд сонгуульд оролцох боломжгүй гэх мэт) эдлэх боломжийг хязгаарлаж болохыг үгүйсгэх аргагүй юм.

#### *Огцоо 4.4 Айлд мал маллаж буй хүүхдүүдийн хувийн жин, нас, нийгмийн үйлчилгээ хүртэх боломж, баримт бичтийн бурдлаар*

Баримт бичиг	Нас			
	6-11	12-14	15-17	Бүгд
Төрсний гэрчилгээ/Иргэний үнэмлэх*				
Байгаа	81,0	81,8	84,1	82,6
Байхгүй	5,3	10,1	11,5	9,6
Мэдэхгүй	13,7	8,1	4,4	7,8
Эрүүл мэндийн даатгалтай				
Байгаа	79,3	79,8	77,0	78,5
Байхгүй	8,6	9,1	16,8	12,2
Мэдэхгүй	12,1	11,1	6,2	9,3
Бүгд	100,0	100,0	100,0	100,0
Айлд мал маллаж буй хүүхдийн тоо	58	99	113	270

Тайлбар: \* - 16 ба түүнээс дээш насны хүүхдээс иргэний үнэмлэхтэй эсэхийг асуусан.

Бага насны хүүхдүүдийн хувьд төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн даатгалтай эсэхээ мэдэхгүй гэсэн хариултын хувь харьцангуй өндөр байв. Харин 15-17 насны хүүхдүүдийн 16,8 хувь нь эрүүл мэндийн даатгалгүй, 11,5 хувь нь төрсний гэрчилгээ/иргэний үнэмлэхгүй гэсэн нь бусад насны бүлгээс хамгийн өндөр хувьтай байна.

#### *4.1.4 Аялалын хувьд хамрагдсан хүүхдүүдийн бичиж чадахгүй*

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн гуравны нэг нь (32,6 хувь нь уншиж, 33,7 хувь нь бичиж чадахгүй) өөрсдийгөө уншиж, бичиж чадахгүй гэжээ. Судалгаанд 6, 7, 8 настай хүүхдүүд хамрагдсан хэдий ч ерөнхий боловсролын дунд сургуульд 7 настай элсэн ордог, мөн нэгдүгээр ангийн сурагчид сургалтын төлөвлөгөөний дагуу хичээлийн жилийн эхний хагаст бичиг үсэгт тайлагдан “Цагаан толгойн баяр”-аа тэмдэглэдэг гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Иймд уншиж, бичиж сурсан байх албан ёсны насанд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бодит байдал ямар байгааг хүүхдүүдийн насны бүлэг, хүйсээр Хүснэгт 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Айлд мал маллаж буй 6-11 насны хүүхдүүдийн 55,2 хувь нь уншиж, бичиж чадахгүй байгааг нэг талаас, 6-7 насны хүүхдүүд хараахан энэ түвшинд хүрээгүй байгаатай холбон тайлбарлаж болох боловч хамрагдаж буй хариулагчийн тоо харьцангуй цөөн

(13 хүүхэд буюу 4, 8%) юм. Харин 12 ба түүнээс дээш насны дөрвөн хүүхэд тутмын нэг нь уншиж, бичиж чадахгүй байгаа нь мал маллаж буй хүүхдүүдийн дунд сургууль завсардалт өндөр байгаагийн тод илрэл болж байна.

Хүүхдүүдийн хүйсийн хувьд албан ёсны статистик болон бусад судалгааны үр дүнтэй нэгэн адил дүр зураг харагдаж байна. Тодруулбал, уншиж, бичиж чадахгүй байгаа эрэгтэй хүүхдийн (харгалзан 34,5 хувь, 36,2 хувь) хувь охидынхаос 5-7 пунктээр дээгүүр байна.

*Одийн 4.5 Айлд мал малладаг уншиж, бичиж чадлагчийн хүүхдүүдийн хувь болон тоо, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Уншиж чадахгүй		Бичиж чадахгүй	
	Бүгд	Уншиж чадахгүй хүүхдийн тоо	Бүгд	Бичиж чадахгүй хүүхдийн тоо
<b>Нас</b>				
6-11	55,2	32	56,9	33
12-14	27,3	27	29,3	29
15-17	25,7	29	25,7	29
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	34,5	60	36,2	63
Эмэгтэй	29,2	28	29,2	28
<b>Аймаг</b>				
Өвөрхангай	36,7	33	38,9	35
Ховд	53,3	48	54,4	49
Хөвсгөл	7,8	7	7,8	7
Бүгд	32,6	88	33,7	91

1990 оны сүүлчээс албан бус боловсролын хөтөлбөр улсын хэмжээнд хэрэгжиж байгаа хэдий ч мал дээр ажиллаж буй хүүхдүүд тэр дундаа хөвгүүдийн боловсрол охидынхаос доогуур түвшинд хэвээр байна. Судалгаанд хамрагдсан гурван аймгаас Монгол улсын баруун хязгаар Ховд аймаг энэ үзүүлэлтээр толгой цохиж, Өвөрхангай аймаг удаалж байгаа юм.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвецийн 32-р зүйлд хүүхэд боловсрол эзэмшихэд саад учруулах ажлаас хамгаалах эрхийг хүлээн зөвшөөрсөн юм. Айлд мал маллаж буй хүүхдийн хөдөлмөр тухайн хүүхдийг сургуульд суралцахад нь саад болж байна уу? Асуултын хариултыг айлд мал маллаж буй хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын байдлыг харуулсан Хүснэгт 4.6-аас олж болно.

*Одийн 4.6 Айлд мал маллаж буй хүүхдүүдийн хувийн жин, сургуульд хамрагдалтын байдал, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Сургуульд хамрагдалтын байдал			Бүгд	Айлд мал маллаж буй хүүхдийн тоо
	Сурдаг/ Албан	Сурдаг/ Албан бус	Сурдаггүй		
Нас					
6-7	-	-	100.0	100.0	13
8-11	57.8	-	42.2	100.0	45
12-14	56.6	2.0	41.4	100.0	99
15-17	31.0	1.8	67.2	100.0	113
7-15*	51.5	1.0	47.4	100.0	194
Хүйс					
Эрэгтэй	37.4	1.7	60.9	100.0	174
Эмэгтэй	54.2	1.0	44.8	100.0	96
Аймаг					
Өвөрхангай	41.1	2.2	56.7	100.0	90
Ховд	6.7	2.2	91.1	100.0	90
Хөвсгөл	82.2	-	17.8	100.0	90
Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох					
Өвөө, эмээ, ах, эгч	49.4	1.3	49.3	100.0	81
Бусад хамаатан	45.1	1.8	53.1	100.0	113
Хамаатан бус	34.2	13	64.5	100.0	76
Бүгд	43.3	1.5	55.2	100.0	270

Тэмдэглэгээ: \* Суурь боловсролд зайлшигүй хамрагдах нас

Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй хүүхдүүдийн 43,3 хувь нь албан, 1,5 хувь нь албан бус сургалтад хамрагдаж байна. Сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн хувь 15-17 насны хүүхдүүд (67,2 хувь) болон эрэгтэй хүүхдүүдийн (60,9 хувь) дунд нэлээд өндөр байна. Энд хамгийн их анхаарал татаж буй нэг асуудал бол манай улсын баруун хязгаар, баруун бүсийн төв Ховд аймгаас судалгаанд хамрагдсан, айлд мал маллаж буй хүүхдүүдийн дийлэнх буюу 91,1 хувь нь сургуульд сурхагүй байгаа явдал юм. Суурь боловсрол зайлшигүй эзэмших ёстой 7-15 насны бүлгийн судалгаанд хамрагдсан хүүхдийн 47,4 хувь нь сургуулийн гадна байж, айлд мал маллах ажил хийж байгаа нь онцгой анхаарал татаж байна.

Хамаатан бус айлд мал маллаж буй хүүхдүүдийн дунд сургуульд хамрагдалт харьцангуй доогуур байна. Өмнө дурьдаж байсанчлан хамаатан бус айлд мал малладаг гэж хариулсан 12-14 насны хүүхдүүдийн хувийн жин бусад насныхнаас хамгийн өндөр байсныг энд анхаарч үзвэл суурь боловсрол эзэмших насны мал маллаж буй хүүхдүүдийн дунд сургууль завсардалт өндөр байна гэж хэлж болохоор байна.

Хүүхэд сурхын хажуугаар олон цагаар хөдөлмөр эрхэлж байгаа нь ялангуяа ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хувьд хичээл давтах цаг, зарцуулах хугацаанд сөрөг нөлөөтэй байж болно. Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй хүүхдүүд гэрийн даалгавраа хийхэд дундажаар 2 цаг гаруй хугацааг зарцуулж байна.

Хүүхдүүдийн 35,5 хувь нь дундажаар 3 цаг, 29,8 хувь нь дундажаар 2 цаг, 19 хувь нь дундажаар 1 цагийг гэрийн даалгавраа хийхэд зарцуулдаг гэсэн хариулт хамгийн өндөр хувийн жинг эзэлж байна. Өнгөрсөн хичээлийн жилд (судалгаа явагдахаас өмнөх хичээлийн жил мал маллаж буй хүүхдүүдийн 67,8 хувь нь А, В үнэлгээтэй, 28.9 хувь нь С үнэлгээтэй суралцсан байна. Энд хөдөөгийн сургуулиудын чанарын асуудлыг давхар харгалzan үзэх хэрэгтэй.

Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй хүүхдүүдийн 55,2 хувь (270-аас 149 хүүхэд) нь албан болон албан бус сургалтанд хамрагдаагүй гэжээ. Сургуулиас гадуур байгаа хүүхдүүдийн гол шалтгааныг насны бүлэг болон хүйсээр Хүснэгт 4.7-оос харж болно.

*Одийд 4.7 Сургуульд суралцхийг байгаа гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн хувийн жин, суралцахгүй байгаа шалтгаан,*

*сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Суралцхийг байгаа шалтгаан										Сургуульд суралцхийг байгаа малчин хүүхдийн тоо
	Суралцахгүй тааруу	Ажилладаг	Ар гэрийн гачигдал	Сургуулиас хол	Эрүүл мэндийн шалтгаанаар	Мөнөөний боломжгүй	Сургуулийн нас болоогүй/ нас хэтэрсэн	Сонирхолгүй	Эдэг, эх зөвлөөрөгүй	Бүгд	
Нас											
6-11	-	9,4	31,3	18,6	6,3	9,4	15,6	3,1	6,3	100,0	32
12-14	4,9	17,1	31,7	2,4	9,8	4,9	-	26,8	2,4	100,0	41
15-17	5,3	14,5	46,1	6,6	11,8	3,9	-	10,5	1,3	100,0	76
Хүйс											
Эрэгтэй	3,8	15,1	40,6	6,6	7,5	4,7	1,9	16,0	3,8	100,0	106
Эмэгтэй	4,7	11,6	34,8	11,6	16,3	7,0	7,0	7,0	-	100,0	43
<b>Бүгд</b>	<b>4,0</b>	<b>14,1</b>	<b>38,9</b>	<b>8,1</b>	<b>10,1</b>	<b>5,4</b>	<b>3,4</b>	<b>13,4</b>	<b>2,7</b>	<b>100,0</b>	<b>149</b>

Сургуульд суралцахгүй байгаа гол шалтгаанд ар гэрийн гачигдал (38,9 хувь), ажил хийдэг учраас (14,1 хувь), суралцах сонирхолгүй (13,4 хувь), эрүүл мэндийн улмаас (10,1 хувь) гэсэн шалтгаанууд хамгийн өндөр хувийн жинг эзэлж байна.

Бага буюу 6-11 насны хүүхдүүдийн хувьд ар гэрийн гачигдал, сургуульд суралцахгүй байгаа гол шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл, ар гэрийн гачигдал, өрхийн байршил нь хүүхдийг хуулинд заасан насанд нь сургуульд элсэх боломжийг хязгаарлаж байна гэсэн үг юм. Энэ насны бүлгийг илүү нарийн задлаж үзвэл, 6-7 насны хүүхдүүд сургуульд элсэх нас болоогүй, 8-11 насныхны хувьд сургуульд орох нас хэтэрсэн гэсэн хариултын хувь мөн өндөр (15,6 хувь) байна. Харин 12-оос дээш насны сургуульд суралцахгүй байгаа хүүхдүүдийн хувьд ар гарийн гачигдлаас гадна суралцахгүй, ажилладаг зэргээс тэд сургуульд суралцахгүй байгаа ажээ. Суралцахгүй гэсэн шалтгаан хөвгүүдийн хувьд

охидоос 9 пунктээр өндөр, эсрэгээр эрүүл мэндийн улмаас гэсэн хариулт охидын хувьд хөвгүүдээс 9 орчим пунктээр өндөр байна. Эндээс ерөнхий боловсролын сургуулийн сургалт, арга зүйн асуудал эрэгтэй хүүхдүүдийг цаашид үргэлжүүлэн суралцах сонирхолыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй болох нь харагдаж байна. Мөн ядуу эдийн засаг нь хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох сонирхол бий болоход нөлөөлж улмаар сургууль завсардалтын томоохон шалтгаан болсоор байна.

## **4.2 Айлд мал маллаж буй хүүхдүүдийн өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт**

### **4.2.1 *Айлд мал маллаж буй хүүхдүүдийн өнгөрсөн ба одоогийн ажил эрхлэлт***


Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй хүүхдүүдийн анх ажил хийж эхэлсэн насыг одоогийн насыны бүлгээр Хүснэгт 4.8-д харууллаа.

*Одогийн насыг 4.8 Айлд мал маллаж буй хүүхдүүдийн хувийн жин, одоогийн насыг ба тухайн айлд мал маллаж эхэлсэн насаар*

Ажиллаж эхэлсэн насы	Одоогийн насы			Бүгд
	6-11	12-14	15-17	
5	22,4	3,0	0,9	6,3
6	24,2	11,1	2,6	10,4
7	36,2	9,1	7,1	14,1
8	8,6	16,2	8,0	11,1
9	6,9	12,1	6,2	8,5
10	1,7	17,2	13,3	12,2
11	-	14,1	6,2	7,8
12	-	12,1	14,2	10,4
13	-	4,1	15,9	8,1
14	-	1,0	10,6	4,8
15	-	-	10,6	4,4
16	-	-	3,5	1,5
17	-	-	0,9	0,4
Бүгд	100,0	100,0	100,0	100,0
Айлд мал маллаж эхэлсэн дундаж насы	6,6	9,2	11,5	9,6
Айлд мал маллаж буй хүүхдийн тоо	58	99	113	270

Хүүхдүүдийн анх ажил хийж эхэлсэн насыны дундаж 9,6 байна. Одоогийн насыны бүлгээр тооцсон анх ажил хийж эхэлсэн насыны дундаж 6-11 насын хүүхдүүдийн хувьд 6,6 насы байхад 15-17 насын хүүхдүүдийн хувьд 11,7 насы байна. Ер нь ажил хийж буй хүүхдүүдийн насы залуужиж байгааг одоогийн насыны бүлгээр тооцсон насыны дундажаас тодорхой харагдаж (Хүснэгтийн баганы дагуу тооцсон хувийн жингүүдийг ажиглана уу) байна.


Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй хүүхдүүдийн 93 хувийнх нь анхны ажил мал маллахаас эхэлсэн бол 43,7 хувь нь гэрийн үйлчлэгчийн ажлаар эхэлжээ. Зураг 4.2-д хүүхдүүдийн анх хийж байсан ажлын төрлийг хүйсээр харуулав.



Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй

Эрэгтэй хүүхдүүдийн 97,7 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 84,4 хувь нь анх айлд мал маллаж байсан бол охидын 68,8 хувь, хөвгүүдийн 29,9 хувь нь гэрийн үйлчлэгчийн ажлыг анх хийж байжээ. Хөвгүүд мал маллах ажилд охидоос арай илүү, эсрэгээр охид гэрийн үйлчлэгийн ажилд эрэгтэй хүүхдээс арай илүү оролцож байсан байна.

Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй хүүхдүүдийн 20,4 хувь нь (хөвгүүдийн 21,8 хувь, охидын 17,7 хувь) өмнө нь өөр айлд ажиллаж байжээ (Зураг 4.3). Насны бүлгээр авч үзвэл, 15-17 насны дөрвөн хүүхэд тутмын нэг нь (25,7 хувь) өмнө нь өөр айлд ажиллаж байсан байна. Эндээс айлд мал маллаж буй хүүхдүүд нас ахих тусам нэг айлдаа тогтвортой бус, олон айл сольж ажилладаг нь харагдаж байна.



Хүүхдүүдийн 29,3 хувь нь айлд ажил хийхээсээ өмнө сургуулиас завсардсан байжээ. Харин 10 хувь нь буюу арван хүүхэд тутмын нэг нь анх ажил хийхийн тулд сургуулиа орхисон байна. Хөвгүүдийг охидтой харьцуулахад ажил хийхээс өмнө сургууль завсардсан болон ажил хийхийн тулд сургуулиа орхисон тохиолдол бараг 2 дахин өндөр байна. Хөдөөд эрэгтэй хүүхдүүдийг мал маллах зорилгоор сургуулиас илүү их завсардуулж байсныг энэхүү судалгааний үр дүн дахин нотолж байна.

Анх ажил хийх санаачлагыг хүүхдүүдийн 37 хувь нь өөрсдөө гаргасан байна. Эцэг, эх анх ажил хийхийг санаачилсан гэж хүүхдүүдийн гуравны нэг нь, ажиллуулагч айл өөрөө хүсэлт тавьж, санаачилсан гэж 18 хувь нь хариулжээ. Анх ажил хийхийг бага буюу 12 хүртэлх насны хүүхдүүдийн хувьд эцэг эх нь (53,4 хувь), харин 12-оос дээш насныхны хувьд өөрсдөө (41 хувь) санаачилсан байдал хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Өрхийнхөө орлогыг нэмэгдүүлэх (34,8 хувь), эцэг эх нь шаардсан (26,7 хувь), эцэг эх нь ажилгүй (23 хувь) зэрэг шалтгаанууд нь хүүхэд анх ажил хийх болсон хамгийн өндөр хувийг эзэлж буй шалтгаан байна. Эндээс өрхийн орлого бага, ажилгүйдэл, ядуу зүдүү байдал нь хүүхэд хөдөлмөр хийх үндсэн шалтгаан болж байгааг харж болох юм. Түүнчлэн эцэг эх нь ажилгүйн улмаас хүүхдээ хөлс багатай ажилд шахах, шаардаж хийлгэх хандлага хүүхдүүдтэй хийсэн гүнзгийрүүлсэн ярилцлагаас ч ажиглагдаж байв. Харин насны бүлгийн хувьд, бага буюу 6-11 насны хүүхдүүдийг эцэг эхийн зүгээс шаардаж ажил хийлгэх (41,4 хувь), харин 12-оос дээш насны хүүхдүүдийн хувьд сургууль завсардалт (15-18 хувь) нь тэдний ажил хийх гол шалтгаан болсон байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдийн 50 хувь нь айлд мал маллаж эхлээд 2 жил болсон байна. Айлд мал маллаж буй дундаж хугацааг тооцоолж үзэхэд 2 жил 6 сар гарч байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хувьд ажиллаж буй дундаж хугацаа нэлээд ойролцоо байна.

Хүүхдүүдийн 20 хувь нь өмнө нь өөр айлуудад ажиллаж байсан ба өөр айлд ажилласан байсан хүүхдүүдийн 50 хувь нь 2-оос дээш айлд ажиллаж байжээ. Хамгийн олон буюу 5 айл сольсон эрэгтэй хүүхэд судалгаагаар тохиолдсоныг энд тэмдэглэс.

Өмнө нь айлд ажиллаж байсан хүүхдүүдийн айлаа өөрчлөх болсон шалтгаанд тухайн айл ажиллуулахаа больсон (45,5 хувь), хэд хэдэн айлд зэрэг ажилладаг (20,0 хувь), хамаатнаа бараадсан (16,4 хувь) гэсэн хариултууд хамгийн өндөр хувийг эзэлж байна. Айлаа өөрчлөх болсон шалтгааныг хүйсээр Зураг 4.4-д харууллаа.

Хүйсийн хувьд ялгаа хамгийн их байгаа шалтгаануудад дээр дурьдсан турван шалтгаан орж байгаагаас гадна өлсдөг, хөлс бага гэж хариулсан эрэгтэй хүүхдийн хувь охидынхоос өндөр, харин айлын хүмүүс архи уудаг, шийтгэдэг гэсэн хариулт охидын хувьд хөвгүүдийнхээс өндөр байгааг дээрх зургаас харж болно.



Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй

#### *4.2.2 1-ийн ажлыг үзүүлэх*

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 79,6 хувь нь судалгаа авах үед анхныхаа айлд ажиллаж хийж байгаа хүүхдүүд байв.

Одоогийн айлдаа мал маллаж эхэлсэн дундаж нас нийт хүүхдүүдийн хувьд 11,8, харин эрэгтэй хүүхдийн хувьд 11,4, эмэгтэй хүүхдүүдийн хувьд 12,8 байна (Хүснэгт 4.9). Эндээс эрэгтэй хүүхдүүд охидоос арай эрт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нь харагдаж байна.

Одоогийн ажлыг хийх санаачлагыг анх хүүхэд өөрөө эсвэл эцэг, эх, ажил олгогчоос гаргасан гэсэн хариулт тус бүр 32,7 хувийг эзэлж байна. Харин хүйсийн хувьд одоогийн ажлыг анх санаачилсан хүмүүсийн хувийн жин ялгаатай байна. Тухайлбал,

охидын 47,1 хувь өөрийн санаачлагаар анх ажил хийж эхэлсэн байхад хөвгүүдийн хувьд эцэг эх, ажил олгогчдоос анх санал тавьсан гэж тус бүр 36,8 хувь нь хариулжээ.

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн хувьд мал аж ахуйн үйл ажиллагаан дахь оролцоо болон тухайн өрхийн гэр орны ажилд зарцуулж буй хөдөлмөрийн оролцоог зааглаж харах нь чухал юм. Учир нь хүүхдүүд айлд амьдарч, айлын мал малладаг нэрийн дор ажил олгогчийн гэрийн ажлыг хийж байна уу? Тийм бол хэр ачаалалтай байна вэ? Тэдний хөдөлмөрийг хэрхэн үнэлж байна вэ? Тэд малчин уу эсвэл гэрийн үйлчлэгч үү? Гэх мэт олон асуултууд ар араасаа урган гарч ирж байна. Тэгвэл судалгаагаар айлд мал малладаг хүүхдүүдийн тухайн айлд хийдэг ажлууд дараахь байдлаар тодорхойлогдож байна (Хүснэгт 4.9).

Айлд хийдэг ажлуудыг төрлөөр нь задлан үзвэл гэрийн ажил хийдэг хүүхдүүдийн хувийн жингийн тархалт, мал аж ахуйтай холбоотой хийдэг ажлын тархалтаас илт өндөр байна. Айлын ундны болон ахуйн ус, түлээ түлш зөөж бэлтгэх, гэр орон, хувцас хунарыг угааж, цэвэрлэх, өдөр тутмын хоолыг бэлтгэх, хийх, айлын хүүхэд, өндөр настан асрах, гэр сахих зэрэг гэрийн үйлчлэгчийн өдөр тутам хийдэг бүхий л ажлуудыг судалгаанд хамрагдсан айлд мал малладаг хүүхдийн талаас ч илүү хувь нь хийдэг болохыг судалгааны үр дүн харуулж байна. Харин цэвэр мал аж ахуйн үйл ажиллагаануудад оролцдог гэж хариулсан хүүхдийн хувийн жингийн тархалт арай өөр дүр зургийг илтгэж байна.

*Одийн 4.9 Айлд мал малладаг хүүхдүүдийн хувь, хийдэг гэрийн болон МАА-н ажлууд*

Гэрийн ажил	Хувь	Мал мал аж ахуйн ажил	Хувь
Ус зөөх	88.1	Мал хариулах/эргүүлэх	93.0
Гэр цэвэрлэх	70.4	Малын хашаа цэвэрлэх	85.6
Гэр сахих	67.0	Сааль, цагаа бэлтгэх, боловсруулах	61.5
Түлээ, мод бэлтгэх	67.0	Ноос авах	57.8
Хоол хийх/бэлтгэх	59.6	Мал нядлах	33.3
Түлээ мод хагалах	54.8	Алдуул мал хайх	33.0
Хүүхэд/өндөр настан асрах	48.1	Мал угаах/шүлтгэх	32.2
Хувцас угаах	46.7	Оторт бис дааж явах	9.3
Чингэлэг/TҮЦ-д суух	0.4	Цагаан идээ зарах/борлуулах	8.5
		Тууварт явах	7.4
		Мал услах	5.2
		Бусад*	1.5
Бүгд	270		270

Тайлбар: Давхардсан тоогоор хариултыг авсан учраас 100 хувьтай тэнцэхгүй


\* Бусад гэсэн ангилалд алдуул мал хайх, өвс хадлан бэлтгэх, төл авах, хурдны морь, эмнэг сургах зэрэг ажлууд багтсан болно.

Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг манай орны хувьд мал маллах нь байгаль, цаг уураас ихээхэн хамааралтай, эрсдэл өндөртэй байдаг бөгөөд хүүхдүүдийг голдуу гэр орчинд (мал хариулах, эргүүлэхийг эс тооцвол) малын хашаа, хороо, өтгө бууц цэвэрлэх, сааль, цагаа бэлтгэх, ноос авах гэх мэт ажлуудад түлхүү ажиллуулж байна. Малын хашаа хороо цэвэрлэх ажлыг шууд мал аж ахуйн үйлдвэрлэлийн ажил гэхээсээ илүү гэрийн үйлчилгээний ажлын өргөтгөсөн хэлбэр гэж үзэж болохоор

байна. Түүнчлэн сааль саах, сүү, цагаан идээ боловсруулах ажил нь хэдийгээр мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжсэн ажил хэдий ч нөгөө талаас өрхийн хэрэглээ, хоол хүнс бэлтгэж буй ажил юм. Тиймээс айлд ажиллаж буй хүүхдийн хөдөлмөр нь мал аж ахуйн ба гэрийн үйлчилгээний гэсэн хоёрдмол шинжтэй, гэрийн үйлчилгээний ажилд түлхүү суурилж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Цаашилбал, малчин айлд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн хөдөлмөрийн хуваарилалт эрс ялгаатай болохыг Зураг 4.5 илэрхийлж байна.

Үнэндээ айлд мал малладаг охид малчин айлын гэрийн гэж хэлж болох бүхий л ажлыг хийж байна. Мал аж ахуйн цөөн төрлийн ажлуудад тэд оролцож байгаа бөгөөд эдгээр нь мөн л ахуйн чанарын хашаа, хороо цэвэрлэх, сүү, цагаа бэлтгэх гэх мэт ажлуудыг голдуу хийдэг байна. Харин эрэгтэй хүүхдүүдийн хувьд, гэрийн гадуурх ажлууд тухайлбал, ус, түлээ бэлтгэх болон мал эргэх, ноос авах, алдуул мал хайх зэрэг жинхэнэ мал аж ахуйн ажлуудад охидоос илүү оролцдог болох нь Зураг 4.5-гаас харагдаж байна.



Айлд мал маллаж буй эмэгтэй, эрэгтэй хүүхдүүдийн ажлын нэг өдрийн зураглалыг гүнзгийрүүлсэн ярилцлагад үндэслэн гаргаж үзье.

<sup>a</sup> ãëeo<sup>o</sup> 7 öàäò áíññíä ïð äýðýý öóðàäí, ãäë òjëæ öäé -äí áí à. Í àë öäðäí ãàä òjëýý ïðóðëí à. Öàéäà õó-ëöàä 8-9 öàäèéí õíñðíä çíýý ñàäí à. Äàðàà íü çöýð áyëò-ýýðò ãàðäàí à. Äyäà òàåäà õäàäæ, äýð öýâýðéýíý. Ò°ëeo<sup>o</sup> öäøàä, õíñü yì àà ñàäí à. Äàðàà íü ò°ëeo<sup>o</sup> íèéëçjëæ áyë-ýýðò ãàðäàí à. Õñ àäí à áàñ çàðèì ãàä òjëýý òjëíý. <sup>-</sup> äýýñ õíéø õíññíä áyëäýíý. Äýñýð áàéòäé òðäæé öýð öää áíëæ, ò°ëeo<sup>o</sup> öäøèí à. Õíññí õèéñí èé ãàðàà õäæéó àéëä ïðæ æàäæ çöðääò ççäýä. <sup>a</sup> â<sup>o</sup>, àõ, ýä-íàðûí ïðûñ çàñí à. Í ðíé 10 öää "íã°ðooä çóë àñäàäæ, äíññí áóððäíä ñçj°ðäooä àæëë äóññää. Öýäýä è óí òäí à.

(Á. *I*, yì yāòyé, 14 iàñòàé, ñóðäóöëü çàññäðäñáí, <sup>a</sup>â°ðöàíñàé, ÒàðàñÒ ñóì )

<sup>a</sup> ãǣoo 7-ä áíñäǟã. 8 öàãèéí ðäǟ ðíýy èåýëäýäýã. Öoãäëe òóóæ, öîíèí áýë-ýíý. Í àéüí öàøàà öýâýðéýíý. Öàé óó÷èöààà àÿã, Öàâàã óâààæ, äýð öýâýðéýäýã. Özëø öðooäoæ, i íä öàãàéíà. Öýäýyä óñ çooí o. - äýø öîíü, ðöýð ýðãçëäýã. Áãñ àäöö íéðòóöeíà. Í ðîé òóãäë öî ðeööeæ, <sup>o</sup>âñ öäyæ <sup>o</sup>ãä<sup>o</sup>ã. Öîíèí öî ðeööeàä <sup>o</sup>äðeéí àæeëe äööñäǟ.

(Ö. I , ýðýäòýé, 16 íàñòàé, ñóðäóöëü çàâñàðäñàí, <sup>2</sup> â°ðöàíääé, Ççíáàÿí-Öëààí ñòí )

Хүснэгт 4.10 болон 4.11-д ундны ус зөөдөг болон түлээ түлиш бэлтгэдэг хүүхдийн хувийн жинг насны бүлэг болон хүйсээр харуулсан болно.

Айлд ажиллаж буй хүүхдүүдийн ус зөөвөрлөж буй зай өрхөөс дундажаар 1 км байгаа ба хамгийн ойр нь 5 метрээс, хамгийн хол нь 15 километрээс усаас бэлтгэдэг байна. Усыг гараар зөөвөрлөдөг гэж хүүхдүүдийн 73,1 хувь хариулсан бөгөөд энэ хувийн жин охид (80,7 хувь) болон бага буюу 6-11 насны хүүхдүүд (76 хувь) хувьд харьцаангуй өндөр байна.

*Одийн 4.10 Ус зөөх ажил хийдэг хүүхдүүдийн хувь, ашигладаг хэрэгсэл болон сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Хэрэгсэл					Бүгд	Ус зөөдөг хүүхдийн тоо
	Тэргээр	Дамнуур-гаар	Ердийн хөсгөөр	Гараар	Машин/Мотоциклоор		
Хүйс							
Эрэгтэй	15,3	0,7	14,0	68,7	1,3	100,0	150
Эмэгтэй	6,8	1,1	9,1	80,7	20,3	100,0	88
Нас							
6-11	12,0	2,0	8,0	76,0	2,0	100,0	50
12-14	10,1	1,1	10,1	77,6	1,1	100,0	89
15-17	14,1	-	16,2	67,7	2,0	100,0	99
Зай							
500 метр хүртэл	13,9	-	4,4	81,7	-	100,0	115
501-1000 метр	11,1	2,8	9,7	72,2	4,2	100,0	72
1001- метрээс дээш	9,8	-	33,3	54,9	2,0	100,0	51
Бүгд	12,2	0,8	12,2	73,1	1,7	100,0	238

Тухайн ажиллаж буй айлынхаа түлээ, түлшийг хүүхдүүдийн дийлэнх (70,2 хувь) нь биеэрээ үүрч айлдаа авчирдаг байна. Түлээ, түлшийг ажилладаг айлаасаа дундажаар 2,7 километрийн зайнаас бэлтгэж байгаа ба хамгийн ойр нь 1 километр хэртэй, хамгийн хол нь 40 километр замыг туулж айлын түлээ, түлшийг нь бэлтгэдэг ажээ. Үндны болон ахуйн ус бэлтгэж байгаатай нэгэн адил эмэгтэй хүүхдүүд (92,2 хувь) болон бага насны хүүхдүүд (84,4 хувь) түлээ, түлшийг үүрч бэлтгэдэг практик хамгийн өндөр хувийн жинг эзэлж байна.

*Одийн 4.11 Түлээ, тулих бэлтгэх ажил хийдэг хүүхдүүдийн хувь ашигладаг хэрэгсэл, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Хэрэгсэл				Бүгд	Түлээ бэлтгэдэг хүүхдийн тоо
	Тэргээр	Ердийн хөсгөөр	Үүрч	Машин/Мотоцикл		
Хүйс						
Эрэгтэй	9,3	25,4	61,5	3,8	100,0	130
Эмэгтэй	7,8	-	92,2	-	100,0	51
Нас						
6-11	6,7	8,9	84,4	-	100,0	45
12-14	4,8	22,6	69,4	3,2	100,0	62
15-17	13,4	20,3	62,2	4,1	100,0	74
Зай						
500 метр хүртэл	15,9	9,1	75,0	-	100,0	44
501-1000 метр	6,9	13,8	79,3	-	100,0	58
1001-метрээс дээш	6,3	26,6	60,8	6,3	100,0	79
Бүгд	8,8	18,2	70,2	2,8	100,0	181

Насанд хүрсэн малчин олон хоногоор алдуул мал хайх, отор тувварт явах нь нүүдлийн мал аж ахуйн нэлээд хүнд бөгөөд гол ажлуудын нэгд багтдаг. Халуунд

халах, хүйтэнд даарч бээрэх, осгож, хөлдөх, төөрөхөөс гадна удаан хугацаагаар гэр орноосоо хол байж хээр хөдөө, мал дагаж явах нь асар эрсдэлтэй. Насанд хүрсэн эрэгтэй малчдын голлон хийдэг дээрх ажлыг айлд мал маллаж буй хүүхдүүд мөн хийж байна. Айлд мал маллаж буй хүүхдийн 33 хувь нь алдуул мал хайх, 16,7 хувь нь отор, тууварт явдаг бөгөөд алдуул мал хайж дундажаар 2,5 өдөр, отор, туувар дундажаар 20,7 өдөр зарцуулдаг ажээ.

Хурдны морь унах нь ялангуяа бага насын хүүхдэд нэлээд эрсдэлтэй байдаг. Айлд мал малладаг хүүхдийн 16,3 хувь нь өвөл, 38,5 хувь нь зун хурдны морь унадаг гэжээ (Хүснэгт 4.12). Хурдны морийг голдуу эрэгтэй хүүхдүүд унадаг бөгөөд насын бүлгийн хувьд 12-14 насын хүүхдүүдийн хувийн жин аль ч улиралд харьцангуй өндөр байна.

*Өгүүлэх 4.12 Хурдны морь унадаг хүүхдүүдийн хувь болон тоо, улирал, сонгосон узүүлэлтээр*

Сонгосон узүүлэлтүүд	Өвөл		Зүн	
	Морь унадаг	Тоо	Морь унадаг	Тоо
Хүйс				
Эрэгтэй	25,3	44	55,2	96
Эмэгтэй	-	-	8,3	8
Нас				
6-11	12,1	7	24,1	14
12-14	22,2	22	46,5	46
15-17	13,3	15	38,9	44
Бүгд	16,3	44	38,5	104

#### 4.2.3 Ажлын тоо

Айлд мал малладаг хүүхдүүдийн ажлын цагийн ногдлыг Хүснэгт 4.13-д хүйсээр задлсан харуулбал, хүүхдүүдийн ажил өглөө дундажаар 8 цагт эхэлж, орой дундажаар 20 цагт дуусдаг байна. Хүйсийн хувьд ажлын эхлэх болон дуусгах цаг нэлээд ялгаатай байна. Тухайлбал, айлд мал маллаж буй эмэгтэй хүүхдийн ажил эрэгтэй хүүхдээс нэг цагийн өмнө эхэлж, 40 минутын дараа ажил нь дуусдаг байна. Малчин өрхийн өдөр тутмын ажлын ачаалал өрхийн эзэгтэй, эсвэл эмэгтэй гишүүдэд илүү ногдож байдаг бөгөөд айлд мал малладаг эмэгтэй хүүхдийн хувьд ижил хандлагатай байна.

Өдрийн ажлын үргэлжлэх дундаж хугацаа 9 цаг 40 минут байгаа нь хөдөлмөрийн хуулинд заасан цагаас<sup>15</sup> 1 цаг 40 минутаар, хүүхэд ажил хийж болох цагаас 2 дахин урт байна (долоо хоногийн ажлын цаг нь 14-15 насын ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насын ажилтанд 36 цаг хүртэл байна гэсэн заалтууд зөрчигдсөн). Цаашилбал, эмэгтэй хүүхдийн өдрийн ажлын үргэлжлэх хугацаа эрэгтэй хүүхдийнхээс бүтэн нэг цагаар урт байна.

<sup>15</sup> Хөдөлмөрийн тухай хууль, Бүлэг 5-ийн 70, 71-р зүйл ангиудтай зөрчилдөж байна.

*Огийн 4.13* Айлд мал малладаг хүүхдүүдийн хувийн жин, хүйс, ажлын цагийн ногдоор


Цагийн ногдол	Хүйс		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Өглөө ажил эхэлдэг цаг			
8 цагаас өмнө	31,0	62,5	42,2
8-9	55,7	30,2	46,7
9-цагаас хойш	13,3	7,3	11,1
<i>Абсцисса</i>	<i>8,2</i>	<i>7,5</i>	<i>7,9</i>
Орой ажил дуусдаг цаг			
18 цагаас өмнө	12,1	9,4	11,1
18-19	31,6	20,8	27,8
19 цагаас хойш	56,3	69,8	61,1
<i>Абсцисса</i>	<i>19,6</i>	<i>20,0</i>	<i>19,7</i>
Өдрийн ажлын дундаж хугацаа			
3 хүрглэх цаг	0,6	2,1	1,1
4-6 цаг	18,4	14,5	17,0
7-8 цаг	24,1	11,5	19,6
8 цагаас дээш цаг	56,9	71,9	62,3
<i>Абсцисса</i>	<i>9,1</i>	<i>10,1</i>	<i>9,4</i>
7 хоногт ажилладаг өдөр			
1-2 өдөр	6,9	9,4	7,8
3-5	12,1	9,4	11,1
6	1,7	0,0	1,1
7	79,3	81,3	80,0
<i>Абсцисса</i>	<i>6,3</i>	<i>6,3</i>	<i>6,3</i>
Жилд ажилладаг дундаж сар			
1-4	31,6	38,5	34,1
5-8	4,6	8,3	5,9
9-сараас дээш	63,8	53,2	60,0
<i>Абсцисса</i>	<i>8,6</i>	<i>7,9</i>	<i>8,3</i>
Бүгд	100,0	100,0	100,0
Айлд мал малладаг хүүхдийн тоо	174	96	270

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулинд ажлын таван өдөр, амралтын 2 өдрийг албан ёсоор заасан байдаг ч бодит амьдрал дээр айлд мал маллаж буй хүүхдүүд долоо хоногт дунджаар 6,5 өдөр ажиллаж байна. Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 80 орчим хувь нь долоо хоногийн бүх өдрүүдэд ажилладаг гэжээ. Долоо хоногийн ажлын өдрийн тоо хүйсийн хувьд бараг ялгаагүй байна.

Жилд хүүхдүүд дунджаар 8,3 сар айлд мал маллаж байгаа бөгөөд жилд ажиллаж буй сарын тоо эрэгтэй хүүхдүүдийн (8,6 сар) хувьд охидынхоос (7,9 сар) арай урт байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 70 орчим хувь нь жилийн дөрвөн улирлын туршид айлд мал малладаг (Зураг 4.6) учраас сургууль завсардах эсвэл хичээл номноосоо хоцрох эрсдэлтэй байна.

*Чөдлэл 4.6 Айлд мал малладаг хүүхдүүдийн хувь, ажилладаг улирлаар*



Ийнхүү тасралтгүй хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа нь магадгүй сургуульд суралцахаас илүү эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох сонирхолыг төрүүлэхэд нөлөөлдөг байж болох талтай. Нөгөө талаас, ялангуяа хичээл эхэлсэн улирлуудад ажлаас болж хичээл урт, богино хугацаагаар таслах, улмаас сургуульд завсардахад нь нөлөөлж байна.

### *Ойлгээнийн ажлын төслийн төрөл*

Судалгаанд хамрагдсан хүүхдийн 65,2 хувь нь өдөрт ганцхан удаа, 28,9 хувь нь өдөрт хоёр удаа, 5,2 хувь нь өдөрт гурван удаа халуун хоол иддэг гэжээ. Нэг удаагийн хоололтонд хүүхдүүдийн дийлэнх (96,6 хувь) нь цаддаг гэж хариулсан сайшаалтай юм. Харин хүйсийн хувьд өдрийн хоололтын давтамж нэлээд ялгаатай байна. Охиидын өдрийн ажлын үргэлжлэх хугацаа хөвгүүдийнхээс урт атлаа өдөрт хооллодог давтамж хөвгүүдийнхээс цөөн, бага хооллодог байна. Огт халуун хоол иддэггүй гэж нэг ч эрэгтэй хүүхэд хариулаагүй байхад 2 эмэгтэй хүүхэд ийм хариултыг өгсөн байна.

Судалгаа авахаас өмнөх долоо хоногт халуун хоолгүй хоносон гэж 14 хүүхэд хариулсан нь нийт судалгаанд хамрагдсан хүүхдийн 5,2 хувийг эзэлж байна. Халуун хоолгүй хоносон бага насын болон эрэгтэй хүүхдүүдийн хувь арай өндөр байна. Халуун хоолгүй хоносон дундаж хугацаа 2.6 өдөр байгаа ба хамгийн урт хугацаа 7 хоног (2 хүүхэд) байв.

Хөдөөгийн малчин өрхүүд голдуу илүү гэртэй байдаг бөгөөд түүнийгээ сүү, цагаан идээ бэлтгэх эсвэл агуулах, жижиг төл мал байлгах зэргээр ашигладаг. Айлд мал маллаж буй хүүхдүүдийг илүү гэрт унтуулдаг эсэхийг бид сонирхож үзсэн бөгөөд судалгаагаар ийм үр дүн гарсангүй. Хүүхдүүдийн дийлэнх (98.9 хувь) нь ажил хийж буй айлдаа эсвэл өөрийнхөө гэрт унтаж байгаа нь аюул багатай, дулаан газар

амардгийг харуулж байна. Хүүхдүүдийн 88,9 хувь нь өөрийн гэсэн тусдаа хөнжил, гудастай байдаг бөгөөд аль аль нь огт байдагтүй гэж 22 хүүхэд буюу 8,1 хувь нь хариулжээ. Өөрийн гэсэн тусдаа хөнжил, гудас байдагтүй эмэгтэй хүүхдийн хувийн жин (11,5 хувь) эрэгтэй хүүхдийнхээс 5 пунктээр өндөр байна.

Айлд мал малладаг хүүхдүүд шөнө дундажаар 9,4 цаг унтаж амардаг гэсэн тооцоо гарч байна. Хүйсийн хувьд ялгаа маш бага байна.

Өдрийн цагаас гадна шөнө ажил олгогч ажил хийлгэдэг гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 21,5 хувь нь хариулжээ. Хүүхдийн нас ахих тусам ажил олгогч хүүхдүүдийг шөнийн цагаар ажиллуулдаг гэсэн хариултын хувь нэмэгдэж байна. Шөнийн цагаар ажилладаг эрэгтэй хүүхдийн хувийн жин (33,4 хувь) охидоынхоос 15,7 пунктээр илүү байна. Шөнийн цагаар голдуу (давхардсан тоогоор) 63,8 хувь нь мал манадаг, 62,1 хувь нь төл авдаг, 5,2 хувь нь гэр зуурын (айлын хүүхэд saatuuulaах гэх мэт) ажлуудыг хийдэг байна. Шөнө хүүхдүүд дундажаар 2,5 цаг ажилладаг байна. Хүүхдийн нас ахих тусам шөнө ажилладаг цаг нэмэгдэж байгаа ба эрэгтэй хүүхэд охидоос дундажаар 1,4 цагаар илүү ажилладаг байна.

Айлд мал маллаж буй хүүхдүүд амралт, баяр ёслол болон бямба, ням гаригуудад амарч чаддаг эсэхийг Хүснэгт 4.14-д хүүхдийн хүйс болон насны бүлгээр харуулав.

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 23,3 хувь нь нийтийн амралтын (цагаан сар, наадам гэх мэт) өдрүүд, бямба, ням гаригуудад амардаг, 34,8 хувь нь зөвхөн нийтийн амралтын өдрүүдэд амардаг, 1,9 хувь нь зөвхөн бямба, ням гаригуудад амардаг гэжээ. Амралтын дээрх өдрүүдэд амардагтүй гэж хүүхдүүдийн 40 хувь нь хариулсан байна. Бага насны буюу 6-11, том буюу 15-17 насны хүүхдүүд (харгалзан 44,8 хувь ба 46 хувь), өнчин эсвэл эцэг эхтэйгээ хамт амьдардаггүй хүүхдүүдийн (46,6 хувь) хувьд амралт, баяр ёслолын өдрүүдэд амарч чадахгүй байгаа явдал бусад ангилалд багтах хүүхдүүдийнхээс өндөр байна.

Амралт, баяр ёслолын өдрүүдээр амардаггүй гэж хамаатан бус айлд мал маллаж буй хүүхдүүдийн 44,7 хувь нь хариулсан нь өвөө, эмээ, ах, эгч, хамаатан садныдаа ажиллаж буй хүүхдүүдийнхээс 6-8 пунктээр илүү байна.

Амралт баяр ёслолын өдрүүдэд ажлын ачаалал нэмэгддэг гэж нийт хүүхдүүдийн 42,6 хувь нь хариулсан бөгөөд эмэгтэй хүүхдүүд (53,8 хувь), 6-15 хүргэлх насны хүүхдийн хувьд (46,2-50 хувь) хувийн жин өндөр гарчээ. Энэ нь айлд мал маллаж буй эмэгтэй хүүхдүүд, бага насны хүүхдийг ойр зуурын гэрийн ажил, баярын бэлтгэл ажлуудад илүү дайчилдаг болохыг харуулж байгаа юм.

Мал маллаж байгаа айлдаа амьдардаг хүүхдүүдийг амралт, баяр ёслолын үеэр гэр лүүгээ хариад ирэхийг ажил олгогч зөвшөөрдөг гэж хүүхдүүдийн 81,9 хувь, хааяа зөвшөөрдөг гэж 11,7 хувь нь хариулжээ.

*Огийн 4.14 Айлд мал малладаг хүүхдүүдийн хувийн жин, амралт, баяр ёслолоор амардаг эсэх, сонгосон узүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Амралт баяр ёслолын өдрүүд				Бүгд	Айлд мал маллладаг хүүхдийн тоо
	Амардаг	Зөвхөн нийтийн амралтын өдрүүд	Зөвхөн Бямба, Ням гаригт	Амардаг- гүй		
Хүйс						
Эрэгтэй	23,0	36,2	1,1	39,7	100,0	174
Эмэгтэй	24,0	32,3	3,1	40,6	100,0	96
Нас						
6-11	22,4	31,0	1,8	44,8	100,0	58
12-14	28,3	39,4	2,0	30,3	100,0	99
15-17	19,5	32,7	1,8	46,0	100,0	113
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх						
Хамт амьдардаг	24,0	39,6	1,3	35,1	100,0	154
Хамт амьдардаггүй /Өнчин	22,4	28,4	2,6	46,6	100,0	116
Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох						
Өвөө, эмээ, ах, эгч	17,3	44,4	1,3	37,0	100,0	81
Бусад хамаатан	27,4	31,0	2,7	38,9	100,0	113
Хамаатан бус	23,7	30,3	1,3	44,7	100,0	76
Бүгд	23,3	34,8	1,9	40,0	100,0	270

#### 4.2.4 Ō°ä°ëì °ðèéí õàðèëöàà áà òj; jíèé çîõèööóëàëò

*O<sup>o</sup>ä<sup>o</sup>ëì<sup>o</sup>ðèéí<sup>o</sup> ãýðýý*

Ажил олгогч, хөдөлмөрөө хөлслөгч хоёрын хооронд албан ёсны хөдөлмөрийн гэрээг байгуулж, хөдөлмөрийн харилцаа зохицуулагдах ёстой. Хөдөлмөрийн хуулинд хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажилтнаас ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй гэж заасан байдаг ч малчин буюу ажил олгогч, мал маллаж буй хүүхэд хоёрын хооронд бичгээр нэг ч хүүхэд гэрээ хийгээгүй байна. Энэ нь нэг талаас хөдөлмөрийн харилцаа үүсэх насанд тухайн хүүхэд хүрээгүйтэй, нөгөө талаас хүүхдүүдийн тодорхой хэсэг нь өөрийн ойрын болон холын хамаатан садныдаа ажиллаж байгаатай холбоотой байж болох юм. Харин хийгдэж буй цөөн хэлцэл нь зөвхөн аман тохиролцоо л төдий байдаг байна. Аман тохиролцоо хийсэн гэж ердөө 12 хувь нь буюу 33 хүүхэд л хариулжээ. Аман гэрээг баталгаажуулах боломжгүй бөгөөд хөдөлмөрийн аливаа асуудлыг гүйвуулахад хялбар, гэрээний гүйцэтгэлийг хянах боломж хомс юм. Аман гэрээ байгуулсан эрэгтэй хүүхдүүдийн эзлэх хувийн жин (14,4 хувь) охидынхоос 6 пунктээр өндөр байна. Хүүхдүүдийн нас ахих тусам аман гэрээ байгуулах хандлага нэмэгдэж байна.

## *Ооёөи өдөөи өөр, өзүүеэ чадаа ёа*

Аман гэрээнд хамгийн гол тохиролцог зүйл нь тогтсон хугацаанд бэлэн мөнгөөр хөлс төлөх, ажлын чанартай уялдуулан анх тохирсон хөлсөө өөрчлөх асуудлууд багтдаг гэж хүүхдүүд өгүүлж байна.

Монгол улсын □Хөдөлмөрийн тухай хууль□-нд 18 насанд хүрээгүй ажилтны цалин хөлсийг цагаар, эсхүл хийснээр нь бодож олгох ёстойг заасан байдаг. Гэтэл судалгаанд хамрагдсан айлд мал маллаж буй хүүхдүүд ажлын хөлсөө 25 хувь нь буюу дөрвөн хүүхэд тутмын ердөө нэг нь бэлэн мөнгөөр, 69,3 хувь нь буюу турван хүүхэд тутмын хоёр нь мөнгөн бус хэлбэрээр авч байна. Харин 5,2 хувь нь ажил олгогч огт хөлс өгдөггүй гэжээ (Зураг 4.7).



Ажлын хөлс төлөлтийн хэлбэр нь хүүхдийн нас болон хүйсийн хувьд маш бага ялгаатай байна.

Хөдөө орон нутагт малчдын цалин хөлс, орлогыг бэлэн мөнгөөр тооцоолоход нэлээд хүндрэлтэй байдаг. Айлд мал маллаж хүүхдүүдийн ажлын хөлсийг хотод гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй хүүхдүүд харьцуулах үлэмж бага байна (Бүлэг 3-ийн Хүснэгт 3.21-ийг харна уу). Үүнийг маш явцуу хүрээнд хөдөөд бэлэн мөнгөний хомсдол өндөр, түүнчлэн бэлэн мөнгөний хэрэгцээ харьцангуй бага байдгаар нэг талаас нь тайлбарлаж болох юм.

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн ажлын хөлсний жилийн дундаж хэмжээг 4 ангилалд хувааж үзсэн бөгөөд тархалт бүлгүүдийн хувьд тэнцүү бөгөөд жигд байна. Харин эрэгтэй хүүхдүүдийн жилийн дундаж ажлын хөлсний хэмжээ охидынхоос ерөнхийдөө доогуур байна (Хүснэгт 4.15). Айлд мал маллаж буй хүүхдүүд жилд дундажаар 37039 төгрөг, хамгийн бага нь 5000 төгрөг, хамгийн их нь 180000 төгрөгийг ажлын хөлсөнд авчээ. Эрэгтэй хүүхдүүдийн авч буй бэлэн мөнгөний хэмжээ охидынхоос ерөнхийдөө доогуур байна.

*Оглыйд 4.15* Айлд мал малладаг хүүхдүүдийн хувийн жин, өнгөрсөн 12 сард авсан ажлын хөлсний хэмжээ, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Ажлын хөлс авдаг				
	10000 ба түүнээс доош	10001-20000	20001-40000	40000-с дээш	Бүгд
Хүйс					
Эрэгтэй	31,1	26,7	20,0	22,2	100,0
Эмэгтэй	25,0	25,0	25,0	25,0	100,0
Нас					
6-11	8,3	25,0	41,7	25,0	100,0
12-14	38,7	29,0	9,7	22,6	100,0
15-17	26,9	23,1	26,9	23,1	100,0
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх					
Хамт амьдардаг	25,5	29,8	25,5	19,1	100,0
Хамт амьдардаггүй /Өнчин	36,4	18,2	13,6	31,8	100,0
Ажиллаж буй айл нь ямар хамааралтай болох					
Өвөө, эмээ, ах, эгч	26,7	6,7	26,7	40,0	100,0
Бусад хамаатан	33,3	30,6	19,4	16,7	100,0
Хамаатан бус	22,2	33,3	22,2	22,2	100,0
Бүгд	29,0	26,1	21,7	23,2	100,0
Ажлын хөлсөө бэлэн мөнгөөр авдаг хүүхдүүдийн тоо	20	18	15	16	66

Ажлын хөлсний хэмжээ өвөө, эмээгийндээ ажиллаж буй хүүхдүүдийн хувьд харьцангуй өндөр байна. Гайхалтай нь судалгаанд хамрагдсан ах, эгчийндээ мал маллаж буй 6 хүүхдээс нэг нь ч ажлын хөлсөө мөнгөн хэлбэрээр авдаггүй гэжээ. Холын хамаатныхаа айлд мал маллаж буй хүүхдүүдийг ажлын хөлсний хэмжээ ерөнхийдөө бага байна.

Хүүхдүүд айлд ажиллаж олсон мөнгөө эцэг эх, гэрийнхэндээ өгөх (55,9 хувь), хичээлийн хэрэгсэл худалдан авах (51,5 хувь), өөртөө зориулан хувцас, хунар худалдан авах (44,1 хувь), карманы мөнгө буюу өөрийн хүссэн ойр зуурын жижиг сажиг зүйлс худалдан авах (35,3 хувь) зэргээр зарцуулдаг байна.

Ажил олгогч мал маллаж буй хүүхдүүдэд ажлын хөлсийг мөнгөн бус хэлбэрээр төлөхдөө голдуу хувцас (84,5 хувь), хоол, хүнсний зүйл (65,2 хувь), мал (31 хувь) өгөх зэргээр тооцоогоо хийдэг ажээ.

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн гуравны нэг нь (32 хувь) өөрийн олсон мөнгөн болон мөнгөн бус орлогоосоо гэр бүлийнхэндээ өгдөг ажээ. Тухайбал, эдгээр хүүхдүүдийн 22,4 хувь нь ажил хийж олсон мөнгөн болон мөнгө бус орлогоосоо 25 хүртэл хувийг, 39,1 хувь нь 25-50 хувийг, 14,9 хувь нь 50-75 хувийг, үлдсэн 23,6 хувь нь

75-100 хувийг гэрийхэндээ өгч, өрхийн эдийн засагтаа тодорхой хувь нэмэр оруулж, эцэг эхдээ тусладаг байна.

Ажил олгогч мал маллаж буй хүүхдийн ажлын хөлсийг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр улирал тутамд олгодог гэж хүүхдүүдийн 50,4 хувь нь, сар бүр олгодог гэж 21,5 хувь нь хариулжээ. Айлд мал маллаж буй хүүхдийн хөдөлмөрийн хөлстэй холбоотой дээр дурьдсан судалгааны үр дүнгээс харахад мал маллаж буй нэрийн дор хүүхдүүд малчин айлын гэрийн ажлуудыг давхар хийж байгаа (ялангуяа охидын) хүүхдүүдийн хөдөлмөрийн хөлс нь ажлын цаг, ажлын төрөл, ачаалалтай огт уялдахгүй байгаа нь тодорхой харагдаж байна.

#### **Àæèë ïëäîâ÷ áîëîí õççöäçäèéí ðîîðîíäûí ðàðèëöàà**

Ажиллаж буй айлын эзэн өөртэй нь таатай харьцдаг гэж судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дийлэнх (92,6 хувь) нь үнэлжээ. Сайн хооллодог учраас хүүхдүүдийн 74,4 хувь нь, хувцас, хунар өгдөг учраас хүүхдүүлийн 11,6 хувь нь айлынхаа эзэнг сайхан харьцдаг гэсэн үнэлэлт өгч байна. Харин айлын эзэн таагүй харьцдаг гэж хариулсан эмэгтэй хүүхдийн хувийн жин (12,5 хувь) хөвгүүдийнээс 4 функтээр өндөр байна. Гүнзгийрүүлсэн ярилцлагаар айлын эзэн таагүй харьцаа нь их загнах, зодох, айлгаж сүрдүүлэх байдлаар илэрдэг гэж тодорхойлж байв.

Хэдийгээр айлд мал маллаж, мал аж ахуйн болон орон гэрийнх нь ажилд туслаж байгаа ч судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 3.7 хувь ажил олгогчдоо өөртэй байгаа ажээ. Энэ нь бага тоо мэт харагдавч хүүхэд бусдын хараат байдалд орж, хөдөлмөрийнхөө хөлсөөр өрөө төлдөг болохыг угүйсгэх аргагүй юм.

#### **4.2.5 Àéëä àæèëëàæ áóé ì àë÷èí õççöäçäèéí ðàððàëðûí áàéääë**

Судалгаа хэдийгээр гурванхан аймгийн цөөн сумдыг хамарсан ч гэсэн айлд мал маллаж хүүхдүүдээр дамжуулан ср нь хөдөө орон нутагт өөртэй нь адилхан айлд ажил хийдэг хүүхдүүдийн тархац, далайцыг маш өрөнхий байдлаар тодорхойлохыг бил зорьсон юм. Үр дүнг Хүснэгт 4.16-д харууллаа.

*Одийн 4.16* Айлд мал малладаг хүүхдүүдийн хувийн жин, айлд мал малладаг өөр хүүхдүүдийг мэддэг эсэх, хүйсээр

Сонгосон үзүүлэлтүүд	Мэддэг эсэх		Бүгд	Айлд мал малладаг хүүхдийн тоо
	Тийм	Үгүй		
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	39,7	60,3	100,0	174
Эмэгтэй	27,1	72,9	100,0	96
<b>Нас</b>				
6-11	25,9	74,1	100,0	58
12-14	37,4	62,6	100,0	99
15-17	38,1	61,9	100,0	113
<b>Бүгд</b>	<b>35,2</b>	<b>64,8</b>	<b>100,0</b>	<b>270</b>

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 35,2 хувь нь өөртэй нь адилхан айлд мал маллаж байгаа хүүхдүүдийг мэднэ гэж тодорхойлжээ. Айлд мал малладаг хүүхдүүдийг мэднэ гэж эрэгтэй хүүхдүүдийн 40 орчим хувь нь хариулсан бөгөөд орон нутагт эрэгтэй хүүхдүүд мал дээр түлхүү ажиллаж байгаатай холбоотойгоор тэдний дунд сургууль завсардалт өндөр байгаа билээ. Иймээс ч өөрсдтэй нь адилхан хүүхдүүд байдгийг эрэгтэй хүүхдүүд илүү мэддэг байна. Хүүхдийн нас ахихын хэрээр айлд мал малладаг хүүхдүүдийг мэднэ гэсэн хариултын хувь өсч байна.

Хүснэгт 4.17-д айлд мал малладаг хичнээн хүүхдийг мэдэх гэсэн асуултын хариултыг дэлгэрэнгүй харууллаа.

*Одийн 4.17* Айлд мал малладаг хүүхдүүдийг мэддэг хүүхдүүдийн хувийн жин, айлд мал малладаг хүүхдийн тооны талаарх мэдээлэл сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Айлд мал малладаг хүүхдийн тооны талаарх мэдээлэл						Бүгд	Хариулт өгсөн хүүхдийн тоо
	1	2	3	4	5	6		
<b>Нас</b>								
6-11	53,3	13,3	6,7	6,7	13,3	6,7	100,0	15
12-14	48,6	29,7	13,5	2,7	5,5	-	100,0	37
15-17	46,5	25,5	14,0	7,0	4,7	2,3	100,0	43
<b>Хүйс</b>								
Эрэгтэй	49,4	24,6	13,0	5,8	4,3	2,9	100,0	69
Эмэгтэй	46,3	26,9	11,5	3,8	11,5	-	100,0	26
<b>Бүгд</b>	<b>48,4</b>	<b>25,3</b>	<b>12,6</b>	<b>5,3</b>	<b>6,3</b>	<b>2,1</b>	<b>100,0</b>	<b>95</b>

Судалгаанд хамрагдсан нэг хүүхэд дундажаар өөр айлд мал маллах ажил хийж буй 2 хүүхдийг мэддэг, хамгийн олондоо 7 хүүхдийг мэдэх ажээ. Хүүхдүүдийн 50-аас илүү хувь нь айлд мал малладаг нэгээс олон хүүхдийг мэднэ гэж хариулсан байна. Эндээс мал аж ахуйн салбарт хөлсний хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөр хэр тархсаныг харж болох ба хөлсний малчны хөдөлмөрийн үнэлгээний асуудал нь цаашид судлах судалгааны нэг сэдэв байж болох юм.

## Албандаа дээрээсээ

Тухайн айлд мал маллахаас гадна өөр ямар иэгэн ажил хийдэг гэж судалгаанд хамрагдсан 270 хүүхдээс 18 нь буюу 6,7 хувь нь хариулжээ. Тэд өөр айлд мал маллах, айлын гэрийн ажил хийх, түлээ, самар, жимс бэлтгэж зarah ажлуудыг жилийн бүх улирилд хийдэг байна. Долоо хоногт давхар хийж буй ажилдаа дундажаар 4 өдөр, дундажаар 11 зарцуулдаг байна.

### 4.3 Эрүүл мэнд ба хөдөлмөр хамгаалал

#### 4.3.1 Үзүүлэхэд хүчинчлэлийн хувь

Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 25,6 хувь нь ажил хийж байх хугацаандаа өвдөж байжээ. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн эрүүл мэндийн срөнхий байдлыг Хүснэгт 4.18-д хүйс болон насны бүлгээр харуулав. Хүйсийн хувьд эрүүл мэндийн байдал ялгаа багатай, харин насны бүлгийн хувьд бага буюу 6-11 насны хүүхдүүдийн өвдсөн байдал бусад насны хүүхдүүдийнхээс өндөр байна.

Олонийн 4.18 Айлд мал малладаг хүүхдүүдийн хувийн жин, ажиллаж байхдаа өвдсөн эсэх, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Ажиллаж байхдаа өвдөж байсан		Бүгд	Айлд мал малладаг хүүхдийн тоо
	Тийм	Үгүй		
Хүйс				
Эрэгтэй	26,4	73,6	100,0	174
Эмэгтэй	24,0	76,0	100,0	96
Нас				
6-11	31,0	69,0	100,0	58
12-14	27,3	72,7	100,0	99
15-17	21,2	78,8	100,0	113
Бүгд	25,6	74,4	100,0	270

Ажил хийж буй хүүхдийн эрүүл мэндийн байдлыг эмнэлгийн үзлэгээр оруулж хянаагүй, зөвхөн хүүхдийн өөрийн амаар тодорхойлж буйг энд анхаарна уу. Ажиллаж байхдаа өвдөж байсан хүүхдүүдийн 37,7 хувь нь судалгаа авах үед өвчтэй хэвээр байна гэжээ. Өөрийгөө өвчтэй байгаа гэж хариулсан охид болон 12-оос дээш насны хүүхдүүдийн хувийн жинг эрэгтэй хүүхдүүд, бага насны (12-оос дооп) хүүхдүүдтэй харьцуулахад 12 орчим пунктээр өндөр байна.

Нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид нь халуун, хүйтэнд гадаа ажиллахын зэрэгцээ эрс тэс байгаль, цаг ууртай манай орны хувьд даарч хөрөх, улмаар малчид үе мөч, хоолой ам өвдөх, ханиад томууд өртөмтгийн байдаг. Өвдсөн хүүхдүүдийн дунд ханиад хүрсэн, толгой, хоолой, нуруу, гар хөл, үе мөч өвдсөн гэсэн хүүхдүүдийн хувь хамгийн өндөр байв. Өөрийн өвчний байдлын талаар хүүхдүүдийн 43,5 хувь (30 хүүхэд) нь эмч, эмнэлгийн ажилтнаас зөвлөгөө, тусlamж авсан байна. Эдгээр хүүхдүүд багийн эмч, мэргэжлийн эмчээс зөвлөгөө, тусlamж авсан нэн сайшаалтай

юм. Эмчид үзүүлэхэдээ 53,3 хувь нь төлбөр төлж, төлбөрийг нь эцэг эх болон ажил олгогч хийжээ.


*Одойт 4.19 Ажиллаж байхдаа өвдсөн айлд мал малладаг хүүхдүүдийн хувийн жин, одоог хүртэл өвчтэй байгаа эсэх, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Одоог хүртэл өвчтэй байгаа эсэх		Бүгд	Ажиллаж байхдаа өвдсөн хүүхдийн тоо
	Тийм	Үгүй		
Хүйс				
Эрэгтэй	32,6	67,4	100,0	46
Эмэгтэй	47,8	52,2	100,0	23
Нас				
6-11	27,8	82,2	100,0	18
12-14	37,0	63,0	100,0	27
15-17	45,8	54,2	100,0	24
Бүгд	37,7	62,3	100,0	69

Өвчтэй байгаа хэрнээ эмнэлгийн ямар нэгэн тусламж, зөвлөгөө аваагүй гэж 39 хүүхэд хариулсан байна. Гол шалтгаан нь эрүүл мэндийн төв хол, үзүүлэхийг өөрөө хүсээгүй явдал байв.

### Үзүүлэлтэй өвчтэй бий хүүхдүүдийн хувийн жин, хийж буй ажил нь эрүүл мэндэд нь сөрөг нөлөөтэй талаархи үзэл бодол, хүйсээр

Өөрийн нас, физиологийн хөгжилд тохирсон, аюулгүй ажил хийх нь хүүхдийн хөдөлмөр, хүмүүжилд тодорхой ач холбогдолтой нь ойлгомжтой боловч нүүдлийн мал аж ахуйтай манай орны хувьд гадаа хүйтэнд удаан ажиллах, эзгүй хээр ганцаараа байх зэрэг хүүхдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, цаашилбал гэнэтийн осолд өртөх магадлал өндөр юм. Зураг 4.8-д одоогийн хийж буй ажил нь эрүүл мэндэд нь сөрөг нөлөөтэй эсэх талаархи хүүхдүүдийн үзэл бодлыг хүйсээр ялган харуулав.




Айлд мал маллаж буй хүүхдүүдийн 40,7 хувь нь одоогийн хийж буй ажил нь өөрсдийнх нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж үнэлжээ. Эрүүл мэндийн байдал нь илүү сөрөг нөлөөтэй гэж хариулсан эмэгтэй хүүхдүүдийн эзлэх хувийн жин (42,7 хувь) хөвгүүдийнхээс 3 пунктээр илүү байна.

### *Ӵօőө ѿð Ӵàì Ӵàäéèé*

Ажил хийж байхдаа хүүхдүүдийн 71,9 хувь дулаан гутал, хувцас өмсдөг, саальд гарахдаа муу хувцас голдуу хэрэглэдэг гэжээ. Үйлдвэр аж ахуй, эсвэл уул уурхайн салбарт хөдөлмөр эрхлээгүй хэдий ч гадаа байнга ажилладаг, морь малтай байнга харьцааг гэдэг утгаараа хүүхэд өвлийн улиралд дулаан хувцас, борооны цув, нарны малгай гэх мэт тухай ажлын онцлогт тохирсон хөдөлмөр хамгааллын хувцастай байх ёстой. Судалгаагаар гурван хүүхэд тутмын хоёр нь л боломжийн ажлын хувцастай гэсэн нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

### *Ӣ Ӵó Ӵàäéèé áâ Ӵ᳚Ӵàééé Ӵ᳚᳚ Ӵ᳚᳚*

Айлд мал маллаж буй эрэгтэй хүүхдүүдийн 12,6 хувь нь тамхи татдаг, 16,1 хувь нь согтууруулах ундааны зүйлс хэрэглэдэг байна. Харин охидын 10,4 хувь нь согтууруулах ундааны зүйл хэрэглэдэг гэжээ (Зураг 4.9). Тамхи татаж эхэлсэн дундаж нас 12,9, харин согтууруулах ундааны зүйлс хэрэглэж эхэлсэн нас түүнээс 2 жилээр эрт буюу 10,9 нас байна. Согтууруулах ундаа хэрэглэж, тамхи татаж эхэлсэн насны доод хязгаар 5, дээд хязгаар 16 (аль алинд нь адилхан) байна.



Судалгаагаар айлд мал маллаж буй хүүхдүүдийн дунд мансууруулах бодис хэрэглэдэг гэж хүүхдүүдийн тодорхой хэсэг нь хариулсан. Энэ нь хөдөө орон нутгийн өсвөр үеийнхний дунд мансууруулах бодисын хэрэглээ байдаг, тэр ч битгий хэл эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн аль алинд нь байгаа нь анхаарал татаж байна.

Айлд мал маллаж буй хүүхдүүдээс 12-17 наасны 5 эрэгтэй хүүхдийн 3 нь хулгай, танхайн хэргээр, 2 нь хүчингийн хэргээр цагдаа, сэргийлэхэд дуудагдаж байжээ.


#### 4.4 Хүүхдийн чөлөөт цаг ба хүсэл тэмүүлэл

##### Орчим хувь

Мал маллаж буй хүүхдийн 70 хувь нь чөлөөт цагаа гэртээ, 17 орчим хувь нь эмээ өвөө, найз нөхдийндөө өнгөрөөж байна. Хичээл давтах боломжтой (46 хувь), гэрийнхээ ажил туслах (40 хувь), хүүхдүүдтэй тоглох (25 хувь) зэрэг шалтгааны улмаас хүүхдүүд чөлөөт цагаа дээрх газруудад өнгөрөөдөг гэжээ. Хөдөөд мал маллаж буй хүүхдүүдийн түгээмэл хобби нь урлаг, уран сайхан (27 хувь), спортоор (16 хувь) хичээллэх, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом тоглох (18 хувь) зэргээр тодорхойлогдож байна.

##### Ажлын түвшин

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс “Хэрвээ сургууль сурах, ажил хийх боломжийн нэгийг нь сонго гэвэл та алийг нь сонгох вэ?” гэсэн асуулт тавьж, хүүхдийн сурах болон ажиллах хүсэл эрмэлзлэлийг тодруулахыг бид зорьсон юм. Үр дүнг Зураг 4.10-д хүүхдийн наасны бүлгээр харуулав.



Нийт хүүхдүүдийн 68,1 хувь нь сурах, 28,9 хувь нь ажиллах боломжийг сонгосон байв. Насны бүлгээр авч үзэхэд бага наасны хүүхдүүдийн талаас илүү хувь нь сурах боломжийг, харин 15-17 настай хүүхдүүдийн 80-аас илүү хувь нь ажиллах боломжийг сонгожээ. Тодруулбал, хүүхдийн нас ахих тусам сурах боломжоос татгалзаж, ажиллах сонирхол нь ихэсч байна. Өөртөө итгэл муу байгаагаас сонголт хийхээ мэдэхгүй гэж цөөн тооны хүүхэд хариулжээ. Ийм хариулт өгсөн хүүхдийн хувь 15-17 наасны хүүхдүүдийн дунд харьцангуй өндөр байна.

Суурь боловсрол заавал эзэмших ёстой насандаа айлд ажил хийх бус сургуульд сурч байх үүрэгтэй гэдгээ хүүхдүүдийн 74,7 хувь нь хүлээн зөвшөөрч байв.

Хүснэгт 4.20-д айлд мал малладаг хүүхдүүд ажил хийх дуртай байгаа эсэхийг хүүхдийн хүйс болон насны бүлгээр харуулав.

*Оглайлын 4.20 Айлд мал малладаг хүүхдүүдийн хувийн жин, ажил хийх дуртай байдал, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Ажил хийх дуртай эсэх		Бүгд	Айлд мал малладаг хүүхдийн тоо
	Тийм	Үгүй		
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	92,5	7,5	100,0	174
Эмэгтэй	84,4	15,6	100,0	96
<b>Нас</b>				
6-11	81,0	19,0	100,0	58
12-14	89,9	10,1	100,0	99
15-17	93,8	6,2	100,0	113
Эцэг, эхтэйгээ хамт амьдардаг эсэх				
Хамт амьдардаг	92,2	7,8	100,0	154
Хамт амьдардаггүй/Өнчин	86,2	13,8	100,0	116
Бүгд	89,6	10,4	100,0	270

Судалгаанд хамрагдсан дийлэнх (89,6 хувь) хүүхдүүд ажил хийх дуртай байгаа ажээ. Ялангуяа хөвгүүд (92,5 хувь), 15-17 насныхан (93,8 хувь), мөн эцэг эхтэйгээ хамт амьдардаг хүүхдүүдийн (92,2 хувь) хувьд ийм хандлага нэлээд өндөр байна. Ажил хийх сонирхолыг төрүүлж буй хамгийн том шалтгаан нь гэрийнхэндээ тус дэм болох явдал гэж хүүхдүүдийн талаас илүү хувь нь тодорхойлжээ (Хүснэгт 4.21). Өрхийн ядуу зүдүү байдал нь хүүхэд ажил хийх сонирхолыг нэмэгдүүлж байгааг бусад судалгааны үр дүн мөн харуулж байсан.<sup>16</sup>

<sup>16</sup> Нийгмийн Хөгжлийн Төв, 2001. Айлд мал маллаж байгаа хүүхдийн байдал, судалгааны тайлан, Улаанбаатар

*Өгүй ёс 4.21* Айлд мал малладаг ажил хийх дуртай хүүхдүүдийн хувийн жин, хүйс, шалтгаанаар

Шалтгаан	Хүйс		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Гэрийнхэндээ тус дэм болдог	55,3	59,3	56,6
Суралцахтай холбоотой мөнгө олдог	3,7	2,5	3,4
Хоол, хүнс авах мөнгөтэй болдог	2,5	2,5	2,5
Өөрийн гэсэн мөнгөтэй болдог	7,5	7,4	7,4
Найз нартайгаа ажиллахад зугаатай байдаг	4,3	4,9	4,5
Ажиллахгүй бол амьдрахгүй	7,5	11,1	8,7
Зүгээр сууснаас дээр	12,4	3,7	9,5
Ирээдүйд хэрэгтэй	6,8	8,6	7,4
Бүгд	100,0	100,0	100,0
Ажил хийх дуртай хүүхдүүдийн тоо	161	81	242

Хүснэгт 4.22-д айлд мал маллах дургүй байгаа шалтгааныг хүүхдийн хүйсээр задлан харуулав. Ажил хийх дургүй байгаа хүүхдүүдийн хамгийн гол шалтгаанаа мал маллах ажилдаа сонирхолгүй гэж тодорхойлсон байна. Мөн сургуульд явж чаддаггүй гэсэн шалтгаан ялангуяа эрэгтэй хүүхдийн (30,8 хувь) хувьд өндөр байна.

*Өгүй ёс 4.22* Айлд мал малладаг ажил хийх дургүй хүүхдүүдийн хувь, хүйс, шалтгаанаар

Шалтгаан	Хүйс		
	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
Бис өвддөг, өвчин тусдаг	-	20,0	10,7
Сургуульд явж чаддаггүй	30,8	20,0	25,0
Энэ ажилдаа сонирхолгүй	53,8	53,3	53,6
Их ядардаг	15,4	6,7	10,7
Бүгд	100,0	100,0	100,0
Ажил хийх дургүй хүүхдүүдийн тоо	13	15	28

Судалгаанд хамрагдсан айлд мал маллах буй хүүхдүүдээс ирээдүйн ажлын талаар асууж сонирхоход 53,3 хувь нь хөдөө аж ахуйн бус салбарт, 34,8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт ирээдүйдээ ажиллаж хийж чадна гэж үзсэн байна.

Àæèëë õèéõýä òî õèïëäî æ áóé áýðõøýyë

Айлд мал малхаад хүүхдүүдэд хэл амаар доромжлох (27 хувь), айлган сүрдүүлэх (14,4 хувь), хөлс бага төлөх эсвэл огт төлөхгүй байх (12-13 хувь) зэрэг олон бэрхшээлүүд тохиолддог байна (Хүснэгт 4.23). Эрэгтэй хүүхдүүдийг айлын эзэн/эзэгтэй зодох, харин эмэгтэй хүүхдүүдийн хэл амаар доромжлох үзэгдлийн хувь өндөр байна. Гүнгийрүүлсэн ярилцлагын үр дүн ч мөн хандлагыг илрхийлж байв.

*Одийн 4.23 Айлд мал малладаг хүүхдуудийн хувь, хүйс, тохиолдож буй бэрхшээлээр*

Бэрхшээл	Хүйс		БҮГД	Тоо
	Эрэгтэй	Эмэгтэй		
Айлын эзэн/эзэгтэй зодох	12,1	3,1	8,9	24
Бэлгийн хүчирхийлэл	1,7	2,1	1,9	5
Хэл амаар доромжлох	24,7	31,3	27,0	73
Айлган сүрдүүлэх	14,9	13,5	14,4	39
Бага хоол өгөх/Хоол өгөхгүй байх	5,2	3,1	4,4	12
Бага хөлс төлөх	12,1	12,5	12,2	33
Хөлс төлбөр огт төлдөггүй	13,8	13,5	13,7	37

Хэрвээ дээрх байдлаар айлд мал маллаж, гэр орных нь ажлыг хийж байхад нь хэн нэгэн хандвал хүүхдүүд хамгийн түрүүнд эцэг эх, ах эгчдээ (70 хувь) мэдүүлнэ гэжээ.

Хүүхэд хөдөлмөр эрхэлж болох хуулинд заасан насыг айлд мал маллаж буй хүүхдүүдийн 29 хувь нь зөв тодорхойлжээ. Хүүхдийн нас ахих тутам хуулийг насыг зөв тодорхойлсон хувийн жин нэмэгдэж байна.

Судалгаанд хамрагдсан айлд мал маллаж байгаа нийт хүүхдүүдийн 14,1 хувь (эрэгтэй хүүхдүүдийн 17,2 хувь, эмэгтэй хүүхдүүдийн 8,3 хувь) нь айлд мал маллаж байгаад болысон хүүхдүүдийг мэднэ гэж хариулсан байна. Тэдний мэдүүлж байгаагаар ийм ажлыг хийхээ болысон хүүхдүүдийн дийлэнх нь сурч байгаа ажээ.

Айлд мал маллах ажлыг хийж байгаа хүүхдүүдийн 73 хувь нь өөрийн ах эгч, дүүдээ айлд мал маллахыг зөвлөхгүй гэж хариулжээ. Ийм хариулт өгсөн охидын хувийн жин (82,3 хувь) эрэгтэй хүүхдүүдийнхээс 15 пунктээр илүү байна. Охид илүү их ачаалалтай ажилладаг учраас ийм саналыг гаргахгүй байхад нөлөөлдөг байж юм. Харин хүүхдүүдийн 60 хувь нь энэ ажлаа цаашид үргэлжүүлэн хийх бодолтой байгаа аж. Айлд мал маллах ажлаа үргэлжүүлэх хүсэлтэй байгаа эрэгтэй хүүхдүүдийн хувийн жин (67,2 хувь) охидынхоос даруй 22 пунктээр илүү байна. Хүүхдүүдийн тооцоолж байгаагаар цаашид айлд мал маллах ажил дээр дундажаар 10 жил хугацаатай ажиллах хүсэлтэй байгаа ба эрэгтэй хүүхдүүдийн үргэлжүүлэн ажиллах хугацаа охидоос бараг 2 дахин урт (харгалзан 11 жил, 6 жил) байна. Эндээс мал дээр ажиллаж буй эрэгтэй хүүхдүүдийн дийлэнх нь өрөөсөө л суралцах сонирхолгүй байгааг дахин харж болох юм.

Айлд мал маллах ажлыг цаашид үргэлжүүлэн хийх бодолгүй байгаа хүүхдүүдийн 70 гаруй хувь нь сурах төлөвлөгөөтэй байгаа ажээ. Хүүхдийн нас буурах тусам суралцах хүсэлтэй хүүхдийн хувийн жин нэмэгдэж байгаа нь сайншалтай юм. Харин ямар ч хамаагүй цалинтай ажил хийх хүсэлтэй байгаа хүүхдүүд 10 гаруй хувийг эзэлж байна.

Мал маллаж буй хүүхдүүдийн 36,3 хувь нь мэргэжилтэй, 25,6 хувь нь хөдөө аж ахуй/фермерийн ажилтан, 10 гаруй хувь нь үйлчилгээний ажилтан болох хүсэлтэй байна гэсэн нь бусад мэргэжлийн ангилаас хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Ямар нэгэн төрийн бус байгууллагаас туслаж байсан гэж хүүхдүүдийн 18,1 хувь нь хариулжээ. Төрийн бус байгууллагын туслалцаа авсан охидын хувийн жин (22 хувь) эрэгтэй хүүхдүүдийнхээс 6 пунктээр илүү байна. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаархи иймэрхүү төрлийн судалгаанд хүүхдүүдийн 96,7 хувь нь огт хамрагдаж байгаагүй байна.


## **БҮЛЭГ 5. ГЭРИЙН ҮЙЛЧЛЭГЧ/АЙЛД МАЛ МАЛЛАЖ БҮЙХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ/ЭХ**

Энэхүү бүлэгт гэрийн үйлчлэгч болон айлд мал маллаж буй хүүхдүүдийн үндсэн өрх, өрхийн гишүүдийнх нь шинж байдал, хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл болон ирээдүйн талаарх эцэг/эхийн үзэл бодлыг авч үзэх болно.

## **5.1 Судалгаанд хамрагдсан эцэг/эх, тэдний өрхийн гишүүдийн шинж байдал**

Айлд гэрийн үйлчлэгч болон мал маллах ажил хийж буй нийт хүүхдүүдийн 62 хувь буюу 168 хүүхдийн эцэг/эх (хотын 44, хөдөөгийн 124) энэхүү судалгаанд давхар хамрагдсан бөгөөд тэдний өрхийн гишүүдийн нас, хүйсийн бүтцийг Зураг 5.1-д байршилаар харуулав.

### *Çödää 5.1 Θрхийн гишүүдийн хувийн жин, нас, хүйсийн бүтэц, байршилаар*



Судалгаанд хамрагдагчдын хүйсийн харьцаа хот, хөдөөд срөнхийдөө тэнцвэртэй боловч 20-оос доош насныханы хувьд эрэгтэйчүүд, 30-аас дээш насныханы хувьд

эмэгтэйчүүдийн тоо бага зэрэг илүү байна. Насны бүтцийг авч үзвэл 20 хүртэлх насны хүн амын тоо бусад насны бүлгийнхнээс их байгаа нь 35-49 насны үелрэлийн төрөлтийн түвшин өндөр байсныг харуулж байгаа болов уу.

Голч насыг харвал (Хүснэгт 5.1) судалгаанд хамрагдсан бүх хүн амын тал хувь нь 17-оос доош, үлдсэн тал хувь нь түүнээс дээш насныхан байгаа ба хот, хөдөөд энэ үзүүлэлт ялгаагүй байна. Ерөнхийдөө хөдөлмөр эрхлэх насныхан (59.4%) нийт хүн амын бараг 2/3-ийг эзэлж байгаа учраас хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хөдөлмөрийн бус насны хүн амын тоо буюу хүн ам зүйн ачаалал тийм ч өндөр биш (хотод 71, хөдөөд 67.4) гарчээ.

*Одийн 5.1 Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн хувийн жин, сонгосон үзүүлэлт, байршилаар*

Шинж байдлын сонгосон үзүүлэлт	Байршил		Бүгд
	Хот	Хөдөө	
Боловсролын түвшин			
Боловсролгүй	23.6	33.2	31.0
Бага	23.2	34.0	31.4
Бүрэн бус дунд	26.1	19.6	21.1
Бүрэн дунд	19.2	9.5	11.8
Тусгай мэргэжлийн дунд/ББД	5.9	3.4	4.0
Дээд	2.0	0.3	0.7
Бүгд	100.0	100.0	100.0
7 ба түүнээс дээш настай хүн амын тоо	203	653	856
Ажил эрхлэлтийн байдал			
Ажилладаг/Хувиараа ажил эрхэлдэг	26.2	9.5	13.4
Мал малладаг	1.5	20.6	16.1
Сурдаг	19.4	22.8	22.0
Тэтгэвэрт	1.0	2.5	2.2.
Тахир дутуугийн группт	4.9	1.0	1.9
Гэрийн ажилтай	2.9	7.4	6.4
Гэрийн үйлчлэгч/айлд мал малладаг хүүхэд	23.8	21.9	22.3
Ажилгүй	16.5	10.1	11.6
Гэртээ	3.8	4.2	4.1
Бүгд	100.0	100.0	100.0
6 ба түүнээс дээш настай хүн амын тоо	206	672	878
Насны бүлэг			
0-14 насны хүн ам	40.7	38.0	38.7
15-59 насны хүн ам	58.5	59.8	59.4
60 ба түүнээс дээш насны хүн ам	0.8	2.2	1.9
<i>Одийн 5.1 өдөрний хувь</i>	<i>71.0</i>	<i>67.4</i>	<i>68.3</i>
<i>Айлд бааралт</i>	<i>17.0</i>	<i>17.0</i>	<i>17.0</i>
Бүгд	100.0	100.0	100.0
Нийт хүн амын тоо	236	718	954

Айлд ажиллаж буй хүүхдүүдийн үндсэн өрхийн гишүүдийн боловсролын байдлыг харвал, 7 ба түүнээс дээш настай хотын хүн амын 73.0 хувь, хөдөөгийн хүн амын 86.8 хувь нь тус тус бүрэн бус дунд болон түүнээс доош түвшингийн боловсролтой байна. Эдийн засгийн идэвхийн хувьд хотод тодорхой байгууллагад, эсвэл хувиараа ажил эрхэлдэг хүмүүс (26.2), хөдөөд малчид (20.6 хувь) бусдаас өндөр хувь эзэлж байгаа юм. Харин үүний дараа гэрийн үйлчлэгч/айлд маллаж буй хүүхдүүд (хотод 23.8 хувь,

хөдөөд 21.9 хувь), суралцагчид (хотод 19.4 хувь, хөдөөд 22.8 хувь) болон ажилгүйчүүд (хотод 16.5 хувь, хөдөөд 10.1 хувь) орж байна.

### *5.1.2 Аялалын түвшиний структурын хувийн жин, хүн ам зүйн шинж байдал, байршилаар*

Гэрийн үйлчлэгч болон айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн эцэг/эхээр асуулгад хариулагчдын шинж байдлыг авч үзвэл дундаж нас нь хотод 38.6, хөдөөд 42.7 байсан ба 25-54 насныхан ихэнхийг (хотын хариулагчдын 97.7 хувь, хөдөөгийн хариулагчдын 92 хувь) эзэлж байв. Хүйсийн хувьд хотын хариулагчдын 86.4 хувь, хөдөөгийн хариулагчдын 61.3 хувь нь тус тус эмэгтэйчүүд байлаа (Хүснэгт 5.2).

*5.2 Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, хүн ам зүйн шинж байдал, байршилаар*

Сонгосон үзүүлэлт	Байршил		Бүгд
	Хот	Хөдөө	
<b>Нас</b>			
25 хүртэл	2.3	0.8	1.2
25-34	27.3	9.7	14.3
35-44	56.8	57.3	57.1
45-54	13.6	25.0	22.0
55-64	0.0	5.6	4.2
65 ба түүнээс дээш	0.0	1.6	1.2
<b>Аялалын түвшиний структура</b>	<b>38.6</b>	<b>42.7</b>	<b>41.6</b>
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	13.6	38.7	32.1
Эмэгтэй	86.4	61.3	67.9
<b>Өрхөд амьдарч буй хүний тоо</b>			
1-3	18.2	13.7	14.9
4-5	36.4	33.9	34.5
6 ба түүнээс дээш	45.4	52.4	50.6
<b>Аялалын түвшиний структура</b>	<b>5.4</b>	<b>5.8</b>	<b>5.7</b>
<b>Боловсролын түвшин</b>			
Боловсролгүй	4.5	9.7	8.3
Бага	4.5	25.0	19.6
Бүрэн бус дунд	43.3	35.4	37.6
Бүрэн дунд	29.5	20.2	22.6
Тусгай мэргэжлийн дунд/ББД	15.9	9.7	11.3
Дээд	2.3	0.0	0.6
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>			
Ажилладаг/Хувиараа ажил эрхэлдэг	47.7	22.6	29.2
Мал малладаг	0.0	37.1	27.4
Тэтгэвэрт	0.0	4.8	3.6
Тахир дутуугийн группт	11.4	2.5	4.7
Гэрийн ажилтай	11.4	14.5	13.7
Ажилгүй	29.5	18.5	21.4
<b>Шилжилтийн байдал</b>			
Шилжигч	22.7	0.8	6.5
Шилжигч бус	77.3	99.2	93.5
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>44</b>	<b>124</b>	<b>168</b>

Нийт эцэг/эхчүүдийн тал хувь нь 6, түүнээс дээш тооны гишүүнтэй буюу нэлээд өнөр өрхөд амьдарч байна. Үүнийг байршилаар авч үзвэл, айлд хүүхдээ ажиллуулж буй хөдөөгийн эцэг/эхчүүдийн өрх хотын өрхүүдээс илүү олон гишүүнтэй байв. Тухайлбал, хотын эцэг/эхийн 45.4 хувь нь 6 ба түүнээс олон гишүүнтэй өрхөд амьдарч байхад хөдөөгийн эцэг/эхчүүдийн хувьд энэ үзүүлэлт 52.4 хувь байлаа. Түүнчлэн хотын нэг өрх дунджаар 5.4 гишүүнтэй байхад хөдөөгийн нэг өрх 5.8 гишүүнтэй байгаа нь ч дээрх дүгнэлтийг баталж байна.

Айлд хүүхдээ ажиллуулж буй эцэг/эхчүүдийн боловсролын түвшинг авч үзвэл, бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролтой хариулагчид бусдаас өндөр хувь (60.2 хувь) эзэлж байв. Гэхдээ бүрэн дундаас дээш түвшингийн боловсролтой хүмүүс (11.9 хувь) боловсролгүй болон бага боловсролтой хүмүүсээс 2.3 дахин бага байлаа. Энэ хандлага байршилаар илүү тод харагдаж байна. Тухайлбал, хөдөөд хоттой харьцуулахад огт боловсролгүй хариулагчид (9.7 хувь) 2 дахин, бага боловсролтой хариулагчид (25.0 хувь) 6 дахин их боловч бүрэн дундаас дээш түвшний боловсролтой хариулагчид (9.7 хувь) бараг 2 дахин цөөн байгаа юм.

Судалгаанд хамрагдсан хотын хариулагчдын 3/4 нь эдийн засгийн хувьд идэвхтэй (ямар нэгэн байгууллагад ажилладаг/хувиараа ажил эрхэлдэг болон ажилгүй) хүмүүс байна. Харин хөдөөгийн хариулагчдын дунд малчин (37.1 хувь), тодорхой ажил эрхэлдэг (22.6 хувь) болон ажилгүй (18.5 хувь) хүмүүс бусдаас өндөр хувь эзэлж байгаа юм. Эдгэрээс гадна гэрийн ажилтай хариулагчид ч багагүй хувь (хотод 11.4 хувь, хөдөөд 14.5 хувь) эзэлж байгааг харж болно.

Эцэг/эхчүүдийн шилжилтийн байдлыг авч үзвэл, 6.5 хувь буюу нийт 11 хүн сүүлийн 5 жилийн хугацаанд өөр орон нутгаас судалгаа авч буй орон нутагт шилжин ирж суурьшсан байна. Үүний 10 нь хотын, 1 нь хөдөөгийн хариулагч байв. Шилжин ирэгчдийн 45.5 хувь нь Төв аймгаас, харин Говь,-Алтай, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорнод Сүхбаатар аймгуудаас тус бүр нэг хүн шилжин иржээ. Шилжин ирэгчид тухайн нутагт амьжиргаагаа дээшлүүлэх (63.6 хувь), хамаатан саднаа бараадах (27.3 хувь), экологийн нөхцөл (9.1 хувь) гэсэн шалтгаануудаар шилжин ирсэн байна.

## 5.2 Судалгаанд хамрагдагчдын ахуйн нөхцөл

Эцэг/эхчүүд айлд хүүхдээ ажиллуулж байгаа нь тэдний амьдралын ахуйн нөхцөл, амьжиргаанаас тодорхой хэмжээгээр хамаарч байж болох юм. Иймээс ч, эцэг/эхчүүдээс ахуйн ямар нөхцөлд амьдарч байгааг тодруулах зарим мэдээлэл цуглуулсан ба үр дүнг Хүснэгт 5.3-т харуулав.

Хүүхдээ айлд ажиллуулж байгаа эцэг, эхчүүдийн 4/5 нь гэрт, үлдсэн нь сууцны тусдаа байшин болон нийтийн сууцны байшин доторх сууцанд амьдардаг байна. Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн буюу хотын эцэг/эхчүүдийн 65.9 хувь нь сууж буй сууцаа өөрсдийн эзэмшлийнх, 18.2 хувь нь хамаатан/найз/танилын сууц гэжээ. Харин хөдөөгийн хариулагчид бараг бүгдээрээ (95.2 хувь) өөрсдийн эзэмшлийнхээ сууцанд амьдарч байгаа ба 2.4 хувь нь хамаатан/найз/танилын сууцанд амьдарч байв.

Түүнчлэн хотын хариулагчдын 6.8 хувь, хөдөөгийн хариулагчдын 2.4 хувь нь тус тус ажил олгогчийн сууцанд төлбөргүйгээр сууж байна гэсэн хариултыг өгчээ.

Нийт хариулагчдын 12.5 хувь нь сууцандаа үндсэн ам бүлээс гадна бусад хүмүүстэй хамт амьдарч байгаа ба энэ үзүүлэлт хотын хариулагчдын хувьд (18.2 хувь) хөдөөгийнхөөс 7.7 пунктээр өндөр байна.

Эцэг/эхчүүд өөрсдийн амьдардаг сууцны багтаамж, аюулгүй байдал, дээвэр, ханын материал гэх мэтийг харгалзан сууцаа срөнхийд нь үнэлсэн байдлыг авч үзвэл, дийлэнх (хотын хариулагчдын 86.4 хувь, хөдөөгийн хариулагчдын 80.6 хувь) нь муу буюу дунд зэрэг гэж үнэлжээ.

*Одийд 5.3 Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд, байршилаар*

Ахуйн нөхцлийн үзүүлэлтүүд	Байршил		Бүгд
	Хот	Хөдөө	
<b>Сууцны төрөл</b>			
Гэр	61.4	88.7	81.6
Сууцны тусдаа байшин	36.4	11.3	17.8
Нийтийн сууцны байшин доторх сууц	2.2	0.0	0.6
<b>Сууцны эзэмшил</b>			
Өөрийн эзэмшлийн	65.9	95.2	87.5
Өөрийн эзэмшлийн бус:			
Түрээслэн сууж байгаа	9.1	0.0	2.4
Ажил олгогчийн сууцанд төлбөргүй сууж байгаа	6.8	2.4	3.6
Хамаатан/Найз/Танилын сууцанд төлбөргүй сууж байгаа	18.2	2.4	6.5
<b>Сууцаа бусадтай хамтран эзэмшиж буй эсэх</b>			
Тийм	18.2	10.5	12.5
Үгүй	81.8	89.5	87.5
<b>Сууцаа үнэлсэн байдал</b>			
Муу	29.6	19.4	22.0
Дунд зэрэг	56.8	61.2	60.1
Сайн	13.6	19.4	17.9
<b>Үндны усны эх үүсвэр</b>			
Төвлөрсөн: Халуун, хүйтэн устай	2.3	0.0	0.6
Хамгаалалттай худаг	81.8	12.1	30.4
Хамгаалалтгүй худаг	9.1	22.6	19.0
Булаг, шанд, ражаан	6.8	13.7	11.9
Гол, мөрөн	0.0	51.6	38.1
<b>Хоолоо хийхдээ ашигладаг эрчим хүчний эх үүсвэр</b>			
Цахилгаан	18.2	2.4	6.5
Мод	45.5	44.4	44.7
Нүүрс	34.1	0.0	8.9
Аргал	2.2	53.2	39.9
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Тоо</b>	<b>44</b>	<b>124</b>	<b>168</b>

Үндны усны эх үүсвэрийг байршилаар үзвэл нэлээд ялгаа харагдаж байна. Хотын хариулагчдын хувьд эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй эх үүсвэрээс ус хэрэглэдэг байдал харьцангуй бага (15.9 хувь) байхад хөдөөгийн хариулагчдын ихэнх буюу 87.9 хувь нь дээрх эх үүсвэрээс үндны усаа авч хэрэглэдэг гэжээ. Голлон ашигладаг эрчим


хүчний эх үүсвэрийг сонирхвол хамгийн өндөр хэрэглээтэй түлш нь хотод мод (45.5 хувь) болон нүүрс (34.1 хувь), хөдөөд аргаль (53.2 хувь), мод (44.4 хувь) байсан нь нийт өрхүүдийн дийлэнх гэрт амьдардагтай шууд холбоотой болов уу.

Ахуйн нөхцлийн дээрх шинж байдлуудаас харахад айлд хүүхдээ ажиллуулж буй эцэг/эхчүүдийн амьдарч буй ахуйн нөхцөл нэлээд хангалтгүй, ялангуяа хөдөөд ихээхэн анхаарал татахаар байна.

### 5.3 Судалгаанд хамрагдагчдын орлого


Өрхийн орлого, амьжиргааг авч үзэхийн өмнө орлогын гол эх үүсвэр нь юу болох, түүнийг бүрдүүлэхэд өрхийн ямар гишүүн голлон үүрэг гүйцэтгэдгийг авч үзье. Эцэг/эхчүүдээс өрхийнхөө орлогын гол эх үүсвэрийн талаар өгсөн мэдээллийг Зураг 5.2-т харуулав.

Хотод ажиллаж буй гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн эцэг/эхчүүдийн бараг 2/3 нь өрхийн орлогын гол эх үүсвэрээ цалин гэсэн байхад хөдөөгийн буюу айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн эцэг/эхчүүд орлогын гол эх үүсвэрээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогыг бусдаас илүүтэй (43.5 хувь) нэрлэжээ. Эдгээрийн дараа хотод тэтгэвэр/тэтгэмж (13.6 хувь), мөнгөн тусламж/бэлэг/түрээс/хүүгийн орлого (13.6 хувь) гэж хариулагсад орж байхад хөдөөд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого (24.2 хувь), тэтгэвэр/тэтгэмж (15.3 хувь) гэж хариулагсад орж байна.



Өрхийн орлогын дийлэнхийг хэн бүрдүүлж байгааг авч үзвэл, хотын хариулагчдын 50 хувь, хөдөөгийн хариулагчдын 71.8 хувь тус тус өрхийн тэргүүн гэж хариулсан нь бусдаас өндөр хувь эзэлж байна (Зураг 5.3).

*Соодлаа 5.3 Эцэг/Эхчүүдийн хувийн жин, өрхийн орлогын дийлэнхийг бүрдүүлж буй хүн, байршилаар*




Үүний дараа өрхийн тэргүүний эхнэр/нөхөр гэсэн хариулт (хотод 20.5 хувь, хөдөөд 19.4 хувь) оржээ. Эдгээрээс гадна хотын буюу гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн эцэг/эхчүүдийн 13.6 хувь, айлд мал маллаж буй хүүхдүүдийн эцэг/эхийн 5.6 хувь нь тус бүр гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа болон айлд мал маллаж байгаа хүүхдүүд өрхийн орлогынхоо дийлэнх хэсгийг бүрдүүлдэг гэж хариулжээ. Эндээс харвал, айлд ажиллаж буй хүүхдийн хөдөлмөрийн орлогоор амьжиригаагаа голлон залгуулж буй өрхүүд тодорхой хэмжээгээр байгаа төдийгүй хотод хөдөөгөөс илүүтэй байна.

Айлд ажиллаж буй хүүхдүүдийн өөрийн өрхийн сарын дундаж орлогыг эцэг/эхчүүдийн хэлснээр авч үзвэл 45,250 төгрөг байна. Үүнийг өрхийн нэг хүнд ногдох байдлаар авч үзвэл, хүүхдээ айлд ажиллуулж буй өрхүүд маш доогуур түвшингийн амьжиригаатай болох нь харагдаж байна (YSG-aas 2003-2004 онд хийсэн түүвэр судалгаагаар сард, нэг хүнд ногдохоор тооцсон ядуурлын шугам 24743 төгрөг байна<sup>17)</sup>). Гэвч эцэг/эхчүүдийн хэлсэн зөвхөн дээрх мэдээллээр өрхийн амьжиригааг шууд тодорхойлох нь ихээхэн хангалтгүй бөгөөд практикт ч энэ төрлийн дүгнэлтийг голдуу өрхийн хэрэглээний бүтцэд суурилсан нарийн судалгаагаар гаргадаг. Иймээс ч өрхийн сарын орлогын талаарх мэдээллийг энд товч мэдээлэл төдий болгон оруулав.

Байршилын хувьд, хотын эцэг/эхчүүдийн 52.3 хувь, хөдөөгийн эцэг/эхчүүдийн 54.0 хувь нь сард 40,000 ба түүнээс доош төгрөгийн, бусад нь түүнээс дээш төгрөгийн орлоготой гэж мэдээлжээ (Зураг 5.4).

<sup>17</sup> Үндэсний Статистикийн Газар, Дэлхийн банк, НҮБХХ, "6.5. Ядуурлын шугам", *“6.5. Ядуурлын шугам”*, *“6.5. Ядуурлын шугам”*, 2004: 84

*Соодлаа 5.4 Эцэг/Эхчүүдийн хувийн жин, орхийн сарын дундаж орлого (төгрөг), байршилаар*




Тайлбар: 2004 оны 11-р сарын 20-ны байдлаар 1 америк доллар 1,219 төгрөг байв.

Өрхийн амьжиргааг тодорхойлоход мөнгөн орлогоос гадна үндсэн хөрөнгөтэй эсэхийг авч үзэх нь мөн чухал юм. Ялангуяа хөдөөгийн өрхүүдийн хувьд өрх хувьдаа малтай байх, хичнээн тооны ямар малтай байх зэрэг нь тодорхой санхүүгийн бэрхшээл болон бусад эрсдэлд орох үед нь тэдгээрээс хамгаалах арга болж болох юм. Тухайлбал ямар нэгэн санхүүгийн бэрхшээл тохиолдоход өрх хэрэглээгээ хангах үүднээс малаа зарах, зээл авахад ашиглах гэх мэтээр хөрөнгөө хэрэглэх боломжтой билээ.

Судалгаанд хамрагдсан нийт эцэг/эхчүүдийн 53 хувь нь хувьдаа малтай байсан ба тэд бүгд хөдөөгийн өрхүүд байв. Малтай өрхүүдийн малыг бодод шилжүүлэн<sup>18</sup>, хот, хөдөөгийн нийт өрхүүдийн хувьд дунджаар нэг өрхөд хэдэн мал ногдож байгааг тооцоход 12 бод байв (Зураг 5.5). Харин малтай өрхүүдийн хувьд тооцвол, нэг өрхөд дунджаар 22.7 бод ногдож байгаа юм. Ийнхүү судалгаанд хамрагдсан өрхүүд хэдийгээр мөнгөн орлогын хувьд хангалтгүй ч тодорхой үндсэн хөрөнгөтэй байгаа нь сайшаалтай юм. Дээрх өрхүүдийн малыг төрлөөр нь авч үзвэл ямаа, хонь гэсэн bog малууд тооны хувьд илүү байдаг ажээ.

<sup>18</sup> Малын тоог нэгтгэн тоолоходо bog малыг бодод шилжүүлэх коэффициентийг ашиглав. Эдгээр нь: 1 бод= 1 адuu = 1 үхэр= 0.67 тэмээ = 6 хонь = 8 ямаа



Өрхийн сарын мөнгөн болон мөнгөн бус орлого амьжиргаанд нь хэр хүрэлцдэг эсэхийг хариулагчийн шинж байдлаар Хүснэгт 5.4-т үзүүлэв. Хотод гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа хүүхдүүдийн эцэг/эхчүүдийн 90.9 хувь, хөдөө айлд мал маллаж буй хүүхдүүдийн эцэг/эхчүүдийн 74.2 хувь нь тус тус өрхийн орлого амьжиргаанд нь хүрэлцдэггүй гэсэн ба хангалттай хүрэлцдэг гэсэн хариулагч маш цөөн (2.3 ба 2.4 хувь) байна.

Шилжих хөдөлгөөнд оролцсон хариулагчид бүгд өрхийн орлогоо амьжиргаанд хангалтгүй хүрэлцдэг гэж дүгнэсэн нь ижил хариулт өгсөн шилжих хөдөлгөөнд оролцоогүй хариулагчдынхаас 23 пунктээр өндөр байна.

Орлогын хүрэлцээ өрхийн ам бүлийн тооноос шалтгаалан өрхүүдийн дунд бага зэрэг ялгаатай байна. Ерөнхийдөө орлогоо хангалттай хүрэлцдэггүй гэж үзэж буй хариулагчид хамт амьдарч буй өрхийн гишүүдийнх нь тооноос хамаарахгүйгээр өндөр (70.7-83.5 хувь) байгаа ч хангалттай хүрэлцдэг гэсэн хариулагчид 3-аас олон гишүүнтэй өрхүүдийн дунд байхгүй байна.


Хариулагчийн ажил эрхлэлтийн байдлаар авч үзвэл, орлого нь хүрэлцдэггүй гэсэн хариулагчдын дунд тэтгэвэрт (100 хувь) болон тахир дутуугийн группит байдаг (87.5 хувь), эсвэл ажилгүй (88.9 хувь) хариулагчид бусдаасаа илүүтэй байна. Харин тодорхой байгууллагад буюу хувиараа ажил эрхэлдэг, эсвэл малчин хариулагчдын дунд орлого нь амьжиргаанд боломжийн, хангалттай хүрэлцдэг гэсэн хариулагчдын хувь арай өндөр байна.

Өрхүүдийн сарын орлогын хэмжээ нэмэгдэх тусам орлого нь амьжиргаанд хүрэлцдэггүй гэсэн хариулагчдын хувь багасч байна. Тухайлбал, 20,000 төгрөг ба түүнээс бага орлоготой өрхүүдийн 91.3 хувь нь орлогын хүрэлцээгээ хангалтгүй гэсэн байхад 40,000-60,000 төгрөгийн орлоготой өрхүүдийн 75 хувь, 60,000-аас дээш төгрөгийн орлоготой өрхүүдийн 66 хувь нь дээрх хариултыг өгчээ.

*Очигдэх 5.4 Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүдийн хувийн жин, өрхийн орлого нь амьжиргаанд хүрэлцдэг эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр*

Сонгосон үзүүлэлт	Өрхийн орлого амьжиргаанд хүрэлцдэг эсэх			Бүгд	Тоо
	Хангалттай хүрэлцдэг	Дунд зэрэг хүрэлцдэг	Хүрэлцдэг гүй		
Байришил					
Хот	2.3	6.8	90.9	100.0	44
Хөдөө	2.4	23.4	74.2	100.0	124
Хариулагчийн шилжилтийн байдал					
Шилжигч	0.0	0.0	100.0	100.0	11
Шилжигч бус	2.5	20.4	77.1	100.0	157
Өрхөд амьдарч буй хүний тоо					
1-3	16.0	4.0	80.0	100.0	25
4-5	0.0	29.3	70.7	100.0	58
6 ба түүнээс дээш	0.0	16.5	83.5	100.0	85
Хариулагчийн ажил эрхлэлтийн байдал					
Ажилладаг/Хувиараа ажил эрхэлдэг	2.0	24.5	73.5	100.0	49
Мал малладаг	2.2	21.7	76.1	100.0	46
Тэтгэвэрт	0.0	0.0	100.0	100.0	6
Тахир дутуугийн группт	0.0	12.5	87.5	100.0	8
Гэрийн ажилтай	8.7	21.7	69.6	100.0	23
Ажилгүй	0.0	11.1	88.9	100.0	36
Өрхийн сарын дундаж орлого (төгрөг)					
20000, түүнээс бага	0.0	8.7	91.3	100.0	46
20001-40000	4.5	15.9	79.5	100.0	44
40001-60000	2.5	22.5	75.0	100.0	40
60000-аас дээш	2.6	31.6	65.8	100.0	38
Бүгд	2.4	19.0	78.6	100.0	168

Судалгаанд хамрагдагсдаас айл өрхүүдэд өргөн хэрэглэгддэг зурагт, радио, хөргөгч, машин/мотоцикл, цахилгаан үүсгүүр, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж зэрэг эд зүйлс байдаг эсэхийг лавласан ба тэдгээрийн хэрэглээ нь тухайн өрхийн хүмүүс тав тухтай амьдрах, мэдээлэл хүртэх, амьжиргаагаа дээшилүүлэх боломжоор хэр хангагдсаныг тодорхой хэмжээгээр харуулж болох юм. Нийт хариулагчдын өрхүүдэд зурагт (50.6 хувь), радио (38.1 хувь), цахилгаан үүсгүүр (22 хувь) зэрэг нь бусад эд зүйлээс илүүтэй хэрэглэгддэг байна (Зураг 5.6).



#### 5.4 Нийгмийн үйлчилгээ хүртэх боломж

Судалгаанд хамрагдагчдын өрхийн гишүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ болон зарим сонгосон нийгмийн үйлчилгээнүүд хэр хүртээмжтэй байдгийг тодруулах үүднээс бид судалгаандаа зарим асуултуудыг оруулсан юм.

Нийт хариулагчдын дийлэнх буюу 76.2 хувь нь гэр бүлийнхэн нь өвдсөн үед харьяаллын өрхийн эмнэлэгт, 8.9 хувь нь эрүүл мэндийн төвд, 3 хувь нь эмийн санд ханддаг гэжээ. Эдгэрээс гадна эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй гэсэн хариултыг 3 хувь нь өгсөн ба дээрх төрлийн үйлчилгээнд хамрагдах боломжтой ч тэдэнд хандахгүйгээр өөрсдөө өвчинөө аргалдаг гэсэн хариулагчид (8.9 хувь) ч байлаа. Эдгэр нь хот, хөдөө, шилжилтийн байдал гэх мэт хариулагчийн шинж байдлаар онцын ялгаагүй байв.

Айлд хүүхдээ ажиллуулж буй өрхүүд нийгмийн зарим чухал шаардлагатай үйлчилгээгээр дамжуулан амьжиргаагаа дээшилүүлэх боломж хэр байгааг Хүснэгт 5.5-д үзүүлэв.

*Одийд 5.5 Нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжтой гэж хариулсан хариулагчдын хувь, сонгосон үзүүлэлтүүдээр*


Сонгосон үзүүлэлтүүд	Нийгмийн үйлчилгээ				Тоо
	Жижиг зээлийн үйлчилгээ	Хадгаламжийн үйлчилгээ	Ажлын байрны төсөл, хөтөлбөр	Газар тариалан, МАА-н төсөл	
Байршил					
Хот	43.2	15.9	36.4	27.3	44
Хөдөө	25.8	10.5	24.2	30.6	124
Бүгд	30.4	11.9	27.4	29.8	168

Зээл, хадгаламж болон олон нийтэд чухал эрэлт, хэрэгцээтэй байдаг зарим хөтөлбөр, төслүүдэд хамрагдах боломж хүүхэд нь айлд ажиллаж байгаа өрхүүдэд харьцангуй хязгаарлагдмал байдгийг судалгаанд хамрагдагчид илэрхийлжээ. Тухайлбал, өрх нь дээрх үйлчилгээнүүдэд хамрагдах боломжтой гэж хариулсан эцэг/эх нийт хариулагчдын 1/3-д ч хүрэхгүй байна. Ялангуяа хөдөөгийн хариулагчдын хувьд хотынхонтой харьцуулахад жижиг зээл, хадгаламж, ажлын байрны төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах боломж харьцангуй бага байдаг ажээ. Харин хөдөөд газар тариалан, мал аж ахуйн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдан амьжиргаагаа сайжруулах боломж (30.6 хувь) хотынхноос (27.3 хувь) бага зэрэг илүү байж болох нь эцэг/эхчүүдийн хариултаас харагдаж байна.

## 5.5 Хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийн талаарх эцэг/эхийн бодол

Энэхүү хэсэг нь айлд ажиллаж буй хүүхдийн ажлын орчин, нөхцөл, хөдөлмөрийн үнэлгээний талаарх эцэг/эхийн ойлголт, хандлага, үзэл бодлыг авч үзэх болно.

Гэрийн үйлчлэгчээр ажиллаж байгаа болон айлд мал маллаж байгаа хүүхдүүдийн зарим нь хөдөлмөр эрхлэх хугацаандаа эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй хандлага хот, хөдөөгүй байдаг нь манай судалгааны бүх асуултуудаар харагдсан юм. Хотын эцэг/эхчүүдийн 18.2 хувь, хөдөөгийн эцэг/эхчүүдийн 15.3 хувь нь айлд ажиллаж буй хүүхдээ гэрээсээ өөр газарт амьдардаг гэж мэдээлжээ. Эцэг/эхтэйгээ хамт амьдрахгүй байгаа эдгээр хүүхдүүд (27 хүүхэд) ажиллах үедээ бүгд ажил олгогч өрхийндөө амьдардаг бөгөөд ажил олгогч нь хэн болохыг Зураг 5.7-оос харж болно.



Ажиллах үедээ гэрээсээ өөр айлд амьдардаг хүүхдүүд ямар хугацаанд гэртээ ирдгийг сонирхвол эцэг/эхчүүдийн 37 хувь нь хүүхдүүдээ 7 хоног буюу түүнээс ойр хугацаанд, 22.2 хувь нь 14 хоногт нэг удаа, 22.2 хувь нь сардаа нэг удаа, үлдсэн 18.6 хувь нь сараас дээш хугацааны дараа гэртээ ирдэг гэжээ.

Айлд ажиллаж буй хүүхдийнхээ ажлын орчин, нөхцлийг эцэг/эхчүүд хэрхэн үнэлдэгийг Хүснэгт 5.6-д харуулав. Хүүхдэд өдрийн ажлын үеэр түр амарч, алжаалаа

тайлах боломж гардаг эсэх талаарх эцэг/эхчүүдийн ойлголтыг авч үзвэл хотод, гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй хүүхдүүдийн эцэг/эхчүүдийн 27.3 хувь нь л хүүхдүүдээ дээрх боломж хангалттай гардаг гэсэн ба 11.3 хувь нь энэ талаар ямар ч мэдээлэлгүй буюу анхаарал тавиагүй байв. Харин хөдөөд айлын мал маллаж буй хүүхдүүдийн эцэг/эхчүүдийн 34.7 хувь нь энэ асуудалд хангалттай гэсэн үнэлгээг өгсөн ба 7.3 хувь нь мэдэхгүй, бусад нь дээрх боломж байхгүй буюу бага зэрэг байдалгээ.

*Өглийн 5.6 Эцэг/эхчүүдийн хувийн жин, хүүхдийн ажлын орчин, нөхцлийг үнэлж буй байдал, байршилаар*

Хүүхдийн ажлын орчин, нөхцлийн талаарх эцэг/эхийн үнэлгээ	Байршил		Бүгд
	Хот	Хөдөө	
<b>Өдрийн ажлын үеэр түр амрах, алжаалаа тайлах боломж гардаг эсэх</b>			
Байдаггүй	15.9	16.1	16.1
Дунд зэрэг	45.5	41.9	42.9
Хангалттай	27.3	34.7	32.7
Мэдэхгүй	11.3	7.3	8.3
<b>Өдрийн ажлын үеэр цангаагаа тайлах боломж байдалгээ</b>			
Байдаг	72.7	91.1	86.3
Байдаггүй	22.8	5.7	10.1
Мэдэхгүй	4.5	3.2	3.6
<b>Өдрийн ажлын үеэр хооллох боломж байдалгээ</b>			
Байдаг	72.7	91.9	86.9
Байдаггүй	22.8	5.7	10.1
Мэдэхгүй	4.5	2.4	3.0
<b>Хүүхдийн ажлын нөхцөл</b>			
Муу	22.7	12.9	15.5
Дунд	52.3	44.4	46.4
Сайн	22.7	40.3	35.7
Мэдэхгүй	2.3	2.4	2.4
<b>Хоногийн ажлын цаг</b>			
1-5 цаг	47.7	18.5	26.2
6-8 цаг	25.0	34.7	32.1
9, түүнээс дээш	15.9	42.0	35.2
Мэдэхгүй	11.4	4.8	6.5
<b>Өдрийн ажлын ачаалал</b>			
Хэт их	22.7	32.3	29.8
Дунд зэрэг	61.4	49.2	52.4
Бага	13.6	15.3	14.9
Мэдэхгүй	2.3	3.2	3.0
<b>Ажил хийхэд хүүхэд ядардаг эсэх</b>			
Их ядардаг	25.0	32.3	30.4
Дунд зэрэг	27.3	30.6	29.8
Нэг их ядардаггүй	38.6	29.8	32.1
Мэдэхгүй/Анзаардаггүй	9.1	7.3	7.7
<b>Ажил олгогчийн хүүхэдтэй харьцах харьцаа</b>			
Таагүй	6.8	0.8	2.4
Дунд зэрэг	38.6	16.2	22.0
Сайн	52.3	80.6	73.2
Мэдэхгүй	2.3	2.4	2.4
<b>Бүгд</b>	100.0	100.0	100.0
<b>Тоо</b>	44	124	168

Өдрийн ажлын үеэр хүүхдэд нь цангаагаа тайлах, хооллох боломж байдаггүй гэж үзэж байгаа хотын эцэг/эхчүүд (22.8 хувь) хөдөөгийнхөөс 4 дахин олон байна. Түүнчлэн хотын эцэг/эхчүүдийн 22.7 хувь нь хүүхдийн ажлын нөхцлийг муу гэж үзэж байхад хөдөөгийнхөн илүү хүнд нөхцөлд хүүхдээ ажиллуулдаг боловч ажлын нөхцлийг нь муу гэж үзэж байгаа хувь хотынхос бараг 2 дахин бага, харин сайн гэж үнэлсэн байдал (40.3 хувь) нь бараг 2 дахин өндөр гарчээ.

Хүүхдийн хоногийн ажлын цагийг үзвэл, хотын эцэг/эхчүүдийн дунд хүүхдээ хоногт 1-5 цаг л ажилладаг гэж үзэж буй хариулагчид хамгийн өндөр хувийг (47.7 хувь) үзэж байна. Тэгвэл хөдөөгийн эцэг/эхчүүдийн дунд 9 буюу түүнээс олон цаг ажилладаг гэж үзэж буй хүмүүс бусдаас өндөр хувь (42 хувь) үзэлж байгаа юм. Эндээс, гэрийн үйлчлэгчийн ажил болон айлын мал маллах ажиллуудад оролцож буй хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийг эцэг/эхчүүд нэлээд ялгаатайгаар хүлээн авч байгаа нь харагдаж байна.

Өдрийн ажлын ачааллыг хэрхэн үнэлж байгааг нь харвал, хотын эцэг/эхчүүдийн бараг 2/3 нь дунд зэрэг гэж үнэлжээ. Харин хөдөөгийн эцэг/эхчүүдийн 1/3 нь хүүхдийнхээ өдрийн ажлын ачааллыг хэт их, тал хувь нь дунд зэрэг, үлдсэн нь бага буюу мэдэхгүй гэж үнэлжээ. Түүнчлэн хотын эцэг/эхчүүдийн дунд айлд ажил хийснээр хүүхэд нэг их ядардаггүй гэсэн ойлголт (38.6 хувь) бусдаас илүүтэй байхад хөдөөгийнхний дунд маш их ядардаг гэсэн ойлголт хамгийн өндөр хувь (32.3 хувь) үзэлж байна. Сүүлийн эдгээр дүгнэлтүүд нь магадгүй хоногийн ажлын цагийг эцэг/эхчүүд хэрхэн үнэлсэнтэй шууд холбоотой тайлбарлагдаж болох юм.

Эцэст нь, айлд ажиллаж байгаа хүүхэдтэй нь ажил олгогч ямархуу харьцаатай байдаг талаарх эцэг/эхчүүдийн үнэлгээг сонирхвол, хотын хариулагчдын 52.3 хувь, хөдөөгийн хариулагчдын 80.6 хувь нь тус тус сайн гэж үнэлжээ. Дээрх харьцааг дунд болон таагүй гэж үнэлж буй эцэг/эхчүүд хотод хөдөөнөөс илүүтэй байна.

Хүүхдийн айлд ажиллан авч буй мөнгөн болон мөнгөн бус хөлсийг эцэг/эхчүүд хэрхэн үнэлж байгааг Хүснэгт 5.7-аас харна уу.

Нийт эцэг/эхчүүдийн 25 хувь нь хүүхдийн ажлын хөлсийг бага, 53.6 хувь нь дунд, үлдсэн 21.4 хувь нь өндөр гэж үнэлжээ. Эцэг/эхчүүдийн энэхүү үнэлгээ нь хариулагчийн нас болон өрхийн сарын орлогын түвшингээс төдийлөн хамаарахгүй байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Хүйсээр үзвэл, ажлын хөлсийг нь бага гэж үнэлж буй эрэгтэйчүүдийн хувь (30.7 хувь) эмэгтэйчүүдийнхээс 2.4 дахин өндөр, харин хөлсийг нь өндөр гэж үнэлж буй эмэгтэйчүүдийн хувь (22.8 хувь) эрэгтэйчүүдээс 4.3 пунктээр өндөр байна.

*Одийн 5.7 Эцэг/эхчүүдийн хувийн жин, хүүхдийн ажлын хөлсийг үнэлж байгаа байдал, сонгосон үзүүлэлтүүдээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Хүүхдийн ажлын хөлсийг үнэлсэн байдал			Бүгд	Тоо
	Бага	Дунд	Өндөр		
Хариулагчийн хүйс					
Эрэгтэй	13.0	68.5	18.5	100.0	54
Эмэгтэй	30.7	46.5	22.8	100.0	114
Хариулагчийн нас					
35 хүртэл	30.8	46.1	23.1	100.0	26
35-44	26.0	46.9	27.1	100.0	96
45, түүнээс дээш	19.6	71.7	8.7	100.0	46
Хариулагчийн боловсрол					
Боловсролгүй/Бага	25.5	59.6	14.9	100.0	47
Бүрэн бус дунд	20.6	55.6	23.8	100.0	63
Бүрэн дунд, түүнээс дээш	29.3	46.6	24.1	100.0	58
Өрхийн сарын дундаж орлого					
20000, түүнээс бага	32.6	47.8	19.6	100.0	46
20001-40000	15.9	61.4	22.7	100.0	44
40001-60000	30.0	47.5	22.5	100.0	40
60000-аас дээш	21.1	57.8	21.1	100.0	38
<b>Бүгд</b>	<b>25.0</b>	<b>53.6</b>	<b>21.4</b>	<b>100.0</b>	<b>168</b>

Хүүхдийн ажлын хөлсийг өндөр гэж үнэлсэн байдлыг эцэг/эхчүүдийн боловсролоор авч үзвэл, боловсролын түвшин нь нэмэгдэх тусам энэ хувь нэмэгджээ. Тухайлбал, боловсролгүй/бага боловсролтой хариулагчдын 14.9 хувь нь л хүүхдийнхээ ажлын хөлсийг өндөр гэж үнэлсэн байхад бүрэн бус дунд боловсролтой хариулагчдын 23.8 хувь, бүрэн дунд ба түүнээс дээш түвшингийн боловсролтой хариулагчдын 24.1 хувь нь ингэж хариулсан байна.

Ажил хийснээр хүүхдийн эрүүл мэндэд тулгарч болох эрсдэлийг эцэг/эхчүүд хэрхэн үнэлж байгааг Хүснэгт 5.8-д хариулагчийн шинж байдлаар үзүүлэв.

*Одийн 5.8 Эцэг/эхчүүдийн хувийн жин, ажил хийснээр хүүхдийн эрүүл мэндэд тулгарч болох эрсдэлийг үнэлсэн байдал, сонгосон үзүүлэлтүүдээр*

Сонгосон үзүүлэлтүүд	Хүүхдийн эрүүл мэндэд тохиолдож болох эрсдэлийн талаарх үнэлгээ			Бүгд	Тоо
	Бага	Дунд	Өндөр		
Хариулагчийн хүйс					
Эрэгтэй	50.0	35.2	14.8	100.0	54
Эмэгтэй	40.4	35.1	24.6	100.0	114
Хариулагчийн нас					
35 хүртэл	34.6	34.6	30.8	100.0	26
35-44	42.7	36.5	20.8	100.0	96
45, түүнээс дээш	50.0	32.6	17.4	100.0	46
<b>Бүгд</b>	<b>43.5</b>	<b>35.1</b>	<b>21.4</b>	<b>100.0</b>	<b>168</b>

Хүүхэд ажил хийснээр эрүүл мэндэд нь тулгарч болох эрсдэлийг эмэгтэй, 35 хүртэлх наасны эцэг/эхчүүд илүү өндөр гэж үнэлж байна. Тухайлбал, дээрх эрсдэлийг бага гэж

үзэж буй эрэгтэйчүүдийн хувь (50 хувь) эмэгтэйчүүдийнхээс 10 пунктээр илүү байхад, эрсдэлийг өндөр гэж үнэлж буй эмэгтэйчүүдийн хувь (24.6 хувь) эрэгтэйчүүдийнхээс 10 пунктээр өндөр байна.

Ерөнхийдөө нийт эцэг/эхчүүдийн дунд ажил хийснээр хүүхдэд тохиолдож болох эрүүл мэндийн эрсдэлийг бага гэж үнэлж буй хүмүүс (43.5 хувь) бусдаас өндөр хувь эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

## 5.6 Хүүхдийн ирээдүйн талаарх эцэг/эхийн үзэл бодол

Судалгаанд хамрагдсан эцэг/эхчүүд айлд ажиллаж байгаа хүүхдийнхээ ажлыг хүлээн зөвшөөрч байгаа эсэх нь тухайн хүүхэд цаашид уг ажлаас хөндийрөх эсэхэд тодорхой хэмжээгээр нөлөөтэй нь мэдээж. Энэ талаар эцэг/эхчүүд ямар хандлагатай байгааг Хүснэгт 5.9-т харуулав.

Нийт эцэг/эхчүүдийн 84.5 хувь хүүхэд нь одоогийн ажлыг хийж байгааг хүлээн зөвшөөрч байна. Энэ хандлага хөдөөд буюу айлд мал маллаж буй хүүхдүүдийн эцэг/эхчүүд (86.3 хувь)-ийн дунд гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн эцэг/эхчүүд (79.5 хувь)-ийнхээс өндөр байна. Мөн эрэгтэй, ахимаг насны, боловсролын түвшин багатай хариулагчдын хувьд ч өндөр гарчээ.

*Огийн 5.9 Эцэг/эхчүүдийн хувийн жин, айлд хүүхдээ ажиллуулахыг хүлээн зөвшөөрч буй эсэх, сонгосон үзүүлэлтүүдээр*


Сонгосон үзүүлэлтүүд	Хүүхэд нь айлд ажиллаж байгааг хүлээн зөвшөөрч байгаа эсэх		Бүгд	Тоо
	Тийм	Үгүй		
Байршил				
Хот	79.5	20.5	100.0	44
Хөдөө	86.3	13.7	100.0	124
Хариулагчийн хүйс				
Эрэгтэй	90.7	9.3	100.0	54
Эмэгтэй	81.6	18.4	100.0	114
Хариулагчийн нас				
35 хүртэл	73.1	26.9	100.0	26
35-44	85.4	14.6	100.0	96
45, түүнээс дээш	89.1	10.9	100.0	46
Хариулагчийн боловсрол				
Боловсролгүй/Бага	91.5	8.5	100.0	47
Бүрэн бус дунд	84.1	15.9	100.0	63
Бүрэн дунд, түүнээс дээш	79.3	20.7	100.0	58
Бүгд	84.5	15.5	100.0	168

Эцэг/эхчүүдийн хүүхдээ айлд ажиллахыг хүлээн зөвшөөрч байгаа болон зөвшөөрөхгүй байгаа шалтгаануудыг Зураг 5.8а, Зураг 5.8б-д хот, хөдөөгөөр харьцуулан харуулав.

Хүүхдээ ажиллахыг хүлээн зөвшөөрч буй шалтгаанууд дотор өрхийн амьжиргаанд тус нэмэртэй (хотод 82.9 хувь, хөдөөд 76.6 хувь), хүүхэд өөрөө ажлын дөр сууж, бис

даан амьдарч сурна (хотод 42.9 хувь, хөдөөд 66.4 хувь), хүүхэд өөрийн хоол, боловсролын хэрэгцээний зардлаа олдог гэсэн шалтгаанууд бусдаас өндөр хувь эзэлж байна. Харин хүлээн зөвшөөрдөггүй шалтгаанууд дотор хүүхэд зөвхөн сурх ёстой (хотод 44.4 хувь, хөдөөд 70.6 хувь), ажил хийх нь хүүхдийн эрүүл мэнд, сурлагад муу нөлөөтэй (хотод 66.7 хувь, хөдөөд 58.8 хувь) гэсэн шалтгаанууд голлож байна. Түүнчлэн ажлын нөхцөл хүнд учраас хүүхдээ ажиллахыг нь зөвшөөрдөггүй гэсэн шалтгааныг хөдөөгийн эцэг/эхчүүдийн бараг тал хувь хэлсэн байна. Дээрх бүгдээс дүгнэхэд насанд хүрэгчид хүүхдийн хөдөлмөрийн нөхцлийг болон үр дагаврыг сайн ойлгож мэдэж байгаа нь харагдаж байна.

Ийм үед хүүхдийн ажил эрхлэлтийг болиулахын тулд эцэг/эхчүүдэд чухам ямар нөхцөл бүрдүүлэх хэрэгцээтэй байна вэ гэдгийг мэдэх нь чухал юм. Энэ талаар хариулагчдын өгсөн мэдээллийг Хүснэгт 5.10-д харуулав.



Тэмдэглэл: Хариулт олон сонголттой тул хувийн жингийн нийлбэр 100-аас илүү.

Хүүхдийн ажил эрхлэлтийг зогсоохын тулд эцэг/эхчүүдийн бүрдүүлэхийг хүсч буй нөхцлийдэд өрхийн орлого хангалттай болох, хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд зарцуулах мөнгө хангалттай болох, хүүхэд өөрөө бие дааж амьдрах чадвартай болох, амьдарч буй газар нь сургуульд ойрхон болох зэрэг олон нөхцлийд багтаж байна. Эдгээрээс эцэг/эхчүүдийн хамгийн их нэрлэсэн нь эдийн засгийн шалтгаан буюу өрх хангалттай орлоготой болох явдал (48.2 хувь) ажээ. Үүний дараа хүүхэд хэрвээ өөрөө хүсвэл ажиллахыг нь зогсоно гэсэн хариулт (28 хувь) орж байна. Гэхдээ энд гарсан нэг сонирхол татах үр дүн бол хүүхдээ ажиллахыг болиулах шаардлагагүй гэж

үзэж буй эцэг/эхчүүд нийт хариулагчдын 6 хувийг эзэлж байгаа явдал юм. Эдгээрийг байршилаар авч үзвэл, срөнхий хандлага адилхан ч гэсэн хотын хариулагчдын дунд хүүхдээ ажиллахыг болиулах шаардлагагүй гэсэн хариулагчид байхгүй байна.

#### *Одийн 5.10 Эцэг/эхчүүдийн хувийн жин, айлд хүүхдээ ажиллуулахаа болих нөхцөл, сонгосон үзүүлэлтүүдээр*

Сонгосон үзүүлэлт	Хүүхдээ айлд ажиллуулахаа болих нөхцөл						Bүгд	Toо
	Гэр бүл хангалттай орлого/майл/газартай болох	Хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд мөнгө хангалттай болох	Хүүхэд өөрөө хүсвэл	Хүүхэд бие дааж амьдралтай чадвартай болох	Сургууль гэр/ ажилтай ойрхон болох	Болиулах шаардлагагүй/ Ажил олгогч ажиллуулахаа болих		
Байршил								
Хот	61.4	2.2	36.4	0.0	0.0	0.0	100.0	44
Хөдөө	43.5	9.7	25.0	9.7	4.0	8.1	100.0	124
Өрхөд амьдарч буй хүний тоо								
1-3	40.0	16.0	24.0	4.0	4.0	12.0	100.0	25
4-5	51.7	5.2	27.6	8.6	0.0	6.9	100.0	58
6 ба түүнээс дээш	48.2	7.1	29.4	7.1	4.7	3.5	100.0	85
Орлогын гол эх үүсвэр								
Цалин	55.6	2.2	33.3	6.7	0.0	2.2	100.0	45
Тэтгэвэр/Тэтгэмж /Мөнгөн тусламж /Түрээс/Бэлэг/Хүү	67.6	6.0	20.6	0.0	2.9	2.9	100.0	34
Өрхийн үйлдвэрлэл/үйлчилгээ	38.2	2.9	35.3	11.8	2.9	8.8	100.0	34
ХАА-н үйлдвэрлэл	36.4	16.4	23.6	9.1	5.5	9.1	100.0	55
Бүгд	48.2	7.7	28.0	7.1	3.0	6.0	100.0	168


Өрхийн ам бүлийн тоо олон болох тусам хариулагчдын нэрлэж буй нөхцлүүд дотор эдийн засгийн чанартай нөхцлийг нэрлэх явдал багасах хандлагатай байна. Тухайлбал, 1-3 гишүүнтэй өрхүүдийн 16 хувь нь хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд мөнгө хангалттай болвол хүүхдээ ажиллуулахаа болыно гэсэн байхад 4-5 гишүүнтэй өрхүүдийн 5.2 хувь, 6 ба түүнээс олон гишүүнтэй өрхүүдийн 7.1 хувь нь тус тус ийм хариултыг өгчээ.

Өрхийн орлогын гол эх үүсвэртэй холбон харвал, цалин, тэтгэвэр тэтгэмж гэх мэт тогтмол хэмжээтэй, бага орлогоор голлон өрхийн орлогоо бүрдүүлдэг өрхүүд бусад өрхүүдээсээ илүүтэйгээр гэр бүл хангалттай орлого/майл/газартай болох, хүүхдийн эрүүл мэнд, боловсролд мөнгө хангалттай болох гэх мэт эдийн засгийн нөхцлүүдийг дурьдсан байна. Эндээс, тэдгээр өрхийн нийт орлогод хүүхдийн хөдөлмөрийн орлого барагүй үүрэг гүйцэтгэдэг байж болох юм гэсэн таамаглал хийж болохоор байна.

Дээрх байдлаар эцэг/эхчүүд хүүхдийн ажлыг болиулахад тодорхой нөхцлүүд нэрлэн хэлж байгаа ч гэсэн хүүхдэд сургуульд орох, эсвэл үргэлжлүүлэн суралцах нөхцөл бүрдвэл ажил эрхлэлтийг нь зогсоох эсэхийг бид судалгаагаараа давхар асуусан юм. Үүний үр дүнг сонгосон үзүүлэлтүүдээр Зураг 5.9-д харуулав.


Хүүхэд сургуульд орох, эсвэл үргэлжлүүлэн суралцах нөхцөлд ажил эрхлэлтийг нь зогсоондо гэж хариулсан эцэг/эхчүүд нийт хариулагчдын 82.1 хувийг эзэлж байлаа.

Шинж байдлын хувьд, ийм хариулт өгсөн хөдөөгийн эцэг/эхчүүдийн хувь (84.7 хувь) хотынхоос 9.7 пунктээр, эмэгтэйчүүдийн хувь (84.2 хувь) эрэгтэйчүүдээс 6.4 пунктээр, 35-аас доош насныханы хувь (88.5 хувь) 45-аас дээш насныханаас 12.4 пунктээр, бүрэн дунд ба түүнээс дээш түвшингийн боловсролтой хүмүүсийн хувь (89.7 хувь) боловсролгүй буюу бага түвшингийн боловсролтой хүмүүсээс 11 пунктээр тус тус өндөр байна.



Эцэг/эхчүүдийн айлд ажиллаж байгаа хүүхэддээ ямар боловсрол эзэмшиглэхийг хүсч байгааг сонирхвол (Зураг 5.10), хот, хөдөөгөөс судалгаанд хамрагдагчдын хувьд ялгаагүй, өндөр боловсрол эзэмшиглэхийг хүсч байгаа нь харагдлаа. Тэр дундаа тал хувь нь дээд боловсролтой болгохыг хүсч байгаа ажээ.

*Соодлал 5.10 Эцэг/эхчүүдийн хувь, ажиллаж буй хүүхдэд эзэмшигүүлэхийг хүсч буй боловсролын түвшин, байрилаар*



Дээрх графикаас, хотын эцэг/эхчүүдийн 2.3 хувь, хөдөөгийн эцэг/эхчүүдийн 6.5 хувь буюу нийтдээ 9 эцэг/эх хүүхдэд боловсрол шаардлагагүй гэж үзсэн нь харагдаж байна. Тэднээс албан боловсролын бус, ямар төрлийн сургалт, дамжаанд хүүхдээ хамруулах сонирхолтойг асуухад 4 хариулагч нь ямар ч сургалт, дамжаанд ч хамруулах шаардлагагүй, 3 нь мэдэхгүй, 2 нь жолооны курс гэж саналаа илэрхийлсэн байна.

## **БҮЛЭГ 6. ГЭРИЙН ҮЙЛЧЛЭГЧ/АЙЛД МАЛ МАЛЛАЖ БУЙ ХҮҮХДҮҮДЭД АЖИЛ ОЛГОГЧИД**

Энэхүү бүлгээр судалгаанд хамрагдсан гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж буй хүүхдүүдэд ажил олгогчид, тэдний өрхийн гишүүдийн шинж байдлын талаар танилцуулах болно. Түүнчлэн ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөрийн талаарх үзэл бодол, үнэлэмжийг тодорхойлохыг зорилоо.


### **6.1 Судалгаанд хамрагдсан ажил олгогчид, тэдний өрхийн гишүүдийн шинж байдал**

#### **6.1.1 Ажил олгогчидын өрхийн гишүүдийн шинж байдал**

Судалгаанд нийт 166 гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж буй хүүхдүүдэд ажил олгогч хамрагдсан. Эдгээр ажил олгогчдын өрхийн гишүүд 685 байгаа бөгөөд, тэдний 32.8 хувь нь Улаанбаатар хотод (цаашид 67.0 гэнэ), 67.2 хувь нь хөдөө оршин сууж байна. (Өвөрхангай аймагт 21.2 хувь, Ховд аймагт 26 хувь, Хөвсгөл аймагт 20 хувь)

Судалгаанд хамрагдсан нийт 166 ажил олгогч өрхийн 91-д нь гэрийн үйлчлэгч/айлд мал маллаж буй хүүхэд амьдарч байна.

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын өрхийн гишүүдийн нас, хүйсийн бутцийг байршилаар нь Зураг 6.1-д харуулав.



Судалгаанд хамрагдсан ажил олгогчийн өрхийн гишүүдийн 27.7 хувийт 15-аас доош насны хүүхдүүд, 62.4 хувийг 15-64 насны хүн ам, 9.9 хувийг 65 ба түүнээс дээш насны ахмадууд эзэлж байна. 1980-аад оноос төрөлтийн түвшин буурч эхэлсэнтэй холбоотойгоор суварга суурь хэсгээрээ нарийссан байна. 21-24 насны бүлгээс эхлэн нас ахихын хэрээр хүн амын тоо буурсан боловч 55 наснаас эхлэн бага зэрэг өссөн дүр зураг ажиглагдаж байна. Эдгээр ахмадуудын хувьд хүүхдүүд нь өрх тусгаарласан байдагтай холбоотойгоор өдөр тутмын ажил/амьдралдаа өөр айлын хүүхэд туслацуулах явдал элбэг байдаг учраас судалгаанд илүүтэй хамрагдсан байна (Бүлэг 6.1.2-ийг харна уу).

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын өрхийн гишүүдийн хүйсийн харьцаа ерөнхийдөө ойролцоо хандлага ажиглагдажээ. Тэдний 51.4 хувийг эрэгтэй, 48.6 хувийг эмэгтэй хүн ам эзэлж байгаа бөгөөд, хүйсийн харьцаа хамгийн зөрүүтэй нас нь хот, хөдөөд адилахан 55-59 байна. Харин 0-4 болон 60-64 насныхны хувьд хүйсийн харьцаа төдийлөн зөрүүтэй бус байлаа.

*Одийн 6.1. Ажил олгогчийн өрхийн гишүүдийн хувийн жин, байршил, боловсрол, ажил эрхлэлтийн байдлаар*

Боловсрол, ажил эрхлэлтийн байдал	Байршил		Бүгд
	Хот	Хөдөө	
<b>Боловролын түвшин</b>			
Огт боловсролгүй	18.3	24.1	22.1
Бага	21.2	29.7	26.8
Бүрэн бус дунд	22.1	24.8	23.9
Бүрэн дунд	19.7	9.6	13.1
Тусгай мэргэжлийн дунд/ББД	7.2	7.9	7.6
Дээд	11.5	3.9	6.5
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>7 ба түүнээс дээш настай хүн амын тоо</b>	<b>407</b>	<b>208</b>	<b>615</b>
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>			
Ажилладаг/Хувиараа ажил			
Эрхэлдэг	24.6	8.9	14.2
Мал малладаг	0.5	35.4	23.7
Цэцэрлэг/Сургуульд сурдаг	19.0	17.7	18.1
Тэтгэвэрт	22.3	11.0	14.8
Тахир дутуугийн группт	4.3	0.5	1.7
Гэрийн ажилтай	1.4	7.2	5.2
Гэрийн үйлчлэгч	19.4	13.8	15.7
Ажилгүй	7.6	1.4	3.5
Гэртээ	0.9	4.1	3.1
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>6 ба түүнээс дээш настай хүн амын тоо</b>	<b>418</b>	<b>211</b>	<b>629</b>

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын өрхийн гишүүдийн боловсролын түвшинд байршилаар тодорхой ялгаа ажиглагдаж байгаа нь Хүснэгт 6.1-ээс харагдаж байна. Тухайлбал, хөдөөгөөс судалгаанд хамрагдсан ажил олгогчдын өрхийн гишүүдийн 3.9

хувь нь дээд боловсролтой байхад энэ хувь хотод 11.5 байна. Хотоос судалгаанд хамрагдсан ажил олгогчдын өрхийн гишүүдийн тухайд боловсролгүй хүн амын эзлэх хувь хөдөөтэй харьцуулахад бага байна. Харин бүрэн бус дунд, тусгай мэргэжлийн дунд/ББД боловсролтой хүн амын хувьд байршилын ялгаа хамгийн бага байлаа.

Судалгаанд хамрагдсан хөдөөгийн 10 хүн тутмын 3-4 нь мал маллаж байна. Харин хотод ямар нэгэн ажил эрхэлж байгаа ажил олгогчдын өрхийн гишүүдийн хувь ажил эрхлэлтийн бусад ангилалд багтаж байгаа хүн амын хувиас өндөр (24.3 хувь) байна.

### **6.1.2 Ажил олгогчдын хувь**

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хүн ам зүйн шинж байдлыг Хүснэгт 6.2-т харууллаа.

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын голч нас 56.4 байгаагаас өндөр настай хүмүүсийн дунд гэрийн болон мал маллах ажилдаа өөр айлын хүүхэд туслалцуулах явдал түгээмэл байдаг болохыг харж болно. Голч нас нь байршилаар төдийлөн ялгаагүй байлаа (хотод 56.5, хөдөөд 56.3). Хүснэгт 6.2-оос харахад, хөдөөгөөс судалгаанд хамрагдсан ажил олгогчдын насын бүтцэд онцын ялгаа ажиглагдсангүй. Харин хотоос судалгаанд хамрагдсан 45-54 насын ажил олгогчид хамгийн бага хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан 10 ажил олгогч тутмын 6-7 нь эмэгтэй байсан бөгөөд энэ хандлага хот, хөдөөд ойролцоо байна. Хотын нийт ажил олгогчдын 66 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь хөдөөгөөс 8.2 пунктээр өндөр үзүүлэлт юм.

Ажил олгогчдын боловсролын түвшинд байршилаар мэдэгдэхүйц ялгаа ажиглагдажээ. Хөдөөгийн ажил олгогчдын бараг хагас нь (45.7 хувь) огт боловсрол эзэмшээгүй болон бага боловсролтой хүмүүс байхад, хотын ажил олгогчдын срдөө 10 хувь нь боловсрол эзэмшээгүй буюу бага боловсролтой хүмүүс байна.


Ажил олгогчдыг ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд, хөдөөгөөс судалгаанд хамрагдагсадын талаас ялимгүй илүү хувь мал маллаж байгаа бөгөөд хөдөөд “ажилгүйчүүд” гэсэн ангилалд багтаж байгаа ажил олгогч байхгүй байна. Харин хотын нийт ажил олгогчдын 10 хувь нь ажилгүйчүүд, бараг тал хувь нь тэтгэвэрт байгаа хүмүүс байна.

Нийт ажил олгогчдын 72.9 хувь нь өрхдөө өөр айлын нэг хүүхдийг ажиллуулж байгаа нь 2 хүүхэд ажиллуулж буй ажил олгогчдоос 3.5, 3 ба түүнээс олон тооны хүүхэд ажиллуулж буй ажил олгогчдоос 12.2 дахин өндөр үзүүлэлт юм.

*Өглийн 6.2. Ажил олгогчийн хувийн жин, байршил, хүн ам зүйн шинж байдлын сонгосон үзүүлэлтээр*


Хүн ам зүйн шинж байдлын сонгосон үзүүлэлтүүд	Хот	Байршил Хөдөө	Бүгд
<b>Нас</b>			
34-өөс дооп	26.0	20.7	22.3
35-44	14.0	18.1	16.8
45-54	8.0	18.1	15.1
55-64	24.0	19.8	21.1
65 ба түүнээс дээш	28.0	23.3	24.7
<b>Хүйс</b>			
Эрэгтэй	34.0	42.2	39.8
Эмэгтэй	66.0	57.8	60.2
<b>Гэрэлтийн байдал</b>			
Огт гэрлээгүй	8.0	1.7	3.6
Гэрлэсэн/Хамт амьдардаг	74.0	69.0	70.5
Салсан/Бэлэвсэн/Тусгаарласан	18.0	29.3	25.9
<b>Яс үндэс</b>			
Халх	88.0	64.7	71.7
Бусад	12.0	35.3	28.3
<b>Боловсролын түвшин</b>			
Огтболовсролгүй/Бага боловсролтой	10.0	45.7	34.9
Бүрэн бус дунд	28.0	25.8	26.5
Бүрэн дунд	26.0	9.5	14.5
Тусгай мэргэжлийн дунд/ ББД	18.0	14.7	15.7
Дээд	18.0	4.3	8.4
<b>Ажил эрхлэлтийн байдал</b>			
Ажилладаг/Хувиараа ажил			
эрхэлдэг	30.0	11.2	16.9
Мал малладаг	-	51.7	36.1
Сургуульд сурдаг	6.0	0.9	2.4
Тэтгэвэрт	48.0	22.4	30.1
Тахир дутуугийн группт	4.0	0.9	1.8
Гэрийн ажилтай	2.0	12.9	9.6
Ажилгүй	10.0	-	3.1
<b>Нэг орход ажиллаж буй хүүхдийн тоо</b>			
1	72.0	73.3	72.9
2	18.0	22.4	21.1
3 ба түүнээс олон	10.0	4.3	6.0
<b>Бүгд</b>			
<b>Ажил олгогчийн тоо</b>	100.0	100.0	100..0
	50	116	166

Зураг 6.2-т тухайн өрхөд ажиллаж буй хүүхдийн хамаарлыг байршилаар харуулав.



Нийт ажил олгогчдын 37.3 хувь нь ач/зээгээ, 34.3 хувь нь бусад хамаатнаа, 21.7 хувь нь хамаатан бус хүүхдүүдийг, 6.7 хувь нь төрсөн дүүгээ өөрийн өрхдөө ажиллуулж байна. Ажил олгогчдын насны бүтэц нэлээд хөгшин гарсантай холбоотойгоор төрсөн дүүгээ ажиллуулж буй байдал хамгийн бага байна. Хөдөөд мал малдах ажилд ач/зээгээ, хотод гэрийн ажилд бусад хамаатны хүүхдүүдийг туслацуулж буй ажил олгогчид хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Ажил олгогчдын өрхийн орлогын гол эх үүсвэрэйг Зураг 6.3-д харуулав.



Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 38.6 хувийнх нь өрхийн орлогын голлох эх үүсвэр нь ХАА-н үйлдвэрлэлийн орлого байхад, 35.5 хувийнх нь орлогын голлох эх үүсвэр тэтгэвэр тэтгэмж байна. Харин мөнгөн тусlamж/түрээс/бэлэг/хүүгийн орлого өрхийн орлогын дийлэнхийг бүрдүүлдэг гэж хариулсан ажил олгогчдын хувь хамгийн бага буюу срдөө 2 хувийг эзэлж байна.

Орлогын гол эх үүсвэрүүдийн ялгаа нь байрилаар илүү тод харагдаж байлаа. (Хүснэгт 6.3)

#### *Өгүйдлийн 6.3. Ажил олгогчийн хувийн жин, орлогын гол эх үүсвэр, байрилаар*

Ажил	<i>Төлөөлөх</i>						Ажил олгогчийн тоо
	Цалин	Тэтгэвэр тэтгэмж	Мөнгөн тусlamж /түрээс/бэлэг/хүүгийн орлого	Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээний орлого	ХАА-н үйлдвэрлэл ийн орлого	<i>Ажил</i>	
<i>ОТД</i>	24.0	58.0	6.0	12.0	-	100.0	50
Хөдөө	7.8	25.8	-	11.2	55.2	100.0	116
<i>Ажил</i>	12.7	35.5	1.8	11.4	38.6	100.0	166

Хөдөөгийн бараг бүх өрх малтай (96.6 хувь), дийлэнх хүн ам нь мал маллаж байгаатай холбоотойгоор тэдгээр ажил олгогчдын талаас илүү хувь нь (55.2 хувь) ХАА-н үйлдвэрлэлийн орлогоор аж төрж байна. Харин хотод, тэтгэвэрт байгаа ажил олгогчдын хувь хамгийн өндөр байгаа нь тэтгэвэр/тэтгэмжээр голлох эх үүсвэрээ болгож буй ажил олгогчдын хувийн жин өндөр гарахад нөлөөлжээ. Мөн хотод ажил эрхлэлтийн түвшин хөдөөгийнхөөс өндөр байгаатай холбоотойгоор гэрийн үйлчилгэч хүүхдүүдэд ажил олгогчдын 24 хувийнх нь голлох эх үүсвэр цалин байна. Хөдөөд мөнгөн тусlamж /түрээс/бэлэг/хүүгийн орлогоор аж төрдөг ажил олгогч/өрх огт байхгүй байхад энэ нь хотын нийт ажил олгогчдын 6 хувийнх нь орлогын гол эх үүсвэр болж байна. Энэ нь хөдөөг бодвол хотод байр/сууцаа түрээслэх, гадаадаас мөнгөн гүйвуулга хүлээн авах зэрэг боломж өндөр байгаатай холбоотой болов уу.

Ажил хийж буй хүүхдүүдийн тоо өрхийн шинж байдлын зарим үзүүлэлтээс хэрхэн хамаарч байгааг Хүснэгт 6.4-д харуулав.

*Ожлыгийн* 6.4 Ажил олгогчийн хувийн жин, нэг өрхөд ажиллаж буй хүүхдийн тоо, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлт	Ажиллаж буй хүүхдийн тоо			Бүгд	Ажил олгогчийн тоо
	1	2	3 ба түүнээс дээш		
<b>Ажил олгогчийн өрхөд амьдарч байгаа хүний тоо</b>					
1-3	82.3	14.5	3.2	<b>100.0</b>	<b>62</b>
4-5	70.7	24.0	5.3	<b>100.0</b>	<b>75</b>
6 ба түүнээс дээш	58.6	27.6	13.8	<b>100.0</b>	<b>29</b>
<b>Ажиллаж буй хүүхдийн хамаарал</b>					
Ач/зээ	71.0	24.2	4.8	<b>100.0</b>	<b>62</b>
Төрсөн дүү	63.6	27.3	9.1	<b>100.0</b>	<b>11</b>
Бусад хамаатан	70.2	22.8	7.0	<b>100.0</b>	<b>57</b>
Хамаатан бус	83.3	11.1	5.6	<b>100.0</b>	<b>36</b>
<b>Ажиллаж буй хүүхэд ажил олгогчийнд амьдардаг эсэх</b>					
Тийм	73.6	22.0	4.4	<b>100.0</b>	<b>91</b>
Үгүй	72.0	20.0	8.0	<b>100.0</b>	<b>75</b>
<b>Ажиллаж буй хүүхэд ажил олгогчийнд амьдардаггүй өрхтэй харьцуулахад ялимгүй бага үзүүлэлт</b>	<b>147.0</b>	<b>177.8</b>	<b>224.2</b>		
<b>Бүгд</b>	<b>72.9</b>	<b>21.1</b>	<b>6.0</b>	<b>100.0</b>	<b>166</b>

\*Тэмдэглэл-Зөвхөн малтай өрхүүдийн хувьд бодогдсон

Ажиллаж буй хүүхэдтэй хамааралгүй ажил олгогчдын тухайд, нэг хүүхэд ажиллуулж буй хувь бусдаас 12.2-19.7 пунктээр өндөр байна. Ажил хийж буй хүүхэд ажил олгогчийнд амьдарч буй өрхүүдийн 4.4 хувь нь 3 ба түүнээс олон тооны хүүхэд ажиллуулж байгаа ба энэ хувь ажиллаж буй хүүхэд ажил олгогчийнд амьдардаггүй өрхтэй харьцуулахад ялимгүй бага үзүүлэлт байна.

Харин хөдөөгийн өрхүүдийн эдийн засгийн байдлыг тодорхойлогч үзүүлэлт болох дундаж малын тоо болон өрхөд ажиллаж буй хүүхдийн тооны хооронд шууд хамаарал ажиглагджээ. Өөрөөр хэлбэл, малын тоо нэмэгдэхийн хэрээр ажил олгогчид мал маллах ажилд илүү олон хүүхэд туслуулах хандлагатай байна.

## 6.2. Ажил олгогчийн зүгээс хүүхдийн ажлыг үнэлж буй байдал

### 6.2.1 Ожлыгийн зүгээс хүүхдийн ажлыг үнэлж буй байдал

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 23.5 хувь нь хүүхдийн ажлын хөлсийг бэлэн мөнгөөр, 74.7 хувь нь мөнгөн бус хэлбэрээр төлж байна. Харин хүүхдэд ямар нэгэн ажлын хөлс/урамшуулал олгодоггүй ажил олгогчид 1.8 хувийг (3 ажил олгогч) эзэлж байна. Эдгээр ажил олгогчдын 2/3 нь төлбөрийн чадваргүй улмаас, 1/3 нь хөлс өгөх шаардлагагүй учраас хүүхдэд ямар нэгэн урамшуулал, хөлс өгдөггүй гэж хариулсан байна.

*Одийн 6.5 Ажил олгогчийн хувийн жин, ажлын хөлсийг төлж буй байдал, шинж байдлын сонгосон үзүүлэлтээр*

Шинж байдлын сонгосон үзүүлэлт	Ажлын хөлсийг төлж буй байдал				Ажил олгогчийн тоо
	Бэлэн мөнгөөр	Мөнгөн бусаар	Тооцдоггүй	Бүгд	
<b>Байршил</b>					
Хот	28.0	70.0	2.0	100.0	50
Хөдөө	21.6	76.7	1.7	100.0	116
<b>Ажиллаж буй хүүхдийн тоо</b>					
1	24.8	72.7	2.5	100.0	121
2	22.9	77.1	-	100.0	35
3 ба түүнээс олон	10.0	90.0	-	100.0	10
<b>Ажиллуулж буй хүүхэд ажил олгогчийнд амьдардаг эсэх</b>					
Тийм	22.0	74.7	3.3	100.0	91
Үгүй	25.3	74.7	-	100.0	75
<b>Бүгд</b>	<b>23.5</b>	<b>74.7</b>	<b>1.8</b>	<b>100.0</b>	<b>166</b>


Хүснэгт 6.5-аас харахад, хотод хүүхдийн ажлын хөлсийн бэлэн мөнгөөр тооцож буй ажил олгогчийн хувь хөдөөгийн мөн ажил олгогчийн хувиас 6.4 пунктээр өндөр, харин хөдөөд мөнгөн бус хэлбэрээр ажлын хөлсийг тооцож буй ажил олгогчдын хувь хотынхоос 6.7 пунктээр өндөр байна. Хөдөөгийн ажил олгогчид хотынхтой харьцуулахад байнгын мөнгөн орлогын эх үүсвэртэй байдаггүйтэй холбоотойгоор хүүхдэд бэлэн мөнгө өгөхөөсөө илүү хоол хүнсний зүйл, хувцас мал зэрэг мөнгөн бус хэлбэрээр ажлын хөлсийг олгодог байж болох юм.

З 3 ба түүнээс олон хүүхэд ажиллуулж буй ажил олгогчдын тухайд хүүхдэд мөнгөн бус хэлбэрээр ажлын хөлсийг нь тооцож буй байдал хамгийн өндөр байлаа. Ажиллуулж буй хүүхэд ажил олгогчийнд амьдарч буй тохиолдолд түүний ажлын хөлсийг тооцохгүй байх магадлал арай илүү байна.

Зураг 6.4-д ажиллаж буй хүүхдийн хамаарлыг хүүхдэд төлж буй ажлын хөлсний хэлбэрээр харуулав.

Хүүхдэд ажлын хөлсийг мөнгөн бус хэлбэрээр төлж буй ажил олгогчдын 43.5 хувь нь ач/зээ нараа ажиллуулж буй ажил олгогчид байлаа. Харин хамаатан бус хүүхэд ажиллуулж буй ажил олгогчдын тухайд ажлын хөлсийг төлдөггүй явдал гарсангүй.

**Соодаа 6.4 Ажил олгогчийн хувийн жин, ажиллуулж буй хүүхдийн хамаарал, ажлын хөлс төлж буй хэлбэрээр**



Хүснэгт 6.6-д хүүхдэд төлж буй урамшуулал/хөлсний хэлбэрийг ажил олгогчийн хүн ам зүйн шинж байдлаар харуулав. Хүүхдэд төлж буй урамшуулал/хөлсний хэмжээ нь тухайн ажил олгогчийн шинж байдлуудаар ялгаатай байна.

**Огийд 6.6 Хүүхдэд ажлын хөлс төлдөг ажил олгогчийн хувийн жин, ажлын хөлсний хэлбэр, ажил олгогчийн хүн ам зүйн шинж байдлаар**

Ажил олгогчийн хүн ам зүйн шинж байдал	Ажлын хөлсний хэлбэр			Бүгд
	Бэлэн мөнгөөр	Мөнгөн бусаар		
<b>Нас</b>				
34-өөс доош	23.1	22.5	22.3	
35-44	17.9	16.2	16.9	
45-54	15.4	14.5	15.1	
55-64	30.8	17.7	21.1	
65 ба түүнээс дээш	12.8	29.1	24.6	
<b>Хүйс</b>				
Эрэгтэй	38.5	39.5	39.8	
Эмэгтэй	61.5	60.5	60.2	
<b>Боловсролын түвшин</b>				
Огт боловсролгүй	5.2	8.9	8.4	
Бүрэн дунд ба түүнээс доош	61.5	69.3	67.5	
Бүрэн дундаас дээш	33.3	21.8	24.1	
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	
<b>Хүүхдэд ажлын хөлс төлдөг ажил олгогчийн тоо</b>	<b>39</b>	<b>124</b>	<b>163</b>	

Хүүхдийн ажлын хөлсийг бэлэн мөнгөөр тооцож буй ажил олгогчдын хамгийн өндөр хувийг 34-өөс доош болон 55-64 насны ажил олгогчид эзэлж байна. Эрэгтэй ажил олгогчидтой харьцуулахад эмэгтэй, огт боловсролгүй ажил олгогчидтой

харьцуулахад бүрэн дундаас дээш боловсролтой ажил олгогчид хүүхдэд бэлэн мөнгөөр ажлын хөлс, урамшууллыг илүүтэй олгож байна.

Ажил олгогчдоос хүүхдэд нэг сард төлж буй ажлын мөнгөн үнэлэмжийг авч үзэхэд, судалгаанд хамрагдсан нийт ажил олгогчдын 23.1 хувь 8000 хүртлэх, 28.2 хувь нь 8001-12000 төгрөгийн, 25.6 хувь 12001-20000 төгрөгийн, 23.1 хувь нь 20001 ба түүнээс дээш төгрөгийн хөлс/урамшууллыг өгдөг байна (Хүснэгт 6.7).

**Огийн 6.7 Бэлэн мөнгөөр ажлын хөлсийг тооцож буй ажил олгогчийн хувь, хүүхдэд төлж буй сарын ажлын хөлсний хэмжээ сонгосон үзүүлэлтээр**

Ажил олгогчийн өрхийн шинж байдал	Хүүхдэд сард төлж буй ажлын хөлсний хэмжээ				Бүгд	Бэлэн мөнгөөр ажлын хөлс төлж буй ажил олгогчийн тоо
	8000 хүртэл	8001-12000	12001-20000	20001 ба түүнээс дээш		
<b>Ажилшуулж буй хүүхдийн тоо</b>						
1	23.3	23.3	33.4	20.0	<b>100.0</b>	<b>30</b>
2 ба түүнээс дээш	22.2	44.4	-	33.3	<b>100.0</b>	<b>9</b>
<b>Байршил</b>						
Хот	14.3	21.4	28.6	35.7	<b>100.0</b>	<b>14</b>
Хөдөө	28.0	32.0	24.0	16.0	<b>100.0</b>	<b>25</b>
<i>Ажилшуулж буй хүүхдийн тоо</i>	<i>164.8</i>	<i>164.0</i>	<i>178.7</i>	<i>199.3</i>		
<b>Бүгд</b>	<b>23.1</b>	<b>28.2</b>	<b>25.6</b>	<b>23.1</b>	<b>100.0</b>	<b>39</b>

Хөдөөд хүүхдийн ажлын үнэлгээ хотынхтой харьцуулахад доогуур байгаа дүр зураг ажиглагджээ. Хотын ажил олгогчдын 64.3 хувь нь ажил хийж буй хүүхдэд сард 12000-аас дээш төгрөгийн хөлс өгдөг байхад, эсрэгээр хөдөөгийн ажил олгогчдын 60 хувь нь хүүхдэд сард 12000 төгрөгөөс дооши хөлс өгдөг байна.

Өрхийн дундаж малын тоо нэмэгдэхийн хэрээр хүүхдэд олгож буй ажлын хөлсний хэмжээ сөрөнхийдөө өссөн хандлагатай байна.

Судалгаанд хамрагдсан ажил олгогчийн мэдээллийн үзэхэд, тэд өдөр тутмын ажил/амьдралдаа өөр айлын хүүхэд туслалцуулсаныхаа төлөө хүүхдүүдэд сард дунджаар 18321 төгрөгийн хөлс өгдөг гэсэн тооцоо гарч байна. Гэхдээ ажил олгогч хүүхдэд төлж буй ажлын хөлсийг өсгөж мэдээлсэн байж болохыг анхаарах хэрэгтэй.

Эрэгтэй ажил олгогчидтой харьцуулахад эмэгтэй ажил олгогчид хүүхдүүдэд арай илүү урамшуулал/хөлс төлж байгааг Зураг 6.5-аас харж болно. Эрэгтэй ажил олгогчид ажил хийж буй хүүхдэд сард дунджаар 10800 төгрөг төлж байгаа нь эмэгтэй ажил олгогчдын хүүхдэд төлж буй ажлын хөлс/урамшууллаас 2.1 дахин доогуур үзүүлэлт байна.


Ажил олгогчдын боловсролын түвшин дээшилэхийн хэрээр хүүхдэд төлж буй ажлын хөлс/урамшууллын хэмжээ нэмэгдсэн, өөрөөр хэлбэл хүүхдийн ажлын үнэлэмж дээшилсэн хандлага ажиглагдаж байна. Дээд боловсролтой ажил олгогчид хүүхдэд сард дунджаар 34000 төгрөг төлж байгаа нь огт боловсролгүй болон бага боловсролтой ажил олгогчийн тогтоож буй хөлснөөс 3 дахин, дунджаас 1.6 дахин тус тус өндөр байна.



Тухайн ажил олгогчоос хүүхдэд төлж буй ажлын хөлсний сарын дундаж хэмжээ нь ажил олгогчийн сонгосон үзүүлэлтүүдээр ямар ялгаатай байгааг сонирхож үзье. (Зураг 6.6)

Өдөр тутмын ажил/амьдралдаа нэг хүүхэд туслуулж байгаа ажил олгогчид тухайн хүүхдэд сард 17917 төгрөгийн хөлс олгож байхад, 2 ба түүнээс дээш хүүхэд ажиллуулж буй ажил олгогчид хүүхдийн ажлын хөлсөнд сард дунджаар 19667 төгрөг төлж байна. Үүнээс харьцангуй боломжийн амьдралтай өрхүүд илүү олон хүүхэд ажиллуулах сонирхолтой байдаг, нөгөө талаас хүүхдийн ажлыг арай илүү үнэлдэг гэсэн дүгнэлтүүд гарч байна.

**Чөдлэх 6.6 Хүүхдэд олгож буй ажлын хөлсний сарын дундаж хэмжээ, сонгосон үзүүлэлтээр**




Өмнө дурьдсанчлан, хөдөөгийн ажил олгогчид хүүхдийн ажлыг доогуур үнэлж байгаа нь Зураг 6.6-аас батлагдаж байна. Хотын ажил олгогч ажил хийж буй хүүхдэд сард дунджаар 26143 төгрөг төлж байхад, хөдөөгийн ажил олгогчид түүнээс бараг 2 дахин бага хөлсийг төлж байна.

Өвөө/эмээ болон хамаатан бус ажил олгогчид хүүхдийн хөдөлмөрийг төрсөн ах/эгч болон ойрын биш хамаатнуудаас илүү үнэлж байна. Түүнчлэн ажил олгогчтой хамт амьран өрхийн өдөр тутмын гэрийн болон мал маллах ажилд тусалж буй хүүхдүүдийн ажлын үнэлгээ ажил олгогчтой хамт амьдраагүй боловч өрхийн гэрийн болон мал маллах ажилд тусалдаг хүүхдүүдтэй харьцуулахад илүү байлаа.

Судалгаанд хамрагдсан нийт ажил олгогчдын дийлэнх нь (74.7 хувь) хүүхдийн ажлын хөлсийг мөнгөн бус хэлбэрээр олгож байгаа тухай өмнө дурьдсан билээ. Ажил олгогчид хүүхдийн ажлын хөлсийг мөнгөн бус хэлбэрээр тооцоходоо ихэвчлэн хоол хүнсний зүйл болон хувцсаар төлөх тохиолдол хамгийн түгээмэл (харгалzan 79 ба 75.8 хувь) байхад, мал өгдөг, сургалтын төлбөр өгдөг тохиолдол хамгийн бага (харгалzan 6.5 ба 4.8 хувь) хувийг эзэлж байна.

Мөнгөн бусаар олгож буй ажлын хөлсний хэлбэрүүдийг байршилаар Зураг 6.7-д харууллаа.



Тэмдэглэл: Олон сонголтой асуултгаас тооцсон хувь

Хотод хүүхдийн ажлын хөлсийг хиччелийн хэрэгсэл авч өгч төлж буй ажил олгогчийн хувь хөдөөгийнхөөс 2.4 дахин өндөр байгаа нь хөдөөд айлд мал маллаж байгаа хүүхдүүд ихэвчлэн сургуулиас завсардсан эсвэл сургуульд сурдаггүй хүүхдүүд байдагтай холбоотой. Үүнээс хамааран хөдөөд хжлын хөлсөнд сургалтын төлбөр өгдөг ажил олгогчдын хувь хотынхоос бага байна.

Ажил олгогчид хүүхдэд ажлын урамшуулал/хөлсийг ямар хугацаанд өгдөгийг сонирхож үзэхэд, нийт ажил олгогчдын талаас илүү хувь нь (54.6 хувь) сараас дотогш хугацаанд үлдсэн хувь нь сараас дээш хугацаанд хүүхдэд ажлын хөлсийг олгодог ажээ. Хүүхдэд бэлэн мөнгөөр ажлын хөлсийг тооцож буй ажил олгогчдын хувьд сараар, мөнгөн бус хэлбэрээр тооцож буй ажил олгогчдын тухайд улирлаар ажлын хөлсийг төлөх явдал хамгийн өндөр хувийг эзэлж байна. (харгалзан 46.2 ба 45.2 хувь) Ач/зээгээ ажиллуулж буй ажил олгогчдын 2/3 орчим (62.4 хувь) нь хүүхдэд ажлын хөлсийг сараас дотогш хугацаанд төлдөг байхад, бусад хамаатнаа ажиллуулж буй ажил олгогчдын талаас илүү хувь нь (57.2 хувь) сараас урт хугацааны мөчлөгөөр хүүхдэд ажлын хөлсийг төлдөг байна.


### *6.2.2. Охиждээгээ азээгүйгээ аоёэ ааээдээ*

Тухайн өрхөд ажиллаж буй хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудлыг ажил олгогчид хэрхэн анхаарч байгааг тодруулах зорилгоор судалгаанд “Ажиллаж буй хүүхэд өвдөхөд та ямар арга хэмжээ авдаг вэ?” гэсэн асуултыг оруулсан юм. Энэхүү асуултын үр дүнг харахад, судалгаанд хамрагдсан нийт ажил олгогчдын 31.3 хувь нь тухайн өрхөд ажиллаж байсан хүүхэд ажил хийж байх хугацаандаа огт өвдөж

байгаагүй гэж хариулсан байна. Ажил олгогчийн өрхөд ажиллаж байсан хүүхэд өвдөхөд ажил олгогчдын 99.4 хувь нь ямар нэгэн байдлаар арга хэмжээ авсан байна. Эдгээрийн дотор эм авч өгөх (30.1 хувь), эмчид үзүүлэх (34.9) зэрэг арга хэмжээнүүд хамгийн өндөр хувийг эзэлж байлаа.

Ажил олгогчид өөр айлын хүүхдийг өдөр тутмын ажил/амьдралдаа туслуулж байгаагийн давуу болон сул талыг дараахь байдлаар тодорхойлж байна (Зураг 6.8 ба 6.9).


Зураг 6.8-аас харахад, хөдөөгөөс судалгаанд хамрагдсан ажил олгогчдын тухайд өөр айлын хүүхэд ажиллуулахын давуу тал нь амьдралд суралцаж, бие даах чадвартай болгож байгаад оршдог гэж хариулсан хувь (55.2 хувь) зонхицж байна. Томчуудыг бодвол дуулгавартай байдал нь хүүхэд ажиллуулахын бас нэг чухал давуу тал болж байна гэж нийт ажил олгогчдын 37.4 хувь нь хариулжээ.



Тэмдэглэл: Олон сонголттой асуултаас тооцсон хувь

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 68.1 хувь нь өөр айлын хүүхдийг гэрийн ажилдаа туслуулах/ажиллуулахад сул тал байдаггүй гэж хариулжээ. Зураг 6.9-өөс харахад, хөдөөгийн ажил олгогчдын 77.6, хотын ажил олгогчдын 46 хувь нь тус тус өөр айлын хүүхэд ажиллуулахад сул тал байхгүй гэсэн хариултыг өгсөн байна. Үүний дараагаар, хотын ажил олгогчдын тухайд өөр айлын хүүхдүүд ажилд өөриймсөг ханддаггүй, хөдөөгийн ажил олгогчдын хувьд ажлын туршилага багатай гэсэн шалтгаанууд орж байна.

*Соёдлэл 6.9. Ажил олгогчийн хувь, байршил, өөр айлын хүүхэд ажиллуулахын сүл талаар*



Тэмдэглэл: Олон сонголттой асуултаас тооцсон хувь

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх ажил олгогчдын мэдлэгийг хүүхэд хөдөлмөрийн харилцаанд орж болох хуулийн насыг тодорхойлсон байдлаар үнэлсэн юм. Монгол Улсын хөдөлмөрийн хуулинд 16 ба түүнээс дээш наасны хүүхдүүд хөдөлмөр эрхэлж болно гэж заасан байдаг. Иймээс хүүхэд хөдөлмөрийн харилцаанд орж болох хуулийн насыг 16 гэж хариулсан тохиолдолд зөв, бусад тохиолдолд буруу тодорхойлсон гэж үзлээ. Хүснэгт 6.8-д ажил олгогчид энэхүү насыг хэрхэн тодорхойлсоныг харуулав.

Судалгаанд хамрагдсан нийт ажил олгогчдын 31.9 хувь нь хүүхдүүд 16 нас хүрсэн тохиолдолд хөдөлмөр эрхэлж болно гэж хүүхдийн хөдөлмөр эрхэлж болох хуулийн насыг зөв тодорхойлсон байхад, 10 ажил олгогч тутмын 4 нь энэхүү насыг буруу тодорхойлжээ. Түүнчлэн Монгол Улсад хүүхдүүд хэдэн настайгаасаа эхлэн хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрдөг эсэхийг мэдэхгүй гэсэн хариултыг ажил олгогчдын 1/4-ээс илүү хувь нь өгсөнөөс үзэхэд, ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

*Өгүй 6.8 Ажил олгогчийн хувь, хүхэд ажил эрхэлж болох хуулийн насыг тодорхойлсон байдал, сонгосон үзүүлэлтээр*

Сонгосон үзүүлэлт	Хүхэд ажил эрхэлж болох хуулийн насыг тодорхойлсон байдал			Бүгд	Ажил олгогчийн тоо
	Зөв	Буруу	Мэдэхгүй		
<b>Ажил олгогчийн нас</b>					
34 хүртэлх	37.8	32.5	29.7	<b>100.0</b>	<b>37</b>
35-44	25.0	57.1	17.9	<b>100.0</b>	<b>28</b>
45-54	44.0	32.0	24.0	<b>100.0</b>	<b>25</b>
55-64	31.4	31.4	37.2	<b>100.0</b>	<b>35</b>
65 ба түүнээс дээш	24.4	43.9	31.7	<b>100.0</b>	<b>41</b>
<b>Ажил олгогчийн хүйс</b>					
Эрэгтэй	24.2	45.5	30.3	<b>100.0</b>	<b>66</b>
Эмэгтэй	37.0	35.0	28.0	<b>100.0</b>	<b>100</b>
<b>Боловсролын түвшин</b>					
ОГТ боловсролгүй/Бага	19.0	37.9	43.1	<b>100.0</b>	<b>58</b>
Бүрэн бус дунд	34.1	40.9	25.0	<b>100.0</b>	<b>44</b>
Бүрэн дунд	37.5	45.8	16.7	<b>100.0</b>	<b>24</b>
Техник мэргэжлийн	38.4	30.8	30.8	<b>100.0</b>	<b>26</b>
дунд/ББД					
Дээд	57.1	42.9	-	<b>100.0</b>	<b>14</b>
<b>Байршил</b>					
Хот	42.0	34.0	24.0	<b>100.0</b>	<b>50</b>
Хөдөө	27.6	41.4	31.0	<b>100.0</b>	<b>116</b>
<b>Бүгд</b>	<b>31.9</b>	<b>39.2</b>	<b>28.9</b>	<b>100.0</b>	<b>166</b>

45-54 насны ажил олгогчдын 44 хувь нь хүүхдийн хөдөлмөр эрхэлж болох насыг зөв тодорхойлсон нь бусад насны бүлгүүдээс, ялангуяа 65 ба түүнээс дээш насны бүлгийнхнээс өндөр хувийг эзэлж байна. Эрэгтэй ажил олгогчидтой харьцуулахад эмэгтэй ажил олгогчдын, хөдөөгийнхөнтэй харьцуулахад хотын ажил олгогчдын хуулийн мэдлэг илүү байна. Мөн ажил олгогчдын боловсролын түвшин дээшилэхийн хэрээр хүүхдийн хөдөлмөр эрхэлж болох насыг зөв тодорхойлсон хандлага ажиглагдажээ.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

“Гэрийн үйлчлэгч хүүхдүүдийн суурь судалгаа” нь айлд гэрийн үйлчлэгч болон айлд мал маллаж буй хүүхдүүдийн тоо, тархалт, шинж байдал, хөдөлмөрийн нөхцөл байдлыг илрүүлэн харууллаа. Түүнчлэн тэдгээр хүүхдүүдийн эцэг эх болон хүүхдүүдийг ажиллуулж буй ажил олгогчдын хүүхдийн хөдөлмөрийн асуудлаархи байр суурь, хандлагыг тодорхойлов.

Судалгаагаар дараахь ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. 2001 онд хийгдсэн судалгаагаар<sup>19</sup> өөрийн өрхөөс гадуур, айлд мал маллаж буй хүүхдүүдийн 20 хувь нь хамаатан бус айлд ажиллаж байна гэсэн үр дүн гарсан. Энэхүү судалгаагаар айлд ажиллаж буй хүүхдүүдийн 30 орчим хувь нь хамаатан бус айлд ажиллаж байгаа үр дүн гарсан нь хүүхдүүд айлд хөлсөөр ажиллах явдал нэмэгдэж ирсэнийг харуулж байна. Өнгөрсөн хугацаанд хүн амын доторх амьжирагааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой ядуу өрхийн хувийн жин буураагүй бөгөөд цаашид ядуурлын түвшин буурахгүй бол хүүхдүүд айлд хөлсөөр ажиллах явдал нэмэгдэх хандлагатай байна.
2. Айлд мал маллаж буй хүүхдүүд гэрийн үйлчилгээний ажилд илүү их цагийг зарцуулж байгаа үр дүн гарсан тул хөдөөд айлд мал маллаж буй хүүхдийг гэрийн үйлчлэгчийн ажлыг давхар эрхэлж байна гэж үзэх үндэслэлтэй байна. Түүнчлэн, зарим эцэг, эхчүүд уламжлалт мал аж ахуйн үйл ажиллагаанд илүүтэй анхаарснаас хүүхдийнхээ боловсролын асуудлыг орхигдуулах явдал байсаар байна. Иймд хүүхдийн эдийн засгийн бус үйл ажиллагааг цаашид судлах шаардлагатай байна.
3. Айлд ажиллаж буй 6-11 насны хүүхдүүдийн нөхцөл байдал бусад насны бүлгийн хүүхдүүдтэй харьцуулахад хамгийн их анхаарал татаж байна. Бага насны хүүхдүүд нэн тэргүүнд эцэг эхийн анхаарал, халамж, хамгаалал дор байх ёстой. Айлд ажиллаж, эсвэл амьдарч ажиллаж байгаа бага насны хүүхдүүд тухайн айлын эздийн бүрэн хараа хяналт дор илүүтэй байх нь гарцаагүй. Энэ насны хүүхдүүдийн хувьд сургуульд суралцах ёстой эрхээ тэр бүр мэддэггүй, эцэг эхийн зүгээс шаардан ажиллуулах явдал түгээмэл, ажлын ачааллаас болж ядрах, мөн өвчлөх, хангалттай хоол хүнс хэрэглэдэггүй, ажлын хөлс хамгийн бага, дулаан хувцас хунаргүй зэрэг нөхцөл байдал хамгийн түгээмэл илэрсэн нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй нөхцөл айлд ажиллаж буй бага насны хүүхдүүдийн хувьд бий болжээ гэж дүгнэхээр байна. Хөдөлмөрийн хууль, тогтоомжоор бага насны хүүхдүүд хөлсний хөдөлмөр эрхлэхийг хориглосон хэдий ч асуудал хуулийн хэрэгжилт, хяналтад багтаж байна. Тиймээс бага насны хүүхдийг хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хөндийрүүлэх ажилд нэн тэргүүнд анхаарлаа хандуулах, энэ ажлыг орон нутгийн засаг захиргааны зүгээс хүүхдүүдийг сургуульд зайлшигүй хамруулах зорилт, үйл ажиллагаатай уялдуулах замаар хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

<sup>19</sup> Айлд мал маллаж буй хүүхдүүдийн нөхцөл байдал, 2001, Нийгмийн хөгжлийн төв (Судалгаанд Өвөрхангай, Ховд аймаг хамрагдсан)

4. Айлд ажиллаж буй хүүхдүүдийн хувьд айлын эзэн/эзэгтэйд хэл амаар доромжуулах, зодуулах, ажлын ачаалал хэт ихээс ядрах зэрэг бэрхшээлүүд тохиолддог, ялангуяа охидын хувьд гэрийн эзэд архи уун дарамтлах, оролдох зэргээр хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх эрсдэл бага ч гэсэн байгааг судалгааны үр дүн харууллаа.
5. Айлд ажиллаж буй хүүхдүүдийн хотод тал хувь нь, хөдөөд 30 хувь нь өвөө эмээ, төрсөн ах эгчийндээ ажиллаж байна. Харин 15-17 насны хүүхдүүдийн хувьд тэдний дийлэнх нь хот, хөдөөд ялгаагүйгээр өвөө эмээ, төрсөн ах эгчийнхээсээ бусад өрхөд ажил эрхэлж байна. Ажлын хөлсөө мөнгөн хэлбэрээр авч буй хүүхдүүдийн тодорхой хувь нь тухайлбал, хотод хүүхдүүдийн 34 хувь нь төрсөн ах эгч, өвөө эмээгийндээ ажиллаж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцид өөрийн өрхдөө ажиллаж буй хүүхдүүдэд насны доод хязгаар хамаarahгүй байж болохыг заасан байдаг. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд "гэр бүл" гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг; "гэр бүлийн гишүүн" гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг багтахыг заасан бөгөөд эндээс тусдаа амьдарч буй төрөл, садангийн хүмүүсийг гэр бүлийн гишүүдэд тооцохгүй байх үндэслэл гарч ирж байна. Үүнтэй холбоотойгоор төрсөн ах дүү, эмээ өвөө, бусад хамаатныдаа ажиллаж буй хүүхдүүд өөрийн өрхөөс гадуур өөр өрхөд ажиллаж байна гэж үзэх үндэслэл мөн урган гарч байна. Гэвч өөрийн төрсөн ах дүү, өвөө эмээдээ туслах, хөдөөд тухайлбал төрсөн ах эгчийндээ байгаа өөрийн малыг маллаж буй хүүхдүүдийг хөдөлмөрийн харилцаа үүсгэн ажиллаж байна гэж үзэх, өөрөөр хэлбэл, төрсөн ах эгч, өвөө эмээг ажил олгогч гэж үзэх үндэслэл нь хүн амын нийтээр хүлээн зөвшөөрсөн уламжлалт практиктай зөрчилдөж байгаа тул тийнхүү үзэх боломжгүй юм.

Гэвч хүүхэд суурь боловсрол эзэмших насандaa сургууль завсардан ажил эрхэлж байвал хаана ажиллаж байгаагаас үл хамааран хүүхдийн эрх зөрчигдэж байна гэж үзэн, хүүхдийг боловсрол эзэмших эрхийг нь хэрэгжүүлэх шаардлагатайг олон улсын болон үндэсний хууль, тогтоомжид тусгасан байдаг. Өөрийн өрхөөс гадуур, өөр өрхөд ажиллаж буй хүүхдүүдийн боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтийн байдал, ажлын нөхцлийн талаар судлахад хотод төрсөн ах эгч, өвөө эмээгийндээ ажиллаж буй хүүхдүүдийн 80 хувь, хөдөөд 50 хувь нь сургуульд сурч байна. Тиймээс хүүхдийн ах эгч, өвөө эмээдээ тусалж буй ажил хүүхдийг сургуульд суралцахгүйд хүргэж байгаа, ялангуяа энэ нь хөдөө орон нутагт илүү түгээмэл байгаа асуудлыг хүүхдийн хөдөлмөрийг устгах зорилтын хүрээнд зайлшигүй хөндөх хэрэгтэй гэж үзэж байна. Тиймээс цаашид ч айлд ажиллаж буй хүүхдүүдийн талаарх судалгаанд төрсөн ах эгч, эмээ өвөөгийндөө ажиллаж буй хүүхдүүдийг оролцуулан судлах нь зүйтэй.

6. Гэрийн үйчилгээний ажил хийлгэх, малаа маллуулах зорилгоор өөр айлын хүүхэд ажиллуулж буй, хүүхдийн төрсөн ах эгч, өвөө эмээгээс бусад этгээдийг ажил олгогч хэмэн үзэж, энэ хүрээнд тодорхой үүрэг, хариуцлага хүлээлгэх, тухайлбал

бага насны хүүхдийг ажиллуулахгүй байх, гэрээ байгуулах, хийсэн ажилд нь тохирсон, хөлсийг хууль тогтоомжид нийцүүлэн олгох, хүүхдийн боловсрох эзэмших эрхийг хүлээн зөвшөөрөх, эрүүл мэндийг нь хамгаалах, хүүхдийг бисийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтаас хамгаалах үүргийг хүлээлгэх шаардлагатай байна.

7. Хүүхдүүдийн дийлэнх нь, ялангуяа өсвөр насны хүүхдүүд цаашдаа гэрийн үйлчилгээ, мал аж ахуйн ажлаа үргэлжлүүлэн эрхлэх сонирхолтой байна. Айлд гэрийн үйлчилгээ, мал аж ахуйн ажлыг хөлсөөр хийж буй насанд хүрсэн хүмүүсийн талаар судлагдаагүй байгаа хэдий ч цаашид хөлсний хөдөлмөрийн энэ хэлбэр улам нэмэгдэх хандлагатай байгааг анхааралдаа авч олон нийтийн хараа хяналтаас далд ажиллаж байгаа хүүхэд болон насанд хүрсэн хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт, хяналтыг боловсронгуй болгож, хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:
  - a. Айлд хөлсөөр ажиллахтай холбогдуулан хөдөлмөрийн харилцаа үүсгэх, гэрээ байгуулан эрх үүрэг хүлээх эрх зүйн орчныг Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хүрээнд боловсронгуй болгох;
  - b. Айлд хөлсөөр гэрийн үйлчилгээ, мал маллах ажлын эрэлт, ажиллах хүчиний хангалтыг хөдөлмөр зуучлалын ажлын хүрээнд оруулах, ингэснээр хөдөлмөрийн насанд хүрээгүй хүүхдүүд төрсөн ах дүү, өвөө эмээгийндээ туслах зорилгоор ажиллахаас бусад нөхцөлд өөр айлд хөлслөн ажиллуулах явдлыг халаад чиглэсэн хяналтыг сайжруулах;
  - c. Айлд ажиллаж байгаа хүүхдүүдийг бүртгэлжүүлэх, үүний дагуу хороо, сумын нийгмийн ажилтнуудын зүгээс тавих анхаарлыг сайжруулах, ажил олгогчийн хүүхдийн эрхийг хангах үүргийг өндөржүүлэхэд тавих хяналтыг сайжруулах;
  - d. Түүнчлэн айлд ажиллаж байгаа хүүхдүүдийн эрхийн хэрэгжилтийн байдалд мониторинг хийхэд төрийн бус байгууллагуудын оролцоог дээшлүүлэх, энэ чиглэлээрх санал санаачилгыг дэмжих;
  - e. Хүүхдийн эрх, холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалтуудыг ажил олгогчид болон хүүхдүүд, тэдний эцэг эхэд хүргэх;
8. Айлд ажиллаж байгаа 7-15 насны хүүхдүүд, ялангуяа хөдөөгийн хүүхдүүдийн сургуульд хамрагдарт улсын дундажтай харьцуулахад маш доогуур, бичиг үсэггүй хүүхдийн хувь ялангуяа хөдөөд маш өндөр байна. Мөн Улаанбаатарт шилжин ирсэн хүүхдүүдийн тал хувь нь сургуульд суралцахгүй байна. Айлд ажиллаж буй хүүхдүүдийн суурь боловсрол эзэмших эрх хэрэгжихгүй байна. Тиймээс сум, дүүргийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага сургуулийн гадна байгаа хүүхдүүдэд боловсрол нөхөн олгох сургалтын хамрах хүрээг өргөтгөх, үүнд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг хамруулах талаар тодорхой анхаарал хандуулах, сургуулийн гадна байгаа хүүхдүүдийг сум, хорооны нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллах замаар тодорхойлон боловсрол нөхөн олгох

сургалтанд хамруулах, албан бус боловсролын асуудал хариуцсан ажилтан, нийгмийн ажилтнуудын ажлын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

9. Засгийн Газраас олон хүүхэдтэйн тэтгэмжийг 3 ба түүнээс дээш хүүхэдтэй ядуу өрхөд олгох журамд хүүхдийг хүнд тэвчишигүй хөдөлмөр эрхлүүлэхгүй байх нөхцөл оруулсантай холбогдуулан төрсөн ах дүү, өвөө эмээгээс бусад айлд ажиллаж байгаа, түүнчлэн сургууль завсардсан, бага насын хүүхдүүдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, сургуульд суралцуулах шаардлагыг тавьж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.
10. Айлд ажиллаж буй 10 хүүхэд тутмын нэг хот, хөдөөд ялгаагүй иргэний бичиг баримтгүй, эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь нас ахих тусам буурч байна. Иргэний бичиг баримт нь хүүхдүүд нийгмийн үйлчилгээ хүртэх чухал угтвар нөхцөл тул сум, дүүргийн засаг захиргааны зүгээс хөдөлмөр эрхэлж буй болон бусад хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн иргэний бичиг баримтын бүрдэлтийн байдалд үзлэг хийж, бичиг баримтжуулах ажлыг эцэг эхийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, хүүхэд эцэг эхчүүдэд шаардлагатай дэмжлэг туслацаа үзүүлэх хэрэгтэй байна.
11. Айлд гэрийн үйлчлэгч хийж байгаа, мал маллаж байгаа хүүхдүүдийн талаарх олон нийтийн ойлголтыг дээшилүүлэх, хүүхдийн энэхүү далд хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль эрх зүйн мэдлэгийг дээшилүүлэх чиглэлээр ухуулга сурталчилгааны ажлыг өрнүүлэх хэрэгтэй байна.

## СУДАЛГААНД ОРОЛЦОГСОД

**Зохицуулагч:**

А. Солонго

ХАССТ-ийн захирал, ЭЗС, МУИС

**Техникийн зөвлөх:**

Санжукта Мухаржи

Суурь судалгааны мэргэжилтэн, АЙПЕК, Бангкок

**Судлаачдын багийн гишүүд:**

А. Солонго

ХАССТ-ийн захирал

Т. Навч

ХАССТ-ийн ахлах багш/судлаач

Б. Мөнхжаргал

ХАССТ-ийн багш/судлаач

Б. Нарантулга

ХАССТ-ийн судлаач

Б. Наранчимэг

ХАССТ-ийн судлаач

Б. Эрдэнэсувд

ХАССТ-ийн судлаач

**Сургагч:**

Т. Навч

ХАССТ-ийн ахлах багш/судлаач

**Ярилцлага авагчид:**

Ш. Чимэдцэрэн

Монголын Хүн ам ба Хөгжил нийгэмлэгийн ажилтан

Д. Зүмпэрэлмаа

МУИС-ийн ЭЗС-ийн магистрант

Л. Мөнх-Од

МУИС-ийн ЭЗС-ийн магистрант

Б. Анужин

МУИС-ийн НС-ийн магистрант

Б. Сансармаа

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

Н. Анарноров

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

Ц. Цэцэгтуяа

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

Д. Жаргалсүрэн

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

Э. Энхболд

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

Б. Одончимэг

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

А. Сэлэнгэ

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

Б. Ганбаяр

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

С. Гэрэлмаа

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

Д. Нарантуяа

МУИС-ийн ЭЗС-ийн оюутан

**Тайланг англи хэлийн орчуулсан**

Э. Сайнбилиг

ЭЗС-ийн Англи хэлний тэнхмийн эрхлэгч